

ALADDIN CLASSICS

\* Jack London \*



INCLUDES  
READING GROUP  
GUIDE

*The* Call  
*of the* Wild

With a foreword by Newbery author Gary Paulsen

## Уншигч Танаа!

Америкийн нэрт зохиолч Жек Лондон (1876-1916) амьтдыг дүрсэлсэн дэлхийн уран зохиолын дээжис болон алдаршсан энэ тууждаа зоригт, ухаантай Бэк нохой хүний халуун хайр энхрийлэлд бүүвэйлэгдэж байсан зөөлөн уур амьсгалтай Өмнөд нутгаас алтанд амиа тавьж аз туршсан шуналтай хүмүүсийн гарт орж эрчилгүй Умард нутгийн хахир хүйтэнд хаягдан цэвдэг дотортой хүмүүсийн гар дамжин зүйргүй их зовлон зүдгүүр гэтлэн амьдрахын төлөө нугаршгүй тэмцлийн учрыг биеэр амсан мэдэрч байгааг үзүүлжээ. Тэрчилэн амьтай голтой бүхнийг өрөвдөн хайрлах сэтгэлээ таягдсан этгээд хүн гэдэг эрхэм нэр, мөн чанараа алддагийг, мөн нохой шударга, сайхан сэтгэлтэй хүнд татагдан түүний дотнын анд, үнэнч туслагч нь болж чаддагийг харуулсан байна. Энэ туужид нохойны зан авирыг янз бүрийн нөхцөл байдалд атаархам чадварлаг дүрслэн гаргажээ.

Уг тууж нь хүний оюуны болон биеийн чадвар шавхагдашгүй хийгээд амьтдыг ямагт хайрлаж, хүнлэг ёсоор хандаж байхын чухлыг сургамжилжээ.

Монголын уншигчид Ж.Лондоны "Цагаан соёо", "Нүүрэндээ сорвитой хүн", "Амьдралыг хайрлах ухаан", "Догшин араатан", "Сарны хөндий" зэрэг шилдэг бүтээлүүдийг нь эх хэлээрээ амтархан уншдаг билээ.

## **Нэгдүгээр бүлэг**

### **Балар цагийн амьдралд эргэн очсон нь**

Эрин зууны дадал заншлын гинжийг  
Эртний тэнүүлч угийн авъяас элээнэм  
Их нойрноос сэрсэн араатан  
Ичээнээсээ дахин гарч байнам

Бэк сонин уншиж чаддаггүй болохоор ганц өөрт нь биш, Пьюжет-Саундын булангаас Сан-Диего боомт хүртэлх өргөн уудам нутаг дахь чийрэг, шөрмөслөг, урт өтгөн үстэй бүх нохойг ямар аюул нөмрөх гэж буйг огт мэдсэнгүй.

Умард туйлын харанхуй манан дундуур тэмтчин явсан хүмүүс шар төмөр олсноос хөлөг онгоц, тээврийн пүүсүүд тэр олзны тухай мэдээг газар сайгүй түгээн тарааж олон мянган хүн Умар зүг тэмцэн цутгах болсноос хамаг явдал гарчээ. Тэр хүмүүст нохой хэрэгтэй байж тэгэхдээ хүнд ажилд таарах чийрэг чанга мах булчинтай, умард нутгийн тачигнасан хүйтнийг тэсвэрлэх өтгөн саглагар үстэй сайн үүлдрийн ноход хэрэгтэй болжээ.

"Миллер шүүгчийн эдлэн газар" хэмээх Сант-Кларагийн нарлаг хөндий дэх том байшинд Бэк нохой амьдардаг ажээ. Замаас зайдуухан модон дотроос цухуйж байгаа байшингийн дөрвөн талд барьсан уужим сэрүүн тагт л мөчрийн цаанаас үзэгдэнэ. Хайрга асгасан нарийн зөрөг зам мөчир нь ширэлдсэн өндөр улиангарын ёроолоор ойн цоорхой дундуур байшин руу оджээ. Байшингаас цааш газар нь уужимсаж тэнд байдаг адууны хашааны дотор агтач дагалдан нар нийт арваад хүн ажиллах агаад зарц нарын усан үзмийн мод сүлжиж хийсэн олон жижиг байшин эгнэж аж ахуйн зориулалттай янз бүрийн барилгууд нарийн цэгцтэй ярайж цаахна нь усан үзмийн талбай, билчээр, жимсний цэцэрлэг ногоорон үргэлжилнэ.

Тэнд бас оргилуур, худгийн ус сорох хөөрөгний төхөөрөмж, шүүгчийн хөвгүүд өглөө бүр, өдрийн төөнөм халуунд шумбан сэрүүцдэг том усан сан бий.

Бэк нохой энэхүү уужим эдлэн газрыг ноёрхон дураараа сэлгүүцэнэ. Энд төрж торниод дөрөв дэх жилийнхээ нүүрийг үзэж яваа ажээ. Ийм том эдлэн газарт мэдээжээр өөр олон нохой байдаг боловч тэднийг тоодоггүй ажээ. Янз бүрийн нохой үзэгдсэнээ алга болно, тэд хавчиг хэвтэрт амьдарна. Бээжин хав Тутс, үсгүй шахам мексик үүдрийн Изабель гэх мэтийн болхи амьтад гадагшаа хааяа нэг хоншоороо цухуйлгаж цэцэрлэгт юм уу хашаанд гардаг байлаа. Түүнчлэн хориос цөөнгүй фокстерьер нохой бий. Шалны сойз, шүүрээр зэвсэглэсэн бөөн шивэгчнүүдээр хамгаалуулан зоригжсан Тутс, Изабель хоёрыг цонхоор цухуйхад Бэк заналхийлан хуцна.

Бэк бол гэрт ч байдаггүй, нохойны хороонд ч байдаггүй, харин эдлэн газрын бүрэн эрхт эзэн аж. Хүссэн цагтаа усанд шумбан сэлнэ, шүүгчийн хөвгүүдтэй анд явна, Молли, Алиса гэдэг хоёр охиныг нь оройн бүрэнхийд эсвэл өглөө эрт салхинд зугаалахад нь дагаж явна. Өвлийн урт үдэш номын санд гал улалзан буй задгай пийшингийн өмнө суугаа эзнийхээ хөлд тухтайяа хэвтэнэ. Тэрчлэн шүүгчийн ач нарыг унуулаад давхиж тэдэнтэй цуг зүлгэн дээр хөрвөөн ноцолдоно, тэднийг хойд хашааны усан оргилуур, түүнээс бүр цаана билчээр, жимсний цэцэрлэгийн тэнд дүрсгүйтэн болчимгүй хэрэг үйлдэхээс нь хамгаалж сэргийлнэ.

Бэк нохой олон фокстерьер нохойны хажуугаар ихэмсэг, бардам алхан өнгөрнө, Тутс, Изабель хоёрыг нүдний үзүүрээр ч гоож харахгүй. Бэк бол хаан, Миллер шүүгчийн эдлэн газрын мөлхдөг, нисдэг бүгдийн тэр дундаа хүмүүсийнх нь ч хаан билээ.

Лагс том биетэй сенбернар үүлдрийн Элмо хэмээх эцэг нь олон жилийн турш шүүгчийн салшгүй дагуул явсныг Бэк ч бас нэр төртэй залгамжлах нь дамжиггүй байв. Эх нь Шеп хэмээх нэртэй Шотланд үүдрийн хоньч нохой тул Бэк эцэг лүгээ адил лагс том биш дөнгөж зуун дөчин фунт<sup>1</sup> жин татна. Гэхдээ нэг зуун дөчин фунт жингийн зэрэгцээ цатгалан танхил амьдрал, нийтийн хүндэтгэл зэргээс чанар чансаагаа ойлгож вангийн байдалтай байх боломжтой болжээ.

Гөлөг байхаасаа эхлэн Бэк дөрвөн жилийн турш баян хангалуун сурвалжтан шиг амьдарч бардам додигор тэр ч байтугай эдлэн газартаа шигдэн зожиг суудаг зарим сурвалжит тайж шиг ялимгүй аминчхан ажээ. Гэхдээ гэрийн тэжээмэл эрх танхи нохой болоогүй нь түүний аз болжээ. Хөдөө хээр гарч ан хөөх мөн тиймэрхүү зугаа цэнгээнд оролцдогучраас махлан таргалаагүй, харин ч мах булчин нь улам чангарчээ. Хүйтэн усанд байнга шумбан нааддаг учир бие цогцос нь эрүүл чийрэг болжээ.

Клондаикт олдсон асар их алтны орд ертөнцийн өнцөг булан бүрээс хүмүүсийг тасхийм хүйтэн Умард зүг рүү даллан дуудсан мянга найман зуун ерөн долоон оны тэр намар хүртэл Бэк нохой иймэрхүү амьдарч байлаа. Бэк сонин уншиж чаддаггүй болохоор энэ тухай мэдсэнгүй, цэцэрлэгчийн нэг туслагч Мануэль гэгчтэй танилцсан нь олигтой юманд хүргэхгүй гэдгийг ч бас гадарласангүй.

---

<sup>1</sup>•Фунт-409,5 граммтай тэнцэнэ.

Мануэль хятадын мөрийтэй тоглоомд амиа тавьдаг байжээ. Мөрийтэй тоглоом гэхлээр эрүүл саруул бодол санаагаа умартан яахаас ч буцахгүй хуншгүй болсон тоглоомчин ажээ. Тоглоход багагүй мөнгө хэрэгтэй байдаг, гэтэл туслах цэцэрлэгчийн өчүүхэн цалин эхнэр, олон хүүхдээ тэжээхэд нь л дөнгөн данган хүрдэг байв.

Мануэлийн урван тэрсэлсэн тэр ёрын шөнө Миллер шүүгч Дарсүйлдвэрлэгчдийн нийгэмлэгийн хуралд уригдаж хөвгүүд нь спортын клуб эмхлэн тоноглох ажилд улайран эдлэн газар нь эзгүй байсан болохоор Мануэль Бэкийг дагуулж цэцэрлэг дундуур өнгөрч одохыг хэн ч ажигласангүй. Бэк салхинд зугаалах нь гэж бодож байжээ. Галт тэрэг шаардлага гарвал түр саатан зогсдог "Коллежпарк" нэртэй төмөр замын бяцхан өртөө рүү тэдний хүрч ирснийг цорын ганц хүн л харжээ. Тэр хүн Мануэльтэй хэдэн үг солилцоод дараа нь мөнгө хангир жингэр хийн гараас гарт шилжлээ.

- Чи яахлаараа бараагаа баглаа боодолгүй авчирдаг билээ? гэж үл таних хүнийг дургүйцэн өгүүлэхэд Мануэль Бэкийг хүзүүвчний доогуур бүдүүн оосор давхарлан ороогоод:

- Амьсгаа нь багтартал нь чанга татаарай, тэгвэл яасан ч мултрахгүй гэхэд өнөөх хүн хариуд нь зөвшингүй бувтнав.

Хүзүүнд нь оосор углахад Бэк огт эсэргүүцсэнгүй. Энэ нь түүнд цоо шинэ зүйл байсан авч өөрөөс нь илүү ухаантай гэж таньдаг хүмүүстээ итгэж заншсан байжээ. Гэвч оосрын нөгөө үзүүр үл таних хүний гарт шилжихэд сүрдүүлэн архирав. Архирсан нь тушаал лугаа адил болно гэж Бэкбардам сэтгээд тийнхүүдургүйцсэнээ илэрхийлжээ. Тэгтэл гайхалтай нь оосор огцом чангарч амьсгаа нь боогдох шахав. Бэк агшин зуур хилэгнэн хорссондоо өнөөх хүн рүү дайртал тэр хүн амжиж хоолойг нь чанга базан сурмаг хөдөлгөөнөөр гэдрэг нь газар саван унагав. Оосор улам чангарч Бэк хэлээ унжуулан хүчирхэг хэнхдэг нь гүдэлзэн амьсгаа нь бачимдан шуухитнаж үл таних хүн рүү улангасан архирна.

Урьд нь хэн ч түүнтэй ингэж бүдүүлэг зэрлэг харьцаж байсангүй, хэзээ ч ингэж уурсан хилэгнэсэн удаагүй билээ! Төдөлгүй хүч тэнхээ нь алдран харьж нүд нь бүлтийж галт тэрэг ирж зогсоход хоёр хүн дамжлан өргөөд ачааны вагон дотор хаяхыг огтхон ч мэдсэнгүй. Сэхээ ороод хэл нь хөндүүрлэн өвдөхийг мэдэв. Дараа нь чичрэгээ мэдрэгдэн зэрлэг рүү дөхөн ойртсон уурын зүтгүүрийн яндан хангинах бөглүү дуу сонсогдоход л хаана яваагаа ойлгожээ. Шүүгч өөрийг нь дагуулан галт тэргээр олонтаа аялдаг байсан болохоор гар тээш ачдаг вагонд ямархуу сэтгэгдэл төрдгийг анддаггүй байжээ.

Бэк нохой нүдээ нээв. Нүдэнд нь олзлогдсон вангийн хилэн хорсол дүүрэн аж. Өнөөх хулгайч хүзүүнээс нь барихаар завдан ухасхийхэд нь Бэк энэ удаа шалмаг хөдөлж гараас нь хавхийтэл хазан шүдээ шигтгэж хүзүүнд нь угласан оосор дахин чангарч ухаан нь балартан балартатлаа зуурчээ.

Ноцолдох шуугианаар вагоны үйлчлэгч хаалгаар шагайхад өнөөх хүн цус болсон гараа нуунгаа:

- Өвчин нь хөдлөөд байна! Эзэн маань энэ нохойг Фрискод аваач гэж тушаасан юм аа, тэнд нохой эмчилдэг зэгсэн сайн эмч байдаг сурагтай, энэ галзуурсан амьтныг эдгээх юм байлгүй дээ гэж тайлбар тавив.

Дараа нь Сан-Франциско хотод ирээд усан онгоцны боомтын архины гуанзны арын өмгөр өрөөнд энэ шөнийн явдлыг чимж давслан сүржин үгээр хүүрнээд:

- Дөнгөж хагас зуу шүү, мэдсэн бол бэлэн мянгыг амласан ч татгалзах байсан юм! хэмээн гомдоллоно.

Гараа боосон нусны алчуураас нь цус нэвчин шүүрч өмд нь баруун өвдөгнөөс доош цуу татагджээ.

- Цаад хүн чинь хэдийг авсан бэ? гэж архины гуанзны эзэн сонирхов.

- Зууг л өгсөн, доош ер буулгаагүй шүү!

- Тэгэхлээр нийтдээ зуун тавь гэсэн үг, тийм үнэ хаяахад ч харамсмааргүй нохой байна билээ, би андахгүй!

Өнөөх хүн цус нэвчсэн алчуураа тайлаад хазуулсан гараа харж:

- Галзуу л биш байгаасай, тэгвэл ч өнгөрлөө гэж үглэнэ.

- Зүгээр бүү санаа зов, чи үхэх болоогүй, чи дүүжлүүрийн гогцоонд савлах тавилантай төрсөн эр шүү дээ! хэмээн гуанзны эзэн даажигнаад:

- Алив надад жаахан туслаадах, дараа нь хандсан зүгтээ яв даа гэж нэмж хэлэв.

Хоолой нь хорсон тэсэхийн аргагүй өвдөхөд мэл гайхсан, хагас ухаантай байсан ч гэсэн Бэк тамлагчид руугаа дахин архиран дайрах гэж оролдов. Гэвч

тухай бүр хариу цохиулан шалан дээр унаж хүнд зэсэн хүзүүвчийг нь хөрөөдөж дуустал хоолойд нь угласан оосор улам чангарсаар байлаа. Дараа нь оосрыг тайлаад Бэкийг чингэлэгтэй адилхан сараалжин хайрцаг дотор түлхэн оруулав. Бэк нохой энэ сараалжин хайрцаг дотор хорсол хилэн, доромжлогдсон бардам омогдоо дарагдсаар зовлонт дуусашгүй шөнийг өнгөрөөв. Энэ бүхэн ямар учиртайг ойлгож ядна. Энэ гаднын хүмүүст Бэк ямар хэрэгтэй юм бэ? Яагаад давчуу сараалжин хайрцагт таг түгжээ вэ?

Бэк нохой учраа олохгүй гайхаж нөмрөн буй аюулыг бүдэг бадаг таамаглан сэтгэл нь шанална. Хаалга хяхтнан онгойх чимээ гарих бүрд шүүгч юм уу ядаж хөвгүүд нь ирлээ гэж Бэк горьдон хэдэн удаа огло үсрэн өндийж өөрийн эрхгүй баярлан хуцсанаа тосон дэнлүү барьсаар саравч руу шагайх гуанзны эзний хавагнасан царай бүдэг гэрэлд сүүмэлзэн үзэгдэхэд догшин ширүүн архирах бөлгөө.

Гэвч гуанзны эзэн түүнийг ер оролдсонгүй. Зөвхөн өглөөгүүр дөрвөн эрэгтэй хүн ирж сараалжин хайрцгийг өргөлөө. Сахал самбаа нь бурзайж харласан, хувцас хунар нь сэмэрч урагдсан нэг л жигтэй хүмүүсийг харангуут Бэк "өөр нэг тамлагчид" гэж бодоод уушиг зүрх нь амаар нь гарчих шахан оволзож сараалжин дотроос тэдэн рүү архиран дайрна.

Гэвч тэд хоорондоо тас тас хөхрөлдөж урт сарваагаар чичлэн хатгана. Бэк нохой савааг тас зуун архиран чангааснаа өөрөөс нь чухам ийм л хариу хүлээж байгааг ойлгоод больж ачааны бүхээгтэй тэрэгт зөөн оруултал нь дүнсийн чимээгүй хэвтлээ.

Сараалжин хайрцаг дотор түгжигдсэн Бэк нохой үүнээс хойш олон хүний гар дамжлаа. Эхлээд тээврийн албаны ажилтнууд өөр нэг ачааны бүхээгт тэргэнд зөөн ачин цааш явсан. Дараа нь гатлага онгоцон дээр бөөн хайрцаг дотор аялав. Тэндээсээ төмөр замын том буудалд хүргэгдэж дахиад ачааны вагонд ачигдлаа.

Бүтэн хоёр хоногийн турш уурын зүтгүүрийн дохио бөглүү дуугаар удтал хангинахыг сонсч явлаа. Энэ зуур хэл дээрээ юу ч тавьсангүй. Уурсан ганихарсан Бэк үйлчлэгч нарын өрөвдөж халамжлах гэсний хариуд өөдөөс нь архирах тул тэд өширхсөн түүнийг басамжлан даажигнах болов.

Бэкийн амнаас хөөс цахран бие нь салганан чичирч төмөр сараалжийг самардан дүүлэхэд тэд бүүр ч даамжирч хөхрөлдөн шоолж хашааны бөөстэй хавыг дуурайн цор цор хуцан архирч мяу мяу гэж дуугарч хамрынх нь өмнүүр гараа сарвалзуулан тахиа шиг дуугарна. Бэк ийнхүү агсрах нь учир утгагүй тэнэг хэрэг гэдгийг ухаарах авч бардам сэтгэлийг нь доромжилж байгаад уур нь хүрч хор шар нь дүрэлзэн буцална. Өлсөхийг яаж ийгээд тэсээд байна гэхэд ундаасан цангаснаас тэсвэр алджээ. Аливаа харьцааг гоц содон тусгадаг эмзэг сэтгэлтэй Бэк тийнхүү бүдүүлэг ёсон бус хандсанаас болж өвдчихжээ. Тэрээр халуурч хэт цангаснаас хоолой, хэл нь хатаж үрэвсчээ.

Гэхдээ хоолойг нь шахсан гайтай хүзүүвч байхгүй байгаа нь түүний цорын ганц тайтгарал болжээ. Хүзүүвчинд толгойгоо углуулсан цагт дайснууд нь хамаагүй давуу талтай. Одоо хүзүүвчгүйн хэрэг юу билээ, үзүүлээд өгнө дөө! Хүзүүвч дахин углах гэж ойртож мөн зүрхлэнэ байхдаа! гэж Бэк ингэж хатуу шийджээ.

Хоёр хоног хэл дээрээ юу ч тавьсангүй, бүтэн хоёр хоногийн тарчилгаанд хурж амсраасаа бялхсан догшин уур хилэн түүнд гар хүрэх гэж хамгийн түрүүнд ойлгосон хүнд тусах нь лавтай. Бэкийн нүдэнд цус хурж улаанаар эргэлдэн шулам лугаа адил болон хувирчээ. Өнгөрсөн хэд хоногт Бэк танигдахааргүй

өөрчлөгдөж хэрэв шүүгч хайртай нохойгоо харсан бол огт танихгүй байсан даа. Үйлчлэгч нар түүнийг Сиэтл хот руу ачаад сая хоёр яс хагацаж дотор нь онгойн тайвширч санаа алдацгаав.

Дөрвөн ачигч Бэкийг хорьсон хайрцгийг бүхээг тэрэгнээс ихэд болгоомжтой гаргаж өндөр хайсаар хүрээлсэн хашаан дотор оруулж газар тавилаа. Өөдөөс нь лагс биетэй, сунаж унжсан захтай нэхмэл улаан ноосон углаа цамцтай эр гарч ирээд ачигчаас дэвтэр авч ирүүлсэн барааг хүлээн авсан тухай гарын үсэг зурлаа.

"Бас нэг тамлагч!" гэж бодоод Бэкийн хор буцалж сараалжин хана руу агсран ухасхийв. Углаа цамцтай эр царайгаа барайлган жуумалзаад байшинд буцан орж гартаа сүх, бороохой барьсаар эргэн ирлээ.

- Чи чинь наадхаа арай суллах гэсэн юм биш биз? хэмээн нэг ачигч мэл гайхан асууна.

- Тэгэлгүй дээ гэж углаа цамцтай эр тоомжиргүй үг хаяад сүх далайн хайрцгийн хананд шигтгэв.

Дөрвөн ачигч агшин зуур бутран гүйлдэж өндөр хайс өөд авиран гараад аюулгүй газар эзлэн онц сонирхолтой юм болох нь гэж хүлээн ширтэцгээнэ.

Сүх цавчих бүрт тас няс дуугаран ханзран задрах хана руу Бэк үсрэн дайрч бүх биеэрээ наалдан шахна. Сүхний ир шигдэн гялтганах хананы хэсэг рүү Бэк архиран дайрна. Бэк хайрцаг дотроос мултран ангижрахын түүс болж углаа цамцтай эр ч түүнийг суллан гаргахаар шийдсэн бололтой тайван ажиллана.

Сараалжин хайрцагны хананд нохой багтахаар нүх гармагц өнөөх эр:

- За улаан нүдэт чөтгөр минь үзэлцье дээ! гэж хэлээд сүхээ газар хаяж баруун гартаа бороохой авлаа.

Энэ агшинд Бэк шулам шиг аймшигтай байв. Үс нь сэрвийн босож дүүлэн дайрахаар биеэ хурааж нүдэнд нь цус хурж амнаас нь хөөс цахарна. Битүү хайрцаг дотор удтал хоригдон баригдсан өшөө хорсол нь туйлдаа хүрч биеийнхээ зуун дөчин фунт жингээр дайрахаар завджээ.

Тэгээд агаарт цойлон дайснаа тас зуухаар сунатал яг тэр агшинд огцом цохилтод өртөн үсрэлт дундаа газар саван ойчлоо.

Зовиуртай өвдсөндөө Бэк шүдээ хавиран агаарт эргэлдээд хажуу нуруугаараа газар пидхийн уналаа. Өдийг хүртэл бороохойгоор ер занчуулж байгаагүй учир гайхан самгарджээ. Хөөрхийлөлтэй гангинаснаа ухасхийн босож өрсөлдөгч рүүгээ дахин архиран дайрлаа. Гэвч бас л цохиулж унав. Хэргийн хамаг учир бороохойд л байна гэдгийг сая ойлгож тэгсэн хирнээ уурлаж улангасаад болгоомжлохыг умартжээ. Арваад удаа дайрсан боловч тухай бүрд бороохойнд цохиулан агаарт эргэлдэн газар тэрийн унаж байлаа.

Нэгэн аймшигтай хүчтэй цохилтын дараа Бэк биеэ арай ядан дааж өндийв. Дахин үсрэн дайрах тэнхэлгүй болсноо гэнэт мэдэрч гайхан мэлрэв. Бэк зогсож чадахгүй, дайван ганхаж хамар ам чихнээс нь цус садран гоожиж цэвэрхэн үс нь цус, шороонд хутгалдан заваарчээ.

Улаан цамцтай эр түүнд дөхөн ирж бороохойгоо алгуурхан тайван далайж хоншоор дээр нь хачин чанга буулгав. Энэ нь түрүүчийн цохиулсантай харьцуулахын аргагүй хүчтэй байлаа. Бэк арслан шиг архиран дайрлаа. Нөгөө эр бороохойгоо баруун гараас зүүн гартаа шилжүүлэн барьж доод эрүүнээс нь шүүрэн бариад эргүүлж шидэхэд Бэк агаарт эргэлдэн толгой цээжээрээ газар хатган ойчлоо.

Бэк хамаг хүчээ шавхан дайчилж ахин дүүлэхэд эцсийнх нь гэж зориуд бэлтгэсэн тийм аймшигт цохилтод өртөн дуугарч ч чадсангүй, хүч тамир нь сульдан цуцаж пидхийн ойчлоо.

- Энэ ч нохой сургахдаа муугүй эр байх нь! гэж хашааны хайс дээрээс сонирхогчдын нэг нь бахдан атаархан дуу алдав.

- - Миний бодоход ийм нохойтой зууралдсанд орвол өдөр бүр тэр тусмаа бүтэн сайн өдөр хоёр удаа касс ухаж явбал хал багатай даа хэмээн хөтөч халаглаад морин тэргэндээ сууж одлоо.

Бэк сая ухаан орж биеэ дааж өндийх ч тэнхэлгүй хэвтэн улаан цамцтай эрийг харц салгалгүй ширтэнэ.

- "Бэк" гэдэг нэртэй хэмээн өнөөх эр Сан-Франциско хотын архины гуанзны эзний ирүүлсэн захидлыгуншингаа хэлээд:

- За Бэк хонгор минь чи бид хоёр ялигүй шуугиан дэгдээчихлээ, энэ тухай таг мартацгаая. Чи ч үүргээ сайн ухаар би ч юу хийхээ мэднэ, Дуулгавартай байвал гар хүрэхгүй, зөрж дүрсгүйтвэл зүрхийг чинь сугална шүү, ойлгов уу? гэж хөгжилтэй хэлэв.

Ийн өгүүлээд мөчийн өмнө хайр найргүй нүдэж занчсан толгойг нь хээвнэг илж түүний гар биед нь хүрэх бүрд Бэкийн үс өөрийн эрхгүй босох боловч эсэргүүцсэнгүй, тэсвэрлэх ажээ. Улаан углаа цамцтай эрийг ус авчирч өгөхөд Бэк шуналтайяа залгилж дараа нь мах өгөхөд шинэ эзнийхээ гараас үмх үмхээр тастчин ховдоглон зулгаалаа.

Бэк ичгэвтэр ялагдсан боловч (өөрөө ч ойлгожээ) зориг шантарсангүй. Бороохойгоор зэвсэглэсэн хүн өөрөөс нь хүчээр давуу гэдгийг биеэр амсаж хэзээ ч марташгүйгээр ойлгожээ. Бороохой түүний хувьд нээлт байлаа. Энэ бороохой түүнийг балар эртний хууль үйлчилдэг ертөнцөд ирснийг нь мэдрүүлж Бэк ч тэр хуулийг түргэн ойлгож захирагдах болов. Амьжиргааны хахир ширүүн үнэнийг таньжээ, гэхдээ айж эмээсэнгүй, харин ч хав дараастай явсан төрөлхийн зальжин ухаан нь сэргэжээ.

Цаг хугацаа өнгөрсөөр байв. Энэ зуур хайрцагт хийсэн эсвээс оосорлон уясан олон нохой авчрав. Нэг хэсэг нь их л дуугавартай номхон, зарим нь анхандаа Бэк шиг ардаглан аашлах ажээ. Гэвч улаан углаа цамцтай өнөөх хүн нохой болгоныг номхруулан өөрийн эрхшээлд оруулж байхыг Бэк хараад тухай бүр бороохойгоор зэвсэглэсэн хүнд дасан хайрлахгүй юмаа гэхэд наанадаж аяыг нь даган захирагдах нь зүйтэй эзэн мөнөөс мөн гэсэн үнэнд улам лавтай итгэжээ.

Бэк шинэ эзэндээ дуулгавартай захирагдах боловч харсаар байтал нь зодуулж занчуулсан зарим нохой шиг эзэндээ налигнан эрхэлж сүүлээ шарвалзуулан гарыг нь долродоггүй байлаа. Нэг нохой номхорч захирагдахыгүл хүсэн тэмцэлдэн зодуулсаар эцэстээ алуулахыг ч харжээ.

Урьд зүс үзээгүй, хачин жигтэй улс байн байн ирж эзэнтэй нь уурлан учирлаж эсвээс царайчлан зулгуйдан ямар нэг зүйл ярилцан тохиролцоно. Тиймэрхүү ярианы дараа ирсэн хүмүүсийн гараас эзнийх нь гарт мөнгө шилжиж тэдгээр хүмүүс нэг юм уу хэд хэдэн нохой хөтлөн одно. Явсан ноход эгэн ирж байсан удаагүй болохоор Бэк тэднийг хааш нь аваачдаг юм бол гэж тааварлаж ядна. Хойшид юу гээч болох бол гэхээс айдас нь хүрч худалдан авагчид өөрийг биш бусад нохдыг сонгож авах бүрд дотроо баярлана.

Гэвч түүний ээлж иржээ. Сэтгэлийг нь шаналгасан ирээдүй нь англиар хазгай муруй ярьдаг, утга нь үл ойлгогдох хачин жигтэй хахир огцом үг байн байн хэлдэг, хатингар туранхай, духандаа бөөн үрчлээстэй хүн ирснээр эхэлжээ.

- Чөтгөр ав! хэмээн тэр хүн Бэкийг хармагцаа дуу алдан хашгираад: - Жинхэнэ нохой мөн дөө! Бузгай нохой шив дээ! Хэдээр өгөх вэ? гэлээ.



- Ердөө гуравхан зуугаар, бараг л зүгээр өгч байгаатай ялгаагүй, үнэ хаялцаж төвөг удахгүй биз дээ, тэгээд ч албаны мөнгө болохоос биш чинийх биш тийм үү, Перро! гэж улаан цамцтай эр дуржигнуулан өгүүлэв.

Перро хариуд нь жуумалзав. Нохойны хэрэгцээ урьд хожид дуулдаагүй нэмэгдэж тэнгэрт тулсан үнэ хадсан энэ үед Бэк шиг нохойд хэлсэн үнэ давгүй санагджээ.

Канад улсын Засгийн газар энэ зэргийн наймаанд хотоохгүй л дээ, тэгээд ч шуудангаар түргэн үйлчлэх ёстой.

Перро нохой таньж чаддаг эр байжээ. Бэкийг дөнгөж хармагцаа ийм нохой мянга дотроос ганц тааралдана гэж ойпгов. "Арван мянга дотроос ганц шүү!" гэж дотроо засч бодлоо.

Нэг нь нөгөөдөө мөнгө өгөхийг хараад Бэк, духандаа бөөн үрчлээстэй хүн өөрийг нь сайхан сэтгэлт ньюфаунленд үүлдрийн Кэрлитэй цуг авахад нь гайхсангүй. Үүнээс хойш улаан цамцтай эрийг ер харсангүй билээ.

"Нарвал" хөлөг онгоцны тавцангаас алсад далдрах Сиэтл хотыг харан байхдаа дулаан уур амьсгалтай Өмнөд нутагт ахин хэзээ ч хөл тавихгүй болсноо огтхон ч тааварласангүй.

Перро хоёр нохойг дотогш нь оруулж Франсуа нэртэй хар арьст хүдэр эрд өглөө. Франц гаралтай Канадын иргэн Перро бор өнгөтэй бол Франсуа эрлийз болохоор бүр ч бараан арьстай ажээ. Бэк тийм өнгөтэй хүмүүсийг анх харсан агаад (Хожим нь тийм хүмүүстэй олонтаа таарчээ) тэдэнд татагдаж хайрлах сэтгэл төрөөгүй боловч зохих ёсоор үнэлж хүндэтгэж сурчээ. Перро, Франсуа хоёр бол шударга, тогтоон тайван хүмүүс бөгөөд зөвхөн балаг таривал л цаанаа хал балгүй цайлган сэтгэлээр шийтгэдэг, нохойны олон зан аашийг анддаггүй болохоор яаж ч баашлаад дөнгөхгүй гэдгийг Бэк төдөлгүй ойлгожээ.

Усан онгоц дээр Бэк, Кэрли хоёрыг өөр хоёр нохойтой цугбайрлуулав. Том биетэй, цасан цагаан үстэй нохойгхалим агнуурын хөлөгонгоцны ахмад Шпицберген арлаас авчирчээ. Хожим нь үржил шимгүй хэмээх нутагт геологчидтэй цуг явж байжээ. Энэ нохой тун наалинхай атлаа хар санаатай, нүүрэн дээр нь налигнаж цаагуураа чаддаг зантай аж. Анх тэдний хооллох үеэр Бэкийн хувиас хулгайлсан байна. Бэк шийтгэхээр ухасхийтэл Франсуагийн шилбүүр урьтаж агаарт тас нясхийн хулгайч дээр буув. Франсуагийн ийнхүү шударга хандсанд Бэк талархаж түүнийг хүндэтгэдэг болов.

Нөгөө нохой нь хэнд ч тал засдаггүй, хэний ч талархалыг татдаггүй, бусдын хоол руу ч шунаж өнгөлздөггүй ажээ. Баргар царайлан ямагт дүнсгэр байх хийгээд намайгзүгээр байлгахыг л ганцхан хүсье, оролдоод байх юм бол хохь чинь болно шүү гэдгийг Кэрлид яг таг ойлгуулжээ. Дэйв нэртэй энэ нохой идэж унтахаас өөр юм мэдэхгүй, үе үе эвшээж юуг ч үл сонирхох ажээ. Тэр ч байтугай "Нарвал" онгоц Шарлотта хатны булангаар гарах үеэр эргэлдэн савчиж дайвалзан ганхахад Бэк, Кэрли хоёр амь тавих шахам айж бэмбэгнэн байхад Дэйв дургүйцсэн мэттолгойгоо өндийлгөн тэднийгхайхрамжгүй харснаа нэг эвшээчихээд дахиад л унтаад өгчээ.

Усан онгоц зогсолтгүй, нэгэн хэмийн дүнгэнэх хөдөлгүүрийн доргионд өдөржин шөнөжин дайвалзан донсолно. Өдөр бүр адилхан боловч хоног өнгөрөх тутам хүйтэрч байхыг Бэк мэдэрнэ. Эцэст нь сая нэгэн өглөө сэнсний чихэнд чийртэй дуу тасарч "Нарвал" онгоцны тавцан дээр хөл үймээн боллоо.

Бэк бусад нохдын адил ямар нэгэн өөрчлөлт гарах нь гэдгийг тааварлажээ. Франсуа дөрвөн нохойг оосроор холбон уяд тавцан өөд гарав. Бэк тавцангийн хүйтэн шал дээр гарах агшинд хөл нь цагаан балчигтай адилхан агшаамал

будаанд орчих шиг болохоор нь тургиж ухасхийн ухрав. Тэгтэл мөн тийм цагаан будаа дээрээс нь хаялна.

долоосонд хэлийг нь гал мэт хайхрах шиг болсноо дорхиноо хайлав. Бэкийн гайхаш тасарч дахин долоосонд бас л хайллаа. Эргэн тойронд нь байсан хүмүүс нирхийтэл хөхрөлдөж тэд яагаад инээлдсэн учрыг сайн ойлгосонгүй хир нь Бэк яагаад ч юм ичжээ. Бэк ийнхүү анх удаа цас үзжээ.

## **Хоёрдугаар бүлэг Бороохой, соёоны хууль**

Дайя голын эрэг дээр өнгөрөөсөн анхны өдөр Бэкт хар дарсан зүүд шиг санагдлаа. Энд цаг тутам айж гайхах зүйл тааралдана. Түүнийг соёл иргэншлийн төвөөс гэнэт салгаж балар эртний ертөнцөд авчран хаяжээ. Өмнөд нутгийн наранд ээгдэн нозоорч юу хийж цаг нөгцөөхөө мэдэхгүй гуниглан байсан цэнгүүн амар жимэр амьдрал нь нэгэнт төгсгөл болжээ.

Энд хоромхон зуурын амсхийлт, тайван байдал, амралт алга, сэхээ завгүй хөдөлгөөн, үйл явдал үргэлжилж үймээн шуугиан ноёрхож мөч тутам л бэртэлт, үхлийн аюул заналхийлэх ажээ. Энэ шинэ ертөнцөд ноход, хүмүүс нь хотынхтой харьцуулашгүй шал ондоо учраас алхам тутамд сонор соргог байх шаардлагатай. Эд бүгдээрээ зэрлэг, догшин, бороохой, соёоны хуулиас өөр хуулийг мэдэхгүй ажээ.

Ноход хоорондоо чоно шиг ингэж уралцахыг Бэк Урьд ер үзээгүй билээ. Анхны тулалдаан түүнд мартагдашгүй хатуу сургамж өгчээ. Үнэндээ анхны сөргөлдөөнд Бэк оролцоогүй, тэгсэн бол өдийд амь тавьчихсан, тэрхүү хатуу сургамжийг ашиглахгүй өнгөрөх байсан даа. Тэр сөргөлдөөнд Бэк биш харин Кэрли хохирчээ.

Мухлаг байрласан дүнзэн байшингийн дэргэд тэр хоёрыг орхисон байжээ. Кэрли том чоно шиг хүдэр лагс боловч өөрөөс нь хоёр дахин жижигхэн, чацлаг тэнхээтэй нохойтой аанай л цайлган сэтгэлээр наадаж байлаа. Тэгтэл нөгөө нохой огт санаандгүй гэнэт аянга мэт гялсхийн үсрэн дүүлж шүдээ төмөр хорших мэт хавиран Кэрлийг тас зуугаад, учрыг ухаарахын зуургүй огцом үсрэн холдлоо. Кэрлийн хоншоор нүднээсээ амаа хүртэл өм татагдсан байлаа.

Энэ нутгийн ноход гэнэдүүлэн дайрч сэхээ авахын зуургүй арагш үсрэн зайлдаг чонын булхай зан авиртай ажээ. Үүгээр хэрэг дууссангүй. Тэр даруй хаанаас ч юм бүү мэд гуч дөчөөд ангууч ноход гарч ирээд зодолдогчдыг таг дуугүй, сэрэмжилсэн байдалтай тойрон бүслэв.

Тэд яагаад ийнхүү дуу шуугүй хүлээн хэл амаа шуналтайяа долоодог юм бол гэж Бэк анхандаа гайхжээ. Кэрли өрсөлдөгч өөдөө дайрсанд цаадахь нь бултаснаа дахин зууж амжаад үсрэн холдов. Кэрли дахин дайрахад цээжээрээ угтан овжин зайлсанд Кэрли хөл дээрээ тогтож чадсангүй газар ойчлоо. Зодооныг ажиглан харж байсан ноход үүнийг л хүлээж байжээ. Кэрли босож амжсангүй. Ноход архирагдан нөмрөн шавааралдаж Кэрли амь тавин гонгинож саглагар үстэй амьтдын дунд харагдахгүй болов.

Энэ аймшигтай явдал санамсаргүй, агшин зуур болсон тул Бэк цочирдон барьц алдсан байв. Шпиц хав улаан хэлээ унжуулсан нь инээж байгаа ажээ.

Франсуа сүх эргэлдүүлэн нохдын бөөн дунд ороход гурван эр бороохой барьсаар гүйн ирж туслалцан нохдыг хөөн тараав. Кэрли тэнцвэр алдан

унаснаас хойш ердөө л хоёр минут хирийн дараа нохдыг хөөн зайлуулжээ.  
Кэрли

цусанд будагдан дагтаршсан цасан дээр бараг л сэг болтлоо урж тасдуулаад амь тавьсан хэвтэнэ.

Бараан царайтай эрлийз эр түүнийг ширтэн байдгаараа хараал урсгал зогсоно. Энэ зүрх шимшрэм явдал Бэкийн санаанд олонтаа орж нүдэнд нь харагдан тэр ч бүү хэл шөнө зүүдэнд нь үзэгдэж зовоодог байлаа. Ийм хуультай байжээ, энд шударга өс үгүй, нэг л унах юм бол өнгөрлөө гэсэн үг.

Тэгэхлээр яаж ийгээд зогсох л хэрэгтэй! Шприц дахин хэлээ унжуулан инээхийг хараад тэр мөчөөс эхлэн Бэк түүнийг голоосоо эргэлтгүй үзэн яджээ.

Кэрлийн эмгэнэлт үхлийн дараа сэхээ авч учрыг эрэгцүүлэн бодохын зуургүй сэтгэлийр нь донсолгосон бас нэг үйл явдал болох нь тэр.

Төрөлх эдлэн газрынх нь агтчингууд морьдоо хөллөдөг байсан шиг тийм суран тоногт түүнийг хөллөв. Бэк ийнхүү хөллөгөөний морь шиг зүтгэх болов. Хөндийг хүрээлсэн ойд Франсуагийн хөлөглөсөн чаргыг чирэн модонд явдаг болжээ.

Гарцаагүй захирагдан хөллөгөөнд явдаг болсон нь түүний ихомсэг занг угаар нь хөндөн сэтгэлийг шаналгах боловч эсэргүүцэх зориг хүрсэнгүй. Харин биеэ барьж хөллөгөөнд ороод мод зөөх нь сонин хачирхалтай санагдаж олигтойхон ажиллахыг эрмэлзэв.

Франсуа үг дуугүй захирагдахыг шаардаж хатуу байх агаад шаардлагаа шилбүүрийн тусламжаар биелүүлүүлдэг ажээ. Үүнээс гадна хал үзсэн туршлагатай нохой Дэйв алдаа гаргах бүрд гуянаас нь хазаад авна. Хөллөгөөний түүчээ Шпиц бол Дэйвээс дутахгүй туршлагатай хийгээд Бэкийг хааяа нэг бүдрэхэд савардаж амжаагүй бол хорсолтойёо зэмлэн агсарч эсвэл зүтгүүрийн оосрыг биеийнхээ хүндээр дарж зохих зүгт нь сурмаг зална.

Хоёр нохой, Франсуа нарын удирдлага заалтаар Бэк хөллөгөөний эв дүйг амархан эзэмшиж гайхмаар амжилт олжээ. Буудалласан газраа буцан. ирэхэд "Хо!" гэж хашгирахад зогсоно,

"Урагшаа!" гэхэд урагш зүтгэх ёстой, эргэх үед хурдаа сааруулж ачаатай чарга уулын уруу өнхөрөхөд дундах нохойноос аль болох холдох хэрэгтэй гэдгийг Бэк аль хэдийнээ ойлгосон байв.

- Гурвуулаа сайн нохой байна, тэр тусмаа Бэк бүр онцгой юм! Удахгүй би түүнийг гаргууд сайн сургачихна даа! хэмээн Франсуа буцаж ирээд Перрод магтан ярив.

Засгийн газрын шууданг яаралтай хүргэх үүрэг авсан Перро тэр өдөр Билли, Жо гэдэг хоёр нохой авчрав.

Цэвэр үүдрийн энэ хоёр ангууч ноход нэг эхээс төрсөн хирнээ бие биенээсээ өдөр шөнө шиг ялгаатай ажээ. Билли ныхэтэрхий цайлган сэтгэлтэй атал Жо нь шал өөр зожиг, дүнсгэр, ууртай, дандаа архирч бүгдийг дургүйцэн харна.

Тэр хоёрыг Бэк найрсаг угтав. Дэйв нохой тэднийг огт анхаарч тоосонгүй, харин Шпиц тэр даруй ээлжлэн дайрчээ. Билли анхандаа сүүлээ эвлэрэнгүй хавчиж байснаа байдал бишидсэнийг ойлгож зугтахаар ухасхийсэн боловч амжсангүй.

Шпицийн хурц шүд хавирганд нь шигдэхэд эсэргүүцсэнгүй, хөөрхийлөлтэйгээр гуйж гувшсан маягтай гангинав. Шпиц Жог аль ч талаас нь дайран давшилсан боловч тухай бүрд үсээ босгож чихээ соотолзуулаад хавьтуулсангүй. Жо заналхийлэн архирч шүдээ хавиран тачигнуулж чөтгөр шүглэсэн мэт нүдээ айдас хүрэм гялалзуулна. Шпиц түүнээс эмээн сүрдэж сайн хашраая гэсэн

санаархлаа орхив. Гэвч ялагдсандаа бантан хөөрхийлтэй гонгиносоор буй Билли рүү дахин дайрч буудалласан газраас хөөжээ.

Үдэш болох үеэс Перро шөрмөслөг, чацлаг биетэй, хөллөгөөнд яг тохирох хөгшин ангууч нохой авчрав. Нүүр нь түмэн сорви, гувруутай агаад ганц нүдтэй ажээ. Тэр ганц нүд нь зориг бялхсан, тулалдаанд уриалан дуудсан харцаар гялалзан ширтэх нь өөрийн эрхгүй хүндэтгэл төрүүлнэ. Соллекс буюу Ууртай гэдэг нэртэй ажээ. Соллекс бол Дэйв шиг бусдыг өдөж оролдохгүй, хэнийг ч өөртөө ойртуулахгүй, мөчөөгөө өгдөггүй байв. Түүнийг ихэмсгээр яаралгүйхэн алхлан ойртоход Шпиц хүртэл хөдөлж зүрхэлсэнгүй.

Соллекс нэгэн айхтар сул талтай агаад гай дайрахад Бэк түүнийг нь анх мэдэж илрүүлжээ. Тэр нохой сохор нүднийх нь талаас ойртохыг ер таашаадаггүй юмсанж. Ямар ч сэжиг аваагүй Бэк тэр талаар нь ойртоод гүн дургүйцлийг нь төрүүлж Соллекс огцом эргэн дайрч мөрнөөс нь ясанд нь тултал гурван ямх<sup>1</sup> зузаан хазахад нь л буруудсанаа сая ухаарчээ. Үүнээс хойш Бэк түүний хориотой талаас ганц ч удаа ойртоогүй бөгөөд Соллекс ч түүнийг дахин хөндсөнгүй. Шинэ танил нь Дэйв шиг тайван байлгахыг л хүсэж буй нь илт ажээ. Гэвч Дэйв, Соллекс хоёр дориун өндөр эрмэлзлээр дүүрэн явдгийг Бэк төдөлгүй ойлгов.

Анхны шөнө гэхэд л Бэкэд хоноглох газар олох бэрх асуудал тулгарчээ. Цасанд битүү хучигдсан талын дунд майхан дотроос лааны гэрэл дур булаан анивчина. Хоноглох байр маань тэнд байна гэсэн санаа өөрийн эрхгүй төрнө. Тэгээд майхан дотор ортол Перро, Франсуа хоёр хараал зүхлээр угтаж гартаа тааралдсан юмаар шидлэхэд Бэк анхандаа самгардсанаа сэхээ авч тасхийм хүйтэн рүү ичгүүртэйгээр хөөгдөн гарлаа.

Хахир зэвүүн салхи нүдэж бүх бие дагжин чичирч шархадсан мөр нь шархиран хөндүүрлэнэ. Бэк цасан дээр хэвтэн унтахыг оролдсон боловч хүйтэнд даарч тэссэнгүй босов. Цөхөрч гүйцсэн Бэк майхан буудал дундуур холхин унтчихаар дулаавтар газар эрсэн боловч олдсонгүй. Энд тэндээс агсам ноход дайрахад өөдөөс нь Бэк сэrvээнийхээ үсийг босгон хилэгнэн архирвал (тэгж бас сурчээ) тэд номхорно.

Эргэн очиж хөллөгөөний ноход хаана хоноглож байгааг үзье гэсэн бодол гэнэт төрөв. Гэтэл нэг нь ч байдаггүй, гайхаж хоцров. Тэд хаашаа юм бүү мэд цөм алга болчихжээ. Дахиад л майхан буудал дундуур хэсүүчлэн явж тэднийг зөндөө эрсэн боловч бас л олсонгүй. Арай майхан дотор байгаа юм биш биз дээ? Үгүй тийм байх ёсгүй. Бэкийг тэндээс тууж хөөсөн шүү дээ! Тэгээд хаачдаг юм бэ? Бүх бие нь дагжин чичирч сүүлээ хавчин дэмий л майхан тойрон ганцаараа хэрхэхээ мэдэхгүй явна.

Тэгтэл урд саврынх нь дор цас гэнэт цөмөрч золтой л бүдэрч уначихсангүй. Хөлийнх нь дор ямар нэгэн юм хөдөлнө. Үл мэдэгдэх гэнэтийн явдалд цочирдсон Бэк хойш ухарч архиран үс нь сэrvийн босчээ. Гэвч нөхөрсөг намуунаар гангинах дуу сонсоод тайвширч болгоомжтой дөхлөө. Дулаан агаар пүнхийж Билли нүхэн дотор цасан дор биеэ хураан атирч тавлаг хэвтэж байх нь тэр. Бэкэд тал засан гангинаж сүүлээ хөдөлгөн эв найртай буйгаа илэрхийлээд түүнийг өөртөө татах гэж халуун хэлээрээ хоншоорыг нь долоож зүрхлэв.

Бас нэгэн үнэт сургамж авлаа. Энд тасхийм хүйтнээс ингэж хоргодон аврагддаг байна шүү! Учрыг ойлгож сэтгэл нь сэrvгэсэн Бэк тэр даруй аятайхан газар итгэлтэйгээ сонгож удтал мунгинан ихээхэн чармайж цас малтан нүх гаргав. Төдсөнгүй нүхэн дотор биеийнх нь илчинд халуун дулаан болж хэцүү урт

өдрийн дараа тааламжтай, бөх унтлаа. Нойрон дундаа хар дарж зүүдлэн үе үе архиран хуцна.

Тэгээд зөвхөн өглөөгүүр буудлын чимээ шуугианаар сэрчихэв. Анхандаа хаана байгаагаа ойлгохгүй бантав. Шөнө их цас орж түүнийг нүхэн дотор нь битүү дарж орхижээ. Зузаан цас битүү бүрхэж тал бүрээс нь түрнэ. Гэнэт Бэкийг урхинд орсон араатны айх сэтгэл эзэмдлээ. Үнэндээ хэмжээнээс хэтэрсэн соёлтой энэ нохой өдий хүртэл урхи гэдгийг мэдэхгүй, тийм ч учраас болгоомжлох ёсгүй байтал ийнхүү сандарч тэвдсэн нь эртний удмын зөн билэг илэрсэн нь энэ ажгуу.

Бие нь чичрэн татвалзаж хүзүү, мөрнийх нь үс сэрвийн босож зэрлэг догшин архирч нүхнээс ухасхийн дайран гарахад сэвсгэр цас бутран бударч өглөөний хурц нар нүдийг нь гялбуулав. Тэгээд цасан дээр байрласан буудлыг хараад одоо хаана байгаагаа ухарч Мануэль цэцэрлэгчтэй цуг зугаалахаар гарсан тэр өдрөөс хойш хоноглох газар эрж цас малтан нүх гаргаж унтахаар хэвтсэн урьд шөнийг хүртэлх бүх үйл явдлыг агшин зуур нэхэн саналаа.

Франсуа түүнтэй хашгиран мэндчилж Перрод хандан.

- За би хэлээгүй юу, энэ Бэк адтай золиг шүү! гэв.

Перро хариуд нь их л сүрхий толгой дохив. Перро Канад улсын Засгийн газрын зарлигаар ажиллаж шуудан, чухал албан бичиг зөөдөг болохоор түүнд хамгийн сайн ноход хэрэгтэй юм. Тийм учраас аз таарч Бэк нохойг олж авсандаа сэтгэл машид хангалуун байлаа.

Перро цаг ч өнгөрөөгүй байхад хөллөгөөний гурван нохой нэмж аваад нийтдээ есөн нохойтой болж мөчийн дараа гэхэд нохдоо бүгдийг нь хөллөчихөөд Дайя хавцлын зүг цасан замаар хурдлан давхив.

Бэк байдалд өөрчлөлт гарсанд баярлан хөллөгөөнд явах нь хүнд төвөгтэй боловч дургүйцэж зэвүүрхсэнгүй.

Хөллөгөөнд хамт яваа ноход нь махран зүтгэж байгаа нь Бэкэд анхандаа хачирхалтай санагдсан боловч төдөлгүй өөрөө ч тэдний урам зүтгэлд автав. Дэйв, Соллекст нарт гарсан өөрчлөлт бүр ч их гайхшийг нь төрүүлэв. Хөллөгөөнд орсон нь тэдний байдлыг эрс өөрчилсөн мэт харагдаж тэднийг танигдахын аргагүй болгожээ. Номой үлбэгэр, амирлангуй тайвуун байдал нь арчсан мэт арилжээ. Ийм цог золбоо, хүч тэнхээ хаанаас гараад ирэв ээ? Тэд хөллөгөөг жигд түргэн явуулахын тулд хамаг хүчээрээ чармайн зүтгэж түр саатах юм уу бусад ноход сандран мунгинахад бухимдан уурлацгаана. Энэ хөдөлмөр тэдний энэ хорвоод төрсний мөн чанарын жинхэнэ илрэл, энэ хөдөлмөрт бүх амьдралынх нь утга учир, цорын ганц аз жаргал нь шингэсэн гэлтэй.

Дэйв бол хөллөгөөний дунд явдаг нохой, энэ удаа Бэкийгтүүний өмнө Соллексийн ард оруулжээ. Бусад нохой тэдний урд цувран давхиж Шпиц хамгийн түрүүнд явна.

Бэкийг хөллөгөөнд сургах гэж Дэйв, Соллекс хоёрын Дунд зориуд оруулжээ. Бэк авъяаслаг сурагч, нөгөө хоёр нь сайн багш болохоо тэр даруй харуулжээ. Тэд Бэкийн гаргасан алдаа болгоныг хурц шүднийхээ тусламжтайгаар дор нь засан залруулж байв.

Дэйв бол шударга ухаалаг нохой ажээ. Бэкийг шалтгаангүйгээр гоочлохгүй хийгээд харин алдаа гаргавал зуухгүй зүгээр өнгөрөөнө гэж огт үгүй, алдаа гаргасан тохиолдол бүрд Франсуагийн шилбүүр шийтгэлийг нэмэх учраас тэднийг эсэргүүцэн архирснаас алдаагаа засч дахин давтахгүйг эрмэлзэх нь дээр юм гэсэн бодол Бэкэд төрнө.

Нэгэн удаа түр буудаллах үеэр Бэк тоногт орооцолдож хөдлөхөд саад болсонд Дэйв, Солекс эвсэн дайрч айхтар сургамж өгчээ. Тэгэхэд нь тоног улам орооцолдсон боловч Бэк хожим тэр алдаагаа дахин давтахгүйг ихэд хичээх боллоо. Үдэш болоход Бэк ногдсон үүргээ чамбай гүйцэтгэн сурч сургагч нар нь ч түүнийг зууж шийтгэдэгээ бараг болив.

Франсуагийн шилбүүр толгой дээгүүр нь тас няс хийдэг нь улам цөөрч тэр байтугай Перро түүнийг ихэд халамжлан саврыг нь ээлжлэн өргөж нягтлан шалгаж үзнэ. Тэд анхны өдөр их хэцүү зам туулж айхтар зүдэрчээ. Хөндийгөөр явж Хонины хот, Жинлүүр суурингаар дайрч Жинлүүр суурингийн хажуугаар ойн захаар гарч хэд хэдэн мөсөн оргил, хэдэн зуун тохой өндөр цасан хунгарыг давж шорвог болон цэнгэг устай голуудын дагууд сунан тогтсон гунигт эл хуль Умард нутагт хүрдэг замын догшин манаа болох цуут Чилкутын давааг давлаа.

Тэд сөнөсөн галт уулын царт үүсэн хөлдөж цуварсан олон нуурын мөсөн замыг эсэн мэнд туулж олон мянган алтны эрэлчид хавар айлчилж мөс хайлахыг хүлээн завинуудаа зэхэн бэлтгэж байгаа Беннет нуурын тэндэх том буудалд шөнө дунд хүрч ирлээ. Бэк ирсэн даруй хунгар цас хонхойлон малтаж нүх гаргаад эцэж ядарсан тул нам

унтлаа. Ханатал унтаж чадсангүй. Төдөлгүй түүнийг нүхнээс нь татан гаргаж өвлийн тасхийм хүйтэн шөнийн пад харанхуйд бусад нохдын хамт хөллөгөөнд оруулав.

Тэд энэ өдөр дагтаршсан замаар явсан болохоор дөчин бээр<sup>1</sup> зам туулжээ. Гэвч дараагийн хэдэн өдөр нь хунгар цасан дундуур өөрсдөө зам гарган явж нилээд ядарч удаан урагшлав. Одоо Перро хөллөгөөний урд цанаар явж ноходод зам гарган Франсуа урт саваагаар хөллөгөөг чиглүүлэн зална. Тэр хоёр хааяа байраа сольж явах боловч тэгж явах нь тун ховор. Перро яаран шавдуулна. Өөрийгөө Франсуагаас илүү мөсний зузааныг тодорхойлж чадаж байна гэж бодно. Учир нь гэвэл намрын мөс даан ч найдвар муутай, тэгээд ч голын урсгал ширүүн газраа ер хөлдөөгүй тул мөсний зузааныг яг таг тодорхойлох нь маш чухал ажээ.

Бэк өдөр алгасалгүй (Эдгээр шаналгаат өдрүүд дуусна гэж үгүй мэт санагдана.) хөллөгөөнд явна. Битүү харанхуй нөмрөхөд л сая нэг түр буудаллах агаад тэнгэр хаяанаасаа гэгээрэн цайрч эхэлмэгц аяны замд гарч ардаа хэдэн бээр зам орхин урагш давхина. Ийнхүү явсаар мөн л шөнийн харанхуйд буудаллаж ноход ногдсон загасаа дор нь идчихээд унтахаар зэхэн цас малтан нүхэнд шургана.

Бэк дандаа өлсөж явна. Өдөрт хагас жин хандгайн мах идэх боловч тэр нь гол зогоох төдийхөн болдог ажээ. Бэк ер цадталаа идсэнгүй, дандаа өлөн хоосон явах болов. Гэтэл өөрөөс нь жингээр бага, иймэрхүү хатуу амьжиргаанд дассан бусад ноход нь өдөрт ердөө л ганцхан жин загас иддэг хирнээ тэнхээ тамираа хадгалж сэргэлэн цовоо явдаг аж.

<sup>1</sup>•Бээр буюу миль нь 7420 метртэй тэнцэнэ.

Бэк өмнөд нутагт байсан шигээ идэх юм шилж сонгон тайвуун зооглодог заншлаа төдөлгүй хаялаа. Бусад нохой ногдсон хувиа ум хумгүй түргэн залгичихаад түүний хоолонд хошуу дүрж булаадаг байв. Бэк ногдсон хувийг харамлах нь байтугай хамгаалж ч чадахгүй байлаа. Хоёр, гурван дээрэмчинтэй архиран тэмцэлдэж байх хооронд үлдсэн загас нь бусдын улаан хоолойгоор орж алга болох ажээ. Тэгээд Бэк бусдын адил түргэн хоцрохгүй идэж сурлаа.

Тэсэхийн аргагүй өлсөж гол нь харлан хулгай хийхээс ч буцахгүй шалдаа буув. Бусад нохой яаж овжин хулгай хийж байгааг ажиглан харсаар өөрөө ч сурчээ. Саяхан ирсэн зальтай Пайк Перрог цааш эргэн харах зуур хамар дороос нь өвчүү сурмаг гэгч сэмхэн зууж авахыг хараад дараа өдөр нь яг тэр аргыг хэрэглэж бүхэл бүтэн өвчүүг шүүрэн зууж арилав. Төдсөнгүй бөөн шуугиан дэгдэж хэргийн эзэн Бэк сэжиг ч төрүүлэлгүй сугаран үлдэж харин түүний оронд сав л хийвэл юманд өртчихдөг болхи Даб шийтгүүлжээ.

Анхны энэ хулгай Умард нутгийн хэцүү нөхцөлд Бэкийн амьдрах чадвартайг, цоо шинэ нөхцөл байдалд дасан зохицох авъяастайг харуулав. Хэрэв ийм чадвар авъяасгүй бол удалгүй зовж тарчлан амиа алдах байлаа Үүний зэрэгцээ анхны хулгай нь түүний ёс суртахуун доройтлын эхлэл болсон аж. Түүнд энэ хорвоод мэндэлсэн анхны өдрөөс нь төлөвшин тогтсон урьдын эрхэм сайхан чанарууд нь бүрмөсөн алдагдаж тэгээд ч амьд мэнд байхын төлөө хатуу ширүүн тэмцэлд тэдгээр нь дарамт чөдөр болохоос цаашгүй ажээ. Тийм эрхэм чанарууд нь хайр нөхөрлөлийн хууль ноёрхсон Өмнөд нутагт л гагцхүл тохирох юм. Тэнд л бусдын эд хөрөнгийг хүндэтгэж бусды' энэрэн хайрлаж байх нь зүйтэй. Харин энд Умард нутаг

бороохой, соёоны хүчээр амь зуухын төлөө тэмцэх зарчим ноёрхдог агаад энд усан тэнэг л амьд мэнд байж бусдын дор орохгүй явахад нь саад болохоос хэтрэхгүй шударга ёсыг баримтлах гэж муйхарлан чармайх биз ээ.

Гэхдээ Бэк ингэж бодож сэтгээгүй нь мэдээж, амьдралын шинэ нөхцөл байдалд л зөн билгээрээ зохицжээ. Бэк өдий хүртэл хүч тэнцвэргүй байхад ч өрсөлдөөнөөс зайлсхийж байсан удаагүй билээ. Гэхдээ улаан цамцтай эрийн барьсан бороохой, түүний биеэ авч явах болхидуу боловч амьдралд чухал шаардлагатай баримтлалыг эгнэгт марташгүйгээр ойлгуулжээ.

Бэк соёлтой нохой байхдаа жишээлбэл Миллер шүүгчийн ташуурыг хамгаалах ч гэх юм уу ёс суртахууны шинжтэй үйлдлийн төлөө үхэн хатан тэмцэхэд бэлэн байлаа. Гэхдээ Бэк тийм ёс суртахууны шинжтэй үйлдлийг одоо эс тоомсорлон хар амиа л хаацайлан хамгаалахад бэлэн байгаа нь баттай зэрлэгшиж байгааг нь илт харуулна. Бэк ов заль, уран чадвараа гайхуулах гэсэндээ биш харин хоосон хоржигнох гэдсээ тэжээж гол зогоох гэсэн цорын ганц тэсвэрлэшгүй шаардлагад захирагдан аргагүй хулгай хийх болов. Бэк бороохой, соёоны хуулийг бүрэн дүүрэн хүндэтгэдэг болсноор бүхий л болгоомжлолыг баримтлан далдуур дээрэм тонуул үйлдэнэ. Товчоор хэлбэл Бэк хийхгүй байснаас хийвэл хялбар байдаг зүйлийг хийжсурчээ.

Бэк улам түргэн хөгжиж амьдралын эрээн барааныг ойлгож үнэндээ зэрлэгшиж байлаа. Түүний булчин төмөр мэт чийрэгжин хатуурч ердийн бага сага зовиурыг эс тоомсорлон үл мэдэрнэ. Оюун санааны төдийгүй бие бялдрын хатуужилтай болов. Бэк одоо ой гутаж бөөлжис цутгам шингэх аргагүй элдэв зүйлийг ч хоолой давуулж сурчээ.

Түүний ходоод залгисан бүхнээ үлдээлгүй боловсруулан шингээж тэр боловсрогдсон зүйлс нь цусаар дамжин бүх биед нь тархаж хатуу чанга булчин шөрмөсийг нь тэжээн тэнхрүүлэх ажээ.

Бэк бол гайхалтай хурц хараатай, үнэрч, нойрон дундаа үл ялих чимээг сонсож аюултай эсэхийг нь ялган таньж мэддэг туйлын сонор соргог юм. Тэр хумсных нь завсраар наалдсан мөсийг ховхлон бутаргаж сурсан төдийгүй цангасан үедээ усан дээгүүр тогтсон мөсийг савраараа цоо цохиж чаддаг болжээ. Гэхдээ түүний хамгийн гойд чадвар нь бүхэл шөнийн салхины чиглэлийг урьдчилан

тааж мэддэг байна. Намуун дөлгөөн үдэш гэнэт хүчтэй салхи гарлаа гэхэд байрласан тухлаг дулаан нүх нь ямагт салхины эсрэг талд байхаар тохируулж модны ёроолд эсвээс голын эрэг дор нүх малтан бэлтгэдэг байв.

Бэкийн амьдралын энэ авхаалжтай чанар нь хатуу хүтүү нөхцөлд дасан хуримтлуулсан туршлага төдийгүй мөн аль эртнээс хав дараастай байсан зэрлэг араатны зөн билэг нь илрэн гарсан хэрэг ажээ. Түүний зэрэгцээ хүний гарт сургагдсаар ирсэн олон үеийнхнээсээ өвлөн авсан бүх зуршил нь оргүй арилж эхлэв. Зэрлэг ноход гүн балар ой шугуйд сүргээрээ хэсүүчлэн тэнэж харагдсан анг мөрдөн мөшгөж урж тасдан цааш харуулдаг байсан өнө эртний уг удмынх нь араншин Бэкийн үйлдэлд бадаг бүдэг цухалзан гарна. Бэк төдсөнгүй хурц соёо, хүчирхэг савраа хэрэглэж сурч чоно шиг тас зууж сурлаа. Өнө эртний удам нь чухамхүү тэгж ач тач тулалддаг байсан аж.

Улирах он цагийн уртад ч үеэс үед уламжлагдан ирсэн тэрхүү удмынх нь араншин өнөөдөр түүний жинхэнэ мөн чанар болжээ. Хав дараастай байсан тэр араншинг илрэхэд Бэк тийм араншин түүнд төрөлхийн шингээстэй, өөрөө ч мэдэж байсан мэт гайхан цочирдсонгүй эзэмшлээ.

Тэрээр хүйтэн боловч дөлгөөн үдэш хоншоороо дээш өргөн чоно шиг уртаар удтал улих нь хорвоогийн мөнх бусыг аль эрт үзүүлсэн элэнц хуланц нь хэдэн зууны туршид од мичид руу хандан тийнхүү ульж байсныг сэргээн амилуулан хэрэг ажээ.

Бэкийн улилтад цус царцам эл хуль, догшин харанхуй, тасхийм хүйтэн дотор өөрийн эрхгүй төрсөн сэтгэлийн элдэв аялгуу, тайлагдашгүй уйтгар гуниг мөн эрт дивангарын үеийнх шиг сонсогдоно.

Ийнхүү бид цөмөөрөө байгалийн хувирамтгай тогтворгүй олон зан аалийгдуулгавартай дагадаг тоглоом гэдгийг батлан нотлох гэсэн мэт Бэкийн хүдэр цээжнээс өнө эртний элэнц хуланцынх нь дуудлага багтаж ядан халин гарч тэднийхээ байдалд буцалтгүй эргэн очлоо. Энэ явдал яагаад болов гэвэл хүмүүс Умард нутаг шар төмөр олсон, тэрчилэн цэцэрлэгчийн туслах Мануэлийн өчүүхэн цалин пүнлүү эхнэрийг нь мөн өөрийг нь яг хуулсан олон хүүхдүүдийг нь мөр бүтэн, ходоод цатгалан явахад огт хүрэлцэхгүй байснаас болжээ.

### **Гуравдугаар бүлэг Зэрлэг араатан сэргэн амилав.**

Бэкийн араншинд араатны шинж төрх улам тод илрэх агаад тэгээд ч амьдралын хатуу хүтүү нөхцөлд бүр ч сэргэж давамгайлах болов. Гэхдээ тэр шинж төрх нь үл ажиглагдана. Бэкийн араншинд сэргэсэн араатны ов заль нь зөн билгээ тогтоон барихад тус болно. Түүнчлэн амьдралын шинэ нөхцөлд зохицон дасах зайлшгүй шаардлага бол ямагт соргог анхааралтай байж үймээн дэгдээж амь өрссөн тулалдаанд улгалан ухасхийхгүй, элдэв сөргөлдөөнөөс аль болохоор зайлсхийж байх ёстой байв.

Бэк тун хянуур, сэрэмжтэй байх боллоо. Яруу түргэн хөнгөмсөг хэрэг үйлдчихээс үргэлж болгоомжилно. Шпиц, Бэк хоёр бие биенээ тэсвэрлэшгүй



үзэн ядаж өшөөт дайсан бололцсон авч Бэк цухалдаж зэвүүцсэнээ ямар ч тохиолдолд ил гаргадаггүй, заналт дайснаа өддөггүй байв.

Гэтэл Шиц түүнийг хамгийн аюултай дайснаа гэж тааварласан бололтой, тохиолдол бүрийг алдахгүй урж зуухаар завдан заналхийлнэ. Бэкийн хор шарыг малтан даажигнаж аль нэгний нь үхлээр гарцаагүй төгсөх тулалдаан өдөх гэж элдэв шалтаг хайна. Гэнэтийн санамсаргүй тохиолдол гараагүй бол бүр аялалын эхэнд тийм амь өрсөн тулалдаан болчих дөхжээ.

Нэгэн үдэш Ле-Барж нуурын эрэг дээр салхи чөлөөтэй үлээсэн задгай газар хоноглохоор буудаллажээ. Пад харанхуйд хуйларсан цасан шуурга улайсгасан хутгаар зүсэх мэт хайр найргүй нүдэж аялагчид аргагүйн эрхээр хоноглохоор шийдэцгээжээ. Тэдний ард эгц хадан хясаа харлан сүндэрлэж үнэхээр тохиромжгүй тав муутай газар байв.

Перро, Франсуа хоёр нуурын мөсөн дээр түүдэг асааж унтлагын хүүдийгээ шууд мөсөн дээр засахаас өөр замгүй болжээ. Ачаагаа хөнгөлж майхнаа бүр Дайяд байхдаа орхисон байжээ. Тэд нуурын ус халих үеэр энд хаягдсан гишүү мөчир түүж гал ноцоосон боловч түүдэг нь орчин тойрныхоо мөсийг гэсгээн хайлуулаад төдөлгүй унтраав. Тэгээд оройн хоолоо хав харанхуйд идэв.

Бэк салхинаас хоргодон хадны ёроолд хэвтэр засан хэвтлээ. Франсуа түүдэг гал дээр гэсгээсэн загасыг нохдод

тарааж өгч дуудахад Бэк дулаан тухлаг хэвтрээсээ дурамжхан бослоо. Өөрт нь ногдсон хувийг идчихээд буцаж иртэл хэвтэр нь эзэнтэй болчихсон байлаа. Өөдөөс нь заналхийлж сүрдүүлсэн дуугаар архиран угтаж дулаан хэвтрийг нь түрэмгийлэн эзлэгч нь Шпиц мөн болохыг илтгэнэ. Бэк заналт дайсантайгаа нүүр тулан халз тулалдахаас өнөөдрийг хүртэл зайлсхийж ирсэн бол энэ удаа яагаад ч тэссэнгүй.

Бэкэд зэрлэг араатны араншин нь сэргэн амилав. Түүний уур хилэн бадарч ухасхийн дүүлэн дайрч гол өрсөлдөгчөө туйлын аймхай хулчгар, гагцхүү лагс том биетэй, хүч чадалтай тул өнөөг хүртэл амьд мэнд яваа гэж бодож заншсан Шпицийн гайхшийг төрүүлэв.

Хоёр нохой тас зууралдан бэлтгэн зассан хэвтрийг нураан өнхрөн гарч ирэхэд Франсуа анхандаа гайхсанаа дорхноо учрыг нь ойлгож Бэкэд хандаж:

-Уухайс даа наадахыгаа наад муу хулгайчийг сайн хашраа! гэж дэмжин хашгирав.

Шпицийн омог хилэн багтаж ядан улайрч аахилан хуцаж үсрэн дүүлэх оновчтой агшныг амдан Бэкийг тойрон 'эргэлдэнэ. Бэк хорсол заналхийлэлд автсан боловч мөн болгоомжлон Шпицийн хөдөлгөөн бүрийг харц салгахгүй ажиглана. Гэтэл удирдагчийн суурь булаацалдсан энэ тулалдааныг тасалдуулсан санаанд оромгүй хэрэг мандлаа. Энэ тулалдаан хожим, аялалын хэцүү бэрх урт замыг туулан давсны дараахан болсон билээ.

Перрогийн хараал зүхэл тавин орилох, хэрзгэр нуруунд бороохой лагхийн буух, огцом ёолон гангинасан дуу аймшигт үймээн эхлэх дохио болсон мэт цуурайтлаа. Буудал хоромхон зуур амилж саглагар үстэй амьтдаар дүүрлээ. Ойролцоох индианы гацаанаас буудлын үнэр авсан гуринхалсан зуугаад ноход давхилдан ирсэн нь энэ ажээ.

Бэк, Шпиц хоёрыг халз тулан үзэлцэж байх зуур тэдгээр урилгагүй зочид буудалд нэвтэрч Перро, Франсуа нарыг бороохойгоор зэвсэглэн ирэхэд өөдөөс нь дайрч байв. Идэх юмны үнэр авсан гуринхалсан ноход айж эмээхийг умартан улангасчээ. Нэгэн нохой хүнсний зүйл байгаа хайрцагт хоншоороо дүрэн самардахыг хармагц Перро түүний турьхан хавирганд нь бороохойгоо буулгав.

Тэгтэл хайрцаг хажуулдан хөмөрч доторхи хүнсний зүйл нь асгаран газраар нэг бутрахад өлсгөлөн ноход талх, гахайн утсан мах тэргүүтэн рүү дайран ороод үмхийн төдийхөн зүйлийг ч булаалдан уралцана. Бороохой тасралтгүй бууна. Ноход бороохойны хүчтэй цохилтод өртөн ёолон гангиналдах хир нь хүнсний зүйлийг үмхийн төдий ч үлдээхгүй ховдоглон идэж дуусгатлаа холдсонгүй.

Энэ зуур Перрогийн бүх нохой тус тусын хэвтрээс айж эмээн гарахад нөгөө догшин ноход тэдэн рүү шууд дайрлаа. Хавирга нь хэрзийсэн, хир даахиндаа баригдсан арьстай, хэлхсэн яснаас бүтсэн гэлтэй ийм нохдыг Бэк урьд өмнө ер үзээгүй, огт тааралдаж байгаагүй билээ.

Нүд нь улаанаар эргэлдэн амнаас нь хөөс цахран гоожсон, өлсөж ухаангүй болсон тэр амьтад үнэхээр аймшигтай, дийлдэшгүй мэтхарагдана. Хөллөгөөний ноход анхны дайралтад дийлдэн ухарч хаданд тулав. Бэк рүү гурван нохой зэрэг хамсан дайрч агшин зуур мөр, хоншоорыг нь хүү татчихав.

Чих дүлийрэм аймшигт шуугиан хадна. Билли бахь л байдгаараа өрөвдөлтэй гаслана. Шархдаж цусанд будагдсан Дэйв, Соллекс хоёр мөр зэрэгцэн зоригтой тулалдана.

Улайрсан Жо дайран хазаж нэгэн нохойны урд савар руу овжин дайрч соёогоо ясанд нь тултал шигтгэв.

Харин зальтай Пайк шархдаж бэртсэн нэг нохой руу үсрэн дүүлж дор нь эд бад хийв.

Амнаасаа хөөс цахруулан дайрсан нохойг үсрэн дүүлэхэд нь Бэк өрсөн амжиж хоолойноос нь зуулаа. Цус садран годгодож бүх биеийг нь будаж халуун цус амтагдахад Бэк ухаанаа алдан улам ч агсран улайрч бас нэг нохой руу дайрлаа. Тэгтэл энэ агшинд хажуугаас нь нэгэн нохой довтолж хүзүүнд нь соёогоо шигтгэв. Энэ бол Шпиц итгэл эвдэн гэнэдүүлэн дайрсан хэрэг байлаа.

Перро, Франсуа хоёр буудлын нэгэн хэсгээс дайрагчдыг хөөгөөд ноходдоо туслахаар ирлээ. Тэднийг гүйлдэн ирэхэд өлсөж улангассан ноход ухрав. Бэк энэ зуур хүзүүнд нь соёогоо шигтгэн зуусан Шпицийг огцом сэгсрэн биенээсээ салгав. Хоромхон зуур бий болсон нам гүм дахин эвдэгдэв. Индианчуудын ноход хөллөгөө рүү ахин дайрч Перро, Франсуа хоёр хүнс хоолоо хамгаалахаар тийшээгээ ухасхийн харайв. Билли нохой амь дүйсэн зориг гарган улангассан нохдын хүрээг цөмлөн сэтэлж нуурын мөсөн дээгүүр зугтлаа. Түүний араас Пайк, Даб дараа нь Перрогийн бусад ноход ухасхийн даган давхив. Бэк мөс рүү харайн орохоор завдах зуур Шпиц аюултай байдалд орсныг нь далимдуулж гэнэдүүлэн унагах санаатай ойртон ирснийг нүднийхээ булангаар харж амжлаа.

Бэк ойччихвол араас нь мөр мөшгөн элдэж буй нохдын хөлд үрэгдэн тастчуулж амиа гарцаагүй алдах юм. Тийм учраас Бэк түр зогтусан биеэ хөвчлөн Шпицийн Дайралтаас бултан зайлаад бусдынхаа араас нуурын мөсөн дээгүүр давхилаа.

Хэсэг хугацаа өнгөрсний дараа хөллөгөний бүх есөн нохой цугларч ойд орж нуугдав. Тэднийг мөрдөн хөөхөө оольжээ. Тэд үнэхээр хөөрхийлөлтэй харагдана. Нохой болгон дөрөв таван газраа шархтай, зарим нь ч айхтар хүнд бэртжээ. Дабын хойд хөл сүрхий бэртэж Доллигийн (Дайя сууринд байхад авчирсан, хөллөгөөнд бусдаасаа хамгийн сүүлд орсон нохой ажээ.) хүзүү хэгз татуулан харлаж Жогийн нэг нүд сохорчээ. Чихээ тасдуулсан Билли шөнөжин тасралтгүй гангинан гаслав. Тэд үүрээр л хөлөө зөөн буудалдаа сажилж ирэхэд тонуулчин ноход алга болсон байлаа.

Франсуа, Перро хоёр багартлаа уурлажээ. Хүнснийх нь бараг талаас илүү хэсгийг устгаж түүгээр ч барахгүй хөллөгөөний сур, бэржээхэн бүтээлгийг хүртэл хэмлэн хуу урж тастжээ. Гуриналсан ноход хоолой давуулчихаж болохоор юм болгонд хошуу дүржээ. Перрогийн хандгайн арьсан гархи гутлыг

тастчин идэж суран татлагыг хэмлэн зулгааж тэр ч байтугай Франсуагийн шилбүүрийг хоёр фунт хиртэй богиносгожээ. Хөтөч шилбүүрээ харамсан ширтэж байснаа шархадсан ноход руугаа харцаа шилжүүлж:

- Ээ хүүхдүүд минь дээ, ямар ч их хазуулж бэртээв дээ? Галзуурчих вий дээ, бүгдээрээ ч галзуурч магадгүй шүү дээ чөтгөр алгад! Перро чи юу гэж бодож байна? гэлээ.

Перро сэтгэл түгшин толгой дохив. Доусон хот хүртэл дахиад дөрвөн зуун бээр зам туулаххэрэгтэй, ноход л бүү галзуураасай билээ. Хоёр цаг хараал урсган гар хамхихгүй хөдөлж байж хөллөгөөгөө бэлтгэв. Ноход хөндүүрлэх шархаа тэвчин чаргануудыг чирэн аян замын хамгийн хэцүү хэсэг рүү гарлаа. Тэд урьд нь аян замын аль ч хэсэгт ийм төвөгтэй хэцүү байдалд орж байгаагүй билээ.

Гучин бээр урт гол нэлдээ арай хөлдөж амжаагүй ажээ. Голын ширүүн урсгал янгинах хүйтэнтэй сөрөн тэмцэж зөвхөн гүехэн тохой хавьдаа л мөстжээ. Тэд гучин бээр газрыг бүтэн зургаан өдөр байдаг хүч чадлаа шавхан дайчилж сая нэг тууллаа. Урагшлах алхам бүрт хүн нохой хоёрын алинд ч нэгэн адил ялгаагүй үхэл 'заналхийлнэ. Өмнө зам гарган явсан Перро арав хорин удаа мөсөнд цөмрөн харз усанд ойчжээ. Урт саваа модоо харз усан дээгүүр хөндлөн тогтох байдлаар дандаа барьж явсны ачаар уснаас гарч дөнгөж байв.

Өвлийн жавар улам чангарч халуун хүйтний хэмжүүрийн заалт тэгээс доош тавин хэмээс дээшлэхгүй байв. Перро харз усанд "шумбасны" дараа тухай бүр түүдэг гал асааж хөлдөж осгох үхлийн аюулаас сэрэмжлэн хувцсаа тайлан хатаана.

Перро юунаас ч үл айх ажээ. Чухам тийм учраас л түүнийг Засгийн газрын зарлигаар томилсон юм. Перро юунаас ч үл зүрхшээх агаад атираатай эцэнхий царайгаа тачигнах салхинд шавхуурдуулан үүрийн гэгээнээс үдшийн бүрэнхий нөмөртөл өдөр бүр учрах аливаа бэрхшээлийг даван туулж ямагт урагш тэмүүлнэ.

Голын зэвүү даасан эргийн зайрмагтан хөлдсөн ирмэгээр мөс шажигнан дуугарч хөл дор намалзан хавталзаж агшин ч саатан зогсох аймшигтайг үл хайхран шийдмэг алхана. Нэгэн удаа мөс цөмрөн Дэйв, Бэк хоёр чаргатай хамт усанд ойчиж золтой л үхсэнгүй, осгох шахахад нь татаж гаргажээ.

Мөсөөр хучигдсан нохдын амийг аврахын тулд Перро, Франсуа хоёр түүдэг гал ноцоож нохдоо түүдэг гал тойруулан бараг л үс нь хуйхран шажигнатал түлэгдэм ойрхон давхиулжээ.

Бас нэгэн удаа Шпиц цөмөрч унахдаа Бэкийг хүртэлх бүх нохой татагдан ороход эргэн тойронд нь мөс шажигнан хагарах боловч Бэк гулгамтгай мөсөн дээр тогтож үлдэхийн тулд хамаг хүчээ шавхан урд хөл дээрээ тулан гэдрэг чангаахад ард нь явсан Дэйв бас бүх тэнхээгээрээ арагш чангааж түүнчлэн чарга дагаж явсан Франсуа бас хойш нь булчин шөрмөсөө сунатал чангаажээ.

Чингээд урагшилж явтал нэгэн удаа голын эрэг хавьд мөс гэнэт хөллөгөөний өмнө ард зэрэг цөмөрчээ. Тэгээд хэцүү байдлаас амьд мэнд ангижрахын тулд хажууд дүнхийсэн эгц хад өөд авиран гарч давах л цорын гани найдвартай боломж байлаа. Перрог аз сорин эгцхана өөд мацан гарах зуур Франсуа дээш ширтэн энэхүү аймшип авиралт бүтэмжтэй дуусаасай билээ хэмээн бурханд залбиран зогсож байв.

Хоёул хөллөгөөний бүх сур, оосрыг залгаж уяад нохдоо эгц хад өөд нэг нэгээр нь татаж гаргалаа. Тэгээд бүх чарга, ачаагаа гаргаж дууссаны дараа хамгийн сүүлд Франсуа эгц хад өөд мацав. Ингэсний дараа дээш гарч ирсэн шигээ эгц хадан дээрээс буух тохиромжтой газар эрж баахан удлаа. Шөнө болоход тэд

голын мөсөн дээгүүр явж байв. Энэ өдөр дөнгөж дөрөвхөн бээр газар урагшилжээ.

Мөс баттай зузаарсан Хуталинка гол хүрэх замд Бэк айхтар их ядарчээ. Бусад ноход ч мөн түүнээс дутахгүй эцэн цуцжээ. Тэгсэн ч Перро алдсан цаг хугацааг нөхөхөөр шийдэж шавдуулан зогсолтгүй урагшилна. Тэд эхний өдөр гучин таван бээр зам туулж Том хулд загас хэмээх худалдаг бэлтгэлийн тосгонд ирж хоноглов. Дараа өдөр нь дахиад гучин таван бээр явж Бага хулд загас сууринд хүр<sup>^</sup> гуравдахь өдөр нь бүр дөчин бээр зам туулж Таван хуру<sup>^</sup> хэмээх сууринд дөхөж очлоо.

Бэкийн хөл Умард нутгийн нохдынх шиг шөрмөслөг чанга биш байв. Түүний зэрлэг удмынхны хамгийн сүүлчийн нохойг агуйн хүн юм уу голын хөвөөнд босгосо!-овоохойд суудаг хүмүүс гаршуулан сургасан тэр балар цагаас хойш түүний үүлдрийн ноход цөм тоймгүй олон үе удмаараа улам бүр танхилуун булбарай болсон ажээ. Бэ<sup>^</sup>

хөлийнхөө янгинах өвчнийг бүхэл өдөржин тэвчин догонцон гэлдэрч үдэш болж буудаллахад газар үхэх мэт <sup>нам</sup>унаад өгнө.

Нохдод загас тараахад хичнээн ч их өлсч байвч өндийх ч чадалгүй болсон учир Франсуа ирж ногдсон хувийг нь тус бүрт нь өгнө. Франсуа өдөр бүр хагас цаг хиртэй түүний хөлийн тавхайг үрдэг төдийгүй арьсан гутлынхаа түрийнээс огтлон авч Бэкийн дөрвөн хөлийн уланд дэгтий хийж өмсгөжээ. Ингэсэн нь Бэкийн зүдрэлийг бага ч атугай нимгэлжээ.

Франсуа нэгэн өглөө Бэкийн хөлд нөгөө дэгтийгээ углахаа мартчихсанд нохой гэдрэг харан хэвтээд өнөөх дэгтийг хөлд нь өмсгөхөөс нааш замд гарахгүй гэж тунисан мэт дөрвөн хөлөө сарвалзуулан байхыг хараад Перрогийн атираатай царайд хүртэл инээмсэглэл тодорчээ. Даан удалгүй Бэкийн хөлийн ул хатуурч урагдаж цоорсон дэгтийний ч хэрэггүй болжээ.

Пелли голын эрэгт буудаллаж хоносны маргааш өглөө нь нохдоо хөллөж байтал урьд нь өдий хүртэл ямар ч сэжиг төрүүлэм авир ажиглагдаагүй Долли гэв гэнэт галзуурав. Тэр нохой чоно шиг аймшигтай, зүрх зүсмээр гаслан ульж бусад ноход цочирдон айсандаа үс нь сэрвийн босов. Тэгснээ Долли гэнэт Бэк рүү шууд ухасхийхэд амьдралдаа анх удаа галзуу нохой үзсэн Бэк тийм нохойноос болгоомжлон холдох ёстой гэдгийг мэдсэнгүй.

Гэвч зөн билгээрээ огло үсэрч түүнээс зайлж давхилаа. Бараг нисэх мэт дүүлэхэд Долли араас нь ганцхан үсрэлтийн зайтай хүндээр аахилж амьсгаадан амнаасаа хөөс цахруулан элдэнэ. Бэк айх сэтгэлд хөтлөгдөж Долли галзуурсандаа хоёулаа ухаан жолоогүй Давхих агаад нэг нь гүйцэхгүй, нөгөө нь холдон тасарч чадахгүй хөөцөлдсөөр байв.

Бэк битүү харлах бутан дундуур шурган гарч хүйлсийн адагт хүрээд бөөн мөс шавааралдсан хоолойг гаталж бас нэгэн хүйлс дээр гарч дахиад нэг хүйлс руу ухасхийв. Тэрээр дугуйран голын гольдрил руу буцан ирж мөсөн дээгүүр сандран давхив. Бэк эргэж харахгүй боловч ард нь ганц үсрэлтийн зайтай мөшгөн яваа Доллигийн архирахыг сонсон хурдална. Тийнхүү дөрөвний нэгэн бээр хиртэй давхиснаа Франсуа дуудахыг гэнэт сонсмогц эргэж бахардах шахам арайхийн амьсгаадсаар Доллигоос ганцхан үсрэлтийн зайтай түрүүнд давхин Франсуа руу зүтгэв. Хөтөч л аврах болов уу гэсэн ганц найдвар үлджээ Франсуа сүх далайж цохиход зэхэн зогсч байснаа Бэкийг хажуугаар нь давхин өнгөрмөщ галзуурсан Доллигийн толгойд буулгалаа.

Хүч тамир нь барагдсан Бэк оволзох амьсгаагаа дарж ядан чарга уруу хөлөө арай ядан зөөсөөр сажлан ирэхэд Шпиц тэр даруй түүний арчаагүй болсныг

далимдуулан шууд дайрч ямар ч эсэргүүцэлтэй тулгараагүй тул зуугаад авлаа. Франсуаг дөхөж иртэл Бэкийг хоёр ч удаа ясанд нь тултал соёогоо шигтгэн зууж хүү татаж амжив. Шпицийн толгой дээр ташуур гялсхийн бууж заналт дайсан нь хөллөгөөний ганц ч нохой урьд нь хүртэж байгаагүй хатуу шийтгэл амсч байхыг Бэк сэтгэл

хангалуун ширтэнэ.

- Шпиц гэж ёстой чөтгөр юм даа! Бэкийг хэзээ нэг цагт хэмлэнэ дээ гэж Перрог хэлэхэд:

- Зүгээр, Бэк бол нэг биш хоёр чөтгөр шүгэлсэн нохой. Би үүнийг байнга ажиглаад байгаа юм. Бэк нэгэн сайхан өдөр чиний Шпицийн улаан голыг тасалчихаас сийхгүй дээ, харж л байгаарай, яг л тэгэх вий! гэж Франсуа сөргөв. Энэ явдлаас хойш Бэк, Шпиц хоёр илт дайсагналцах болжээ. Хөллөгөөний хүндтэй түүчээ, удирдагч болсон Шпиц Өмнөд нутгийн жигтэй хачин энэхүү нохой өөртэй нь өрсөлдөнө гэдгийг мэдээд байжээ. Бишгүйдээ л зам нийлж байсан Өмнөд нутгийн олон нохой урьд нь буудалласан үед ч аян замын уртад ч энэ нутгийн ноходтой эн зэрэгцэж байсан удаа ер үгүй учраас Бэкийг Шпиц хачирхан гайхдаг байв.

Өмнөд нутгаас ирсэн ноход бүгд л дэндүү танхил; тэгээд ч хүч хүрэмгүй хүнд ажил, хүйтэн, өлсгөлөнд дийлдэн төдөлгүй амь үрэгддэг байлаа. Гэтэл Бэк шал ондоо, бүхнийг тэсвэрлэн давж амьдралын шинэ нөхцөлд зохицон дасаж энэ Умард нутгийн нохдоос хүч тэнхээ, догшин араншин, зориг зүрхээрээ ер дутахгүй ажээ. Түүний зэрэгцээ бусдыг захиран удирдахыг тэмүүлдэг, улаан цамцтай хүний бороохойны аймшигт цохилтод урьдынх нь ид хав, зориг нь далдарч түргэн бадардаг уур омог нь дарагдсан дээрээс бүр ч аюултай өрсөлдөгч болжээ. Тэр атаархам зальтай, бусдыг тэргүүлэхийг эрмэлзэн тэмүүлэхдээ аятай боломжийг зэрлэг араатны зангаараа гайхам тэвчээртэй хүлээж чаддаг юм.

Тэргүүлэн удирдахын төлөө үхлийн тулаан гарцаагүй болох ёстой байсан агаад Бэк ч үүнийг хүсч байв. Чухам яагаад хүсэв гэвэл түүний мөн чанар ийм хийгээд замд амьсгаагаа хураатал зүтгэдэг, хөллөгөөг баяртайяа чирдэг, хөллөгөөнөөс хөөчихвөл сэтгэлээр унаж үхэхэд хүрдэг хөллөгөөний нохдын үл тайлагдах бахархал түүнийг бүрмөсөн эзэмджээ.

Дэйвийг хөллөгөөний голд оруулахад тэр бахархал нь сэргэж тэр бахархлынхаа хүчээр Соллексийн чадал тэнхээг шавхартал нь хөллөгөөнд зүтгүүлдэг ажээ. Тийм бахархал аян замд гарах цаг ирэхэд ууртай ярдаг амьтдыг хүч тэнхээ дүүрэн, нэр төрөө хичээсэн, ядарч цуцахыг мэдэхгүй хөдөлмөрч болгон танигдашгүй өөрчилдөг. Энэ бахархал нохдыг бүхэл өдөржин зогсолтгүй урагш залж үдэш буудаллахад л зөвхөн алдагдаж гунигт зовиур, сэтгэл эс ханасан байдал болон хувирдаг.

Хөллөгөөний удирдагч Шпиц чухамдаа тэрхүү мэргэжлийн бахархлаасаа болж хөл алдаж суран тоногтоо орооцолдон мунгинаж эсвэл өглөө хөллөгөөнд орох цаг болчихоод байхад хаа нэгтээ нуугдаж хоргодсон залхуу нохдыг зууж шийтгэнэ. Чухам тийм бахархлаас болж Бэкийг өөрийнхөө оронд хөллөгөөний түүчээ болгочих вий гэж Шпиц айж мөн тэр бахархлаас болж Бек түүчээ болох гэж эрмэлзэж байлаа.

Бэкудирдагч болох гэж одоо илттэмцэх болов. Шпиц болон түүний шийтгэх гэж заналхийлсэн залхуурч хойргошсон нохдын дундуур зориуд ордог боллоо. Нэгэн шөнө их цас орж өглөө нь залхуу, дандаа л арга заль хайдаг Пайк хөллөгөөнд ирсэнгүй. Пайк цасан дотор гүн нүх ухаж нуугдсан агаад Франсуа

түүнийг олохгүй удтал дуудлаа. Шпиц уурлаж байж магадгүй гэсэн газар болгоныг үнэрлэн шиншилж цас малтан аймшигтай архирахад Пайк түүний архирахыг сонсон нүхэн дотроо айж эмээгээд бүх бие нь дагжин чичирч байжээ. Пайкийг сая нэг олж хоргодсон нүхэн дотроос нь гаргахад Шпиц түүнийг хашраахаар дайрахад Бэк гэнэт ухасхийн түүний өмнүүр нь орлоо. Гэнэт овжин дайрсан учир Шпиц арагш шидэгдэн хөл дээрээ тогтож чадсангүй ойчлоо. Айж хулчийсан Пайк ой гутам дагжин чичирч байснаа ийм илт сөргөлдөөн үүссэнд агшин зуур сэргэж ялагдсан удирдагч руугаа дайрлаа. Шударга тулалдаан гэгчийг аль хэдийнээ умартсан Бэк ч бас Шпиц рүү давшиллаа.

Энэ явдал Франсуаг хөгжөөсөн боловч шударга ёсыг сахиу; >ах нь зүйтэй гэж үзээд ташуураа байдгаар нь далайж Бэкийг шавхуурдав. Гэвч цасан дээр ойчоод босож амжихгүй байгаа өрсөлдөгчөөсөө Бэк салахгүй байсанд франсуа ташуурын ишээр цохилоо. Хүчтэй цохилтод өртсөн Бэк арагш ухрав. Франсуа түүнийг ташуураар хэдэнтээ ороолгох зуур Шпиц давхар хэрэг үйлдсэн Пайкийг зэгсэн шийтгэлээ.

Доусон хот хүртэл явсан дараагийн хэд хоногт Шпиц сахилга алдсан нохдыг шийтгэхээр завдах бүрд Бэк ойр хавьд Франсуа харагдахгүй бол тэднийг өмөөрөн тулалдах болов. Бэкийн ийм нууц өдөөн хатгалга нь сахилга алдагдахын дохио мэт болж хөллөгөөний дэг журам улам улам муудав. Гагцхүү Дэйв, Соллекс хоёр л урьдын адил дуулгавартай, бусад ноход улам олиггүй зан гаргах болов.

Байдал эрс дордож нохдын хэрүүл зодоон тасрахаа болилоо. Байдал ийнхүү бэрх болсны гол буруутан нь Бэк байлаа. Энэ хоёр нохой хэзээ нэгэнт цагт үхэх сэхэхээ үзэлцэн гарцаагүй тулалдана гэхээс Франсуа болгоомжлон ямагт сэтгэл зовж явах болжээ. Шөнө ноход хоорондоо архирагдан уралцах чймээгээр тэр нэг биш удаа сэргэж Бэк, Шпиц хоёрыг болов уу гэж айж уутан хөнжлөөсөө сугаран босдог байлаа.

Гэвч амь өрсөн тулалдаан үүсэх бололцоо одоохондоо гараагүй, тэднийг нэгэн бүрхэг өдөр Доусон хотод хүрч ирэхэд ч тэр тулалдаан хараахан болоогүй байжээ.

Доусон хотод хүн их, ноход бүр ч олон ажээ. Энд ноход цөм ажилладагийг Бэк ажиглаж мэдлээ. Хотын төв гудамжаар бүхэл өдөржингөө олон нохой хөллөсөн тэрэг ийш тийш тасралтгүй хөврөх агаад шөнө ч ялгаагүй хонхны дуу үл тасрана. Ноход байшин барих гуалин, түлээ мөн уурхай руу элдэв ачаа зөөнө. Сант-Клара хөндийд морьдын гүйцэтгэдэг ажлыг энд ноход хийдэг байна. Нохдын дотор Өмнөд нутгийн үүлдрийнхэн хааяа тааралдах авч голдуу нутгийн үүлдрийн чонын угсааны ангууч ноход байх ажээ. Тийм ноход шөнө болгон яг ес, арван хоёр, гурван цагт шөнийн аймшигтай, битүүлэг дуугаа дуулан ульдаг байлаа. Бэк ч тэдэнтэй дуртайяа нийлэн улих болов.

Тээр дээр умард зүгийн хүйтэн улбар туяа татаад огторгуйд одод анивчин цасан хунгарт битүү хучигдсан хөлдүү газар шөнийн цагт ноход дуу дуугаа авалцан уртаар сунжруулан гунигтайгаар улихын хамт үе үе цурхирах мэт гаслантайяа гангинах уйтгартай аяс үгүйсэн бол амьдралын уриа гэмээр санагдана.

Энд амьдралын барагдашгүй зовлонд гутран цөхөрсөн ая сонсогдоно. Энэ бол эртний дуу, хорвоо дээр бий болсон балар үеийн өвгөдийнх нь дуу, тэр цагийн идэр залуу хорвоогийн гуниг дүүрэн дуунуудынх нь нэг ажээ. Тоймгүй олон үеийнхний уйтгар гуниг, цөхрөлөөр дүүрэн энэ дуун Бэкийгхачин гайхмаар догдлууна. Тэрээр үл таних нохдын дуутай дуу хоолойгоо нийлүүлж зэрлэг

эртний удмынхаа амьдралын зовлонд тарчилж тэсвэрлэшгүй хүйтэн, пад харанхуй шөнийн нууцаас айж гаслан ульж байсныг мөн давтах ажээ. Зовлонд ганихарснаас үүссэн эртний энэ дуу Бэкийг догдлуулж байгаа нь хэдэн зууны туршид хүний голомт түшсэн гэрийн амьдралаас тэрхүү улилт төрж байсан эрт цагийн зэрлэг үеийн хэвшилдээ эргэлтгүй татагдан тэмүүлж байгааг нь илтгэнэ. Тэд Доусон хотод ирж долоо хоноод буцах замдаа гарч Юкон голын эгц эргээр уруудаж Дайя, Давстай ус суурин руу зүглэлээ. Перро энэ удаа Доусон хотод авчирснаасаа илүү яаралтай шуудан авчээ. Үүний зэрэгцээ сэтгэл нь хөөрч энэ оны хурдны дээд амжилт тогтоохоор шийджээ. Тийм; зоримог шийдвэр гаргахад хэдэн аятай зүйл нөлөөлж байлаа. Ноход бүтэн долоо хоног амарч хүч тэнхээ сэлбэжээ. Тэдний гаргасан замаар нь олон аянчин цувж цас сайн дагтаршжээ. Түүний хажуугаар цагдаагийн газраас зам дагуу хүн, нохойд зориулсан хүнсний хоёр, гурван цэг байгуулсан болохоор буцах замд ачаагаа хөнгөлөх боломж гарчээ.

Тэд анхны өдөр гэхэд л Юкон голын эргээр тавин бээр зам туулж хоёр дахь өдрийн үдэш болоход Пелли голд дөхөж очжээ. Нилээд зовж байж ийм гайхам хурдтай явсан байна. Учир нь Бэкийн зориуд хатган өдөөсөн самуунаас болж хөллөгөөний нийцтэй ажиллагаа эвдэрч нохой бүр толгой мэдэн дур зоргоороо аашлах болов. Бэкийн өмгөөлөлд оодорсон ноход байн байн дүрсгүйтнэ.

Шпицийг хөллөгөөний удирдагчийн хувьд хүндлэн түүнээс айж байх ёстой атал одоо бүр тоохоо больжээ. Зөвхөн Бэкээр барахгүй бусад нохой хүртэл Шпицийн тэргүүлэх үүргийг зөвшөөрөхгүй байлаа. Нэгэн үдэш Пайк том толгой гарган Шпицэд ногдсон загасны хагасыг хулгайлаад Бэкийн хамгаалал дор амтархан идэв. Бас нэг удаа Даб, Жо хоёр Шпиц руу эсэргүүцвэл зохих ёсны хариу барина шүү гэдгийг сануулан улайм цайм дайрчээ. Түүгээр ч барахгүй номхон дөлгөөн Билли хүртэл угийн эелдэг зангаа хаяж урьдын адил зусардан царайчлахаа больжээ.

Шпицийн хажуугаар өнгөрөх бүрдээ Бэк сэрвээийнхээ үсийг босгон архирна. Бүр зодоонч маягтай явж савхийвэл Шпицийн өмнүүр давлиун таахалзан холхих болов.

Хөллөгөөний дэг журам алдагдсан нь бусад нохдын харьцаанд ч нөлөөлжээ. Тэд урдынхаасаа бүр ч олонтаа Хэрэлдэн зодолддог болж буудалласан газар заримдаа аймшигт тулалдааны талбар болон хувирна. Гагцхүү Дэйв,

Соллекс хоёр хэнэггүй байх боловч эргэн тойронд нь үргэлж болдог хэрүүл зодоонд зэвүүцэн уурсах болов.

Франсуа үл ойлгогдох үгээр хараал урсгаж уур хилэндээ шатан газар дэвсэлж үсээ зулгаана. Нохдыг байсхийгээд л ташуурдан зандчих боловч олигтой үр дүн өр алга. Франсуаг буруу хармагц дахиад л зодоон үүснэ. Франсуа Шпицийг, Бэк бусад нохойг өмөөрөн хамгаална. Энэ бүхний гол буруутан нь Бэк гэдгийг Франсуа лавтайяа ойлгож байсан хийгээд Франсуа үүнийг ойлгож байгааг Бэк ч бас мэдэж байв. Гэвч Бэк тун зальтай тул шууд илчлэх бололцоо олгохгүй байлаа. Тэгээд ч хөллөгөөнд сайн явах бөгөөд энэ нь түүний баяр бахдалыг төрүүлнэ. Түүний ээрэгцээ хамт зүтгэж байгаа нохдынхоо хооронд зориуд зодоон өдөөж үүсгэчихээд дараа нь үйлдсэн хэргийнхээ мөрийг баллаж байх нь улам ч бахтай ажээ.

Нэгэн удаа Тэхкин голын адагт буудалласан үдэш Даб оройн хоол идсэний дараа гэнэт туулай харангуут ухасхийсэн боловч хожимдож алдчихлаа. Тэгтэл сүрэг нохой цөм босож олзны хойноос элдэн давхилаа. Зуугаад алхмын зайтай газарт байсан баруун хойд замын цагдаагийн цэгийн тавиад ноход ч мөн энэ

анд нийлэн оролцлоо. Өнөөх туулай голын мөсөөр давхин гарч хөддсөн горхины зүг эргэж гүн хунгар цасан дээгүүр хөнгөн үсрэн зугтана. Түүний араас хүнд биетэй ноход хунгар цасанд шигдэн урагшилна.

Бэк жар гаруй нохойн түрүүнд сэтгэл хөөрсөндөө гангинасхийн сунан дүүлэн давхих боловч туулайг гүйцэж үл чадна. Түүний хүдэр цогцос сарны бүдэг цагаан гэрэлд гялс гялхийн дүүлж үзэгдэнэ. Туулай тасхийм хүйтэн шөнө цагаан хий үзэгдэл мэт урьд нь дэгдэн давхина.

Жилийн нэгэн тодорхой улирал болоход хүмүүсий' шуугиант хотоос гаргаж балар ой шугуй, эзгүй талаар

хэсүүчпэн амьтай голтой бүхнийг үрлэн сум хайрлаж гамнахгүй буудах дон шүглүүлдэг тэр балар цагийн зөн Бэкэд одоо сэргэжээ. Тэр зөнд нь цусанд шунах, амьтны голыг таслан баясах нь зүй ёсны ажээ. Бэк олзны хойноос өсгий даран хөөж байхдаа маханд тачаалдан шунаж соёогоо шигтгэж халуун цусанд хоншоороо нүдэндээ тултал дүрэн амтлахаар өрсөлдөн давхилдаж буй сүрэг нохдын хамгийн түрүүнд явна.

Амьдралын хамгийн дээд оргил болох хөөрөл байдаг. Энэ хөөрлийн үед амьдралыг бүрэн дүүрэн мэдрэхийн зэрэгцээ өөрийгөө болон орчин тойрноо бүрмөсөн умартдаг нь гайхалтай. Ийм баяр бахдал, онгод нь орсон уран бүтээлчийг эзэмддэг билээ. Мөн тийм хөөрөл тулалдааны талбарт цэрэг эрийн сэтгэлийг бүрмөсөн эзэмдэж энэрэл өршөөлийг умартуулдаг. Бэк чухам тийм хөөрөлд автаж нохдын сүргийг манлайлан сарны гэрэлд өмнө нь сүүмэлзэн зугтаж байгаа олзыг өнө эртнээс уламжлагдан ирсэн чонын ялалтын уухайг давтан алдалгүй мөрдөнө.

Энэхүү хөөрөл түүний мөн чанарын үл мэдэгдэх гүнээс ундарч эрт дивангарын цагт буцаан аваачна. Түүнд амьдралын хамаг сайн сайхан амтагдаж булчин мах нь зангирч судас бүр нь гүрэлзэж амьдралын баясгалан одод түгсэн тэнгэрийн дор царцан хөлдсөн талаар энэ улангассан давхилтад шингэжээ.

Ухаанаа умартан улайрсан үедээ ч тайван байж хянамж сэрэмжээ алддаггүй Шпиц, нохдын сүргээс тасарч гол огцом эргэдэг хошуурсан газрын түүгээр туулайг амдан Давхив. Үүнийг Бэк огт анзаарсангүй, голын тохойгоор зргэлтэл өмнө нь туулайны цагаан дүрс сүүмэлзэн холдов. Тэгтэл түүнээс хавьгүй том цагаан дүрс эргийн ирмэгээс Үсрэн туулайны чанх өмнө буулаа.

Туулай огцом зогтусаж эргэх гээд амжсангүй. Шпиц үсрэлт дундаа туулайны нуруунд соёогоо шиптэхэд туулай тарчлан аймаар чарлаад дуу нь тасрав. Бэкийн араас давхин ирсэн ноход агшны өмнө цалгин байснаа үхлийн саварт өртсөн амьдралын эцсийн чарлааныг сонсонгуут зэрлэгээр баярлан гангиналдав.

Гагцхүү Бэк дуугарсангүй, тэр чигээрээ Шпиц рүү гялсхийн дүүлэв. Гэвч дэндүү хурдан хөдөлсөндөө хоолойноос нь зууж амжсангүй. Хоёул газар унаж цас будраан өнхрөв. Шпиц ойчоогүй мэт агшин зуур тэвхийн босоод Бэкийн мөрнөөс нэг хазсанаа хажуу тийш холбирон зайлав. Эрүү нь нэг нийлэхээрээ хүн гар хүрэхээс нааш ер салдаггүй хавхны шүд шиг соёо нь хоёр ч удаа тасхийн нийлж салаад гагцхүү дахин оновчтой дайрах гэж хажуу тийш үсрэн холдов.

Шпиц шүдээ ярзайлган архирна. Шийдвэрлэх мөч нэгэнт ирж үхэх сэхэхээ үзэх цуст тулалдаан эхэлснийг Бэк ойлгов. Хоер нохой чихээ хулмайлган архирч дайрах таатай хоромыг сэрэмжтэй анан бие биеэ тойрон байх зуур энэ явдлыг хэзээний мэддэг, цасанд битүү хучигдсан цав цагаан ой, цагаан тал, сарны үлбийсэн туяа, амь өрссөн тулалдааны хөөрөл бахдал энэ бүхнийг урьд нэг



цагт дайран өнгөрсөн юм шиг Бэкэд гэнэт санагдав. Орчны юмс цасан цагаан нам гүмд умбажээ. Ойр хавьд модны хатсан мөчир, навчисны сэржигнэн шаржигнах чимээ ч сонсогдохгүй, нохдын амьсгаанаас савсах уур л хүйтэн агаарт алгуур хөөрнө.

Барагтайхан гаршсан чонын удмын эдгээр ноход хамсан ганц туулайг дор нь эд бад хийчихээд одоо тулалдаанд улайрсан хоёр нохойг таг дуугүй хүрээлэн бүслэв. Тэдний нүд нь гялалзаж хэлээ унжуулсан амнаас нь амьсгалах бүрт нь уур савсан агаарт хөөрөн замхарна.

Балар цагийн явдлыг давтсан энэ явдал, нөхцөл байдал Бэкэд цоо шинэ, хачин жигтэй сангадав. Тэр ч бүү хэл хэзээнээс иймэрхүү байсан, ингэх ёстой байсан юм шиг санагдана.

Шпиц их юм үзсэн туршлагатай дайсан ажээ. Тэрээр Шпицберген арлаас эхлээд Арктик, Канад, Үржил шимгүй газар хүртэл хөндлөн гулд тоймгүй олон газраар явах замдаа өчнөөн төчнөөн нохойтой таарч учирсан болгоноо дийлж эрхшээлдээ оруулж ирсэн ажээ. Шпицийн уур хилэн бадрах авч ямар ч нөхцөлд өөрийгөө захирах чадварыг гойд эзэмшжээ. Тэрбээр тастан устгах шуналд автсан үедээ ч өрсөлдөгч нь бас өөрөөс нь дутахгүй тэгж тачаадаж байгаа гэдгийг агшин зуур ч үл умартана. Хариу довтолгоог баттай няцаах бэлтгэлгүйгээр хэзээ ч түрүүлж ч үл дайрна, гарцаагүй ялан дийлэх боломж нөхцөл бүрдээгүй байхад тэмцэлдээнд өдөн довтолж байсангүй.

Энэ лагс том биетэй цагаан нохойн хоолойд соёогоо шигтгэх гэж хэдэнтээ довтлоод барсангүй. Хамгаалалт нь суларсан эмзэг газар руу нь давших бүрдээ Шпицийн соёотой тулгарна. Хоёр соёо харшилдаж нүүр ам нь нэлдээ цусанд будагджээ. Өрсөлдөгчөө залилах гэж Бэк хэд оролдоод барсангүй. Тэгээд түүний омог хилэн бадарч дайсан руугаа хэдэнтээ огцом угсран довтлов. Тэрбээр амьдралыг тэтгэсэн судасны цохилт бараг чихэнд нь сонсогдож байгаа цасан цагаан хүзүүнд хүрч хазан зуухаар ахин дахин давших авч Шпиц тухай бүр овжин бултаж түүнийг өрсөн хазчихаад холбирон зайлж амжина.

Бэк шинэ заль сэдэж Шпицийн хоолойноос зуух гэж буй дүр үзүүлж дайраад гэнэт тонгойж мөрөндөө хамаг хүчээ шилжүүлэн түлхлээ. Тэгтэл Шпицхариуд нь мөрнөөс нь хазчихаад хажуу тийш үсрэн зайлав.

Шпиц огт гэмтээгүй байхад Бэкийн хамаг бие нэлдээ цусанд будагдаж хүндээр амьсгаадна. Тулалдаан улам ширүүснэ. Тэр хоёрыг тойрон хүрээлсэн ноход аль нэг нь ялагдан ойчиход хамсан дайрч зүйл дуусгахаар таг дуугүй хүлээцгээнэ. Бэк амьсгаагаа дарж сэхээ авах гэхэд Шпиц хориглолтоос давшиж түр амсхийх боломж үл олгоно. Бэк ядарч цуцжээ. Нэг удаа бүр ойчиход нь өнөөх жараад нохой цөм дүрсхийн өндийцгөөв. Тэгээд Бэкийг гялсхийн босоход ноход дахин таг чиг болон хүлээнэ.

Хүнийг ч амьтныг ч аугаа болгодог сэтгэх чадвар Бэкэд заяасан байжээ. Амь өрсөн тулалдаанд тэр зөн билэгтээ захирагдаж байсан боловч оюун бодол нь зогсолтгүй ажилласаар байлаа. Өрсөлдөгчөө мөрөөр түлхэх өнөөх аргаа давтах гэж буй мэт Бэк дайрснаа сүүлчийн хоромд газарт наалдаж Шпицийн зүүн урд хөлийг тас зуув. Хөлийн яс шажигнан хугарч цагаан нохой одоо гуравхан хөл дээрээ тогтох болов. Бэк түүнийг унагах зорилгоор дахин гурван удаа довтлоод барсангүй, тэгэхлээр нь түрүүчийн залиа бас хэрэглэж баруун урд хөлийг нь зууж амжив.

Шпиц айхтар бэртэж өвдөн шаналж арчаагүй байдалд орсноо эс хайхран хамаг хүч тэнхээгээ шавхан хөл дээрээ тогтох гэж оролдоно. Таг дуугүй бүслэн

хүрээлсэн нохдын гялалзсан нүд, унжсан улаан хэл, амьсгалах бүрийд амнаас нь савсах уурыг харж дотор нь халуу оргиж уур омог нь багтаж ядна. Тулалдагч хоёрыг хүрээлсэн тойрог улам багасан хумигдаж ийм тойрог хумигдсаар эцэстээ ялагдсан нохойг агшин зуур нөмрөн бүчээд гүйцээдгийг Шпиц урьд олонтаа үзсэн билээ. Гэвч энэ удаа түүний дийлдэх ээлж иржээ.

Түүний хувь заяа нэгэнт шийдэгджээ. Бэк өршөөлгүй байлаа. Өршөөл энэрэл бол зөөлөн уур амьсгалтай газар

л тохирох ажээ. Бэк эцсийн шийдвэрлэх дайралт хийхээр азнасхийхэд ноход улам ойртож дэргэд нь тэдний амьсгалах сонсогдоно. Шпицийн арталд, үсрэхээр завдан газарт наалдан буй ноход тулалдагчдын хөдөлгөөн бүрийг нь шуналтайгаар ширтэн буй нүд үзэгдэнэ. Хэсэгхэн зуур нам гүм болов.

Ганцхан Шпицийн бүх бие нь дагжин чичирч хөл дээрээ тогтож ядан ойртон буй үхлийг айлган холдуулах гэсэн мэтсэрвээнийхээ үсийгбосгон аймшигтай архирна. Түүн рүү Бэк ухасхийн дайраад ухрав. Энэ удаа мөрөөрөө түлхсэн нь хэргээ бүтээжээ.

Шпиц газар унав. Тойрон хүрээлсэн ноход түүн рүү уулгалан дайрч Шпиц алга болов. Харин ялан дийлсэн Бэк энэ бүхнийг бахархалтайяа ширтэнэ. Энэ бол өрсөлдөгчөө цааш харуулчихаад ялан дийлсэндээ баярлан зогсож буй өнө цагийн зэрлэг араатан байлаа.

### **Дөрөвдүгээр бүлэг Тэргүүлэхийн төлөө тэмцэлд ялан дийлэв.**

- Энэ Бэк нэг биш хоёр чөтгөр шүгэлсэн амьтан гэж би хэлээгүй юу!

Шпиц алга болж Бэк нэл шархтай ирснийг Франсуа маргааш өглөө нь мэдмэгц ингэж хэлжээ. Тэгээд Бэкийг түүдэг галд ойртуулж түүний нуруу хажууг Перрод үзүүлэв.

- Шпиц ч ёстой жинхэнэ зэрлэг араатан шиг тулалддаг золиг доо гэж Бэкийн биед байгаа шарх, хазуулсны олон орыг харан Перрог өгүүлэхэд:

- Бэк бол түүнээс хоёр дахин илүү шазруун тулалддаг золиг доо! За одоо ч хөллөгөөний дэг ч зүгширнэ

дээ, Шпиц байхгүй болсон, хэрүүл зодоон төгсгөл болжээ гэж байрлан өгүүлэв.

Перро эд юмсаа янзлан чаргандаа ачих зуур Франсуа нохдоо хөллөв. Урьд Шпицийг хөллөдөг байсан түүчээний байр руу Бэкийг дөхөж очиход Франсуа түүнийг анзаарсангүй, хүсэл болсон байранд нь Соллексийг оруулав. Тэгтэл Соллекс руу Бэк архиран дайрч хөөгөөд өөрөө Шпицийн байранд орж зогсов.

- За за! гэж Франсуа бахдан уулга алдан гуяа алгадаж:

- Энэ Бэкийг хараач! Шпицийг цааш нь харуулчихаад одоо бас түүчээ болох санаатай, цаашаа зайл! Холд дээрэмчин минь! гэж зандрав. Гэтэл Бэк юу ч болоогүй юм шиг хээвнэг зогсоно.

Франсуа шилэн хүзүүнээс нь барьж чангаан хүржигнэн архирахыг нь эс тоон хажуу тийш зайлуулаад удирдагчийн байранд дахиад Соллексийг оруулав.

Хөгшин Соллекс Бэкээс айж түүчээ болохоос дургүйцэж хойш ухрав. Франсуа түүнийг муйхарлан чирч түүчээний байранд оруулан дөнгөж эргэтэл Соллексийг Бэк дахин хөөхөд цаадах нь дуулгавартай холдов.

Энэ удаа Франсуа уурлаж:

- Чамайг би нэг сайн хашраагаад өгье! гэж хашгираад эргэн явснаа том бороохой барьсаар ирэв.

Улаан цамцтай эрийг Бэк санаж аажуухан ухарлаа. Тэгээд Соллексийг удирдагчийн байранд хөллөхөд нь дахин довтолсонгүй, бороохойны цохилтод өртөхөөргүй холуур эргэлдэнэ. Бэк бороохой гэгч ямар их аюултай зүйл

болохыг урьд нь амсаж мэдсэн болохоор уурлан гомдонгуй архиран Франсуаг далайж цохилоо гэхэд бултан зайлж амжихын тулд бороохойноос нь харж үл салгана.

Хөтөч ажил төрлөө амжуулаад Бэкийг Дэйвийн өмнө, хуучин байранд нь хөллөх ээлж болоход сая нэг түүнийг дуудлаа. Бэк арагш хэдэн алхам ухрав. Франсуаг ойртоход Бэк бүр ч холдоно. БэкийгТ бороохойноос эмээж байна гэж Франсуа бодоод хол хаяв. Гэвч хэргийн учир бороохойд биш байлаа. Удирдагчийн байранд орохыг санаархаж байгаагаа Бэк шууд илэрхийлнэ. Бороохойдуулахаас зайлсхийсэндээ ч биш чухамдаа түүчээний байранд хөллүүлэхийг л тэр хүсчээ. Ингэх ч эрхтэй, үүнээс доогуур байранд яавч орохгүй.

Перро Франсуад туслахаар ирж тэр хоёр бүтэн цаг Бэкийн хойноос хөөцөлдөж, бороохой шидэх авч Бэк тухай бүр оногдолгүй бултан зайлна. Тэд БэкийгТ эцэг эх, элэнц хуланцийг нь, ертөнцөд мэндлээ ч үгүй байгаа дараагийн олон үеийн үр садыг нь хүртэл, ширхэг үс бүрийг нь, судсаар нь гүйж байгаа дусал цус бүрийг нь харааж зүхнэ. Хараал зүхэл болгонд нь Бэк архиран хариулж өөртөө үл ойртуулна.

Гэхдээ холдож зугтсангүй, харин хүслийг минь биелүүлбэл ахин дуулгавартай номхон болно гэдгээ хүмүүст ойлгуулахыг оролдож буудалласан газраас холдохгүй тойрон давхина.

Франсуа ядарч цөхрөн газар сууж дэмий л шилээ маажна. Перро бугуйн цагаа харснаа уулга алдан хараал урсгана. Цаг талийжээ. Бүтэн цагийн өмнө л замд гарсан байх ёстой байлаа. Франсуа шилээ маажин толгойгоо сэжээд Перро руу харж хулчгардуу жуумалзахад Перро хариуд нь хоёулаа нэг нохойд дийлдэж ялагдсанаа хүлээн зөвшөөрөхөөс дээ гэсэн шиг мөрөө хавчив.

Тэгээд Франсуа Соллекс руу очиж Бэкийг дуудав. Бэк нохойныхоо байдлаар инээд алдсан боловч нилээд зайтай зогсоод ойртсонгүй. Франсуа Соллекс нохойг удирдагчийн байрнаас гаргаж хуучин байранд нь оруулав. Хөллөгөө аян замд гарахад бэлэн болжээ. Одоо хөллөгөөнд ганцхан түүчээний байр л эзгүй байна. Франсуа дахин дуудахад Бэк мөн л ойртсонгүй.

- Наад бороохойгоо хаяач! гэж Перрог хашгирахад Франсуа үгийг нь дагав.

Бэк сая л ойртон ирж хөллөгөөний түүчээний байранд омог бардам зогсов. Түүний хүзүүнд хэтрээ оосор углаж газарт наалдан хөлдсөн чаргануудыг түлхэн хөндийрүүлэв. Хөллөгөө ухасхийн хөдөлж голын зүг хурдаллаа. Перро Франсуа хоёр хөллөгөөтэй зэрэгцэн цанаар гулсан урагш тэмүүлнэ.

Бэк бол хоёр чөтгөр шүглэсэн нохой гэж Франсуа батлан өндөр \ нэлдэг байсан агаад энэ үйл явдлаас нэг хоног өнгөрсний дараа түүнийг хамаагүй дутуу үнэлж байснаа ойлгожээ. Бэк түүчээний эрх үүргээ даруй гүйцэтгэж эхлээд Франсуагийн өдий хүртэл мэдэх хамгийн чадамгай удирдагч нохой Шпицээс ухаан самбаа, хурд, шийдмэг чанараараа хол давуу болохоо харуулав.

Гэхдээ хамгийн гайхалтай нь бусад нохойг бүрэн захирч чаддаг чанар нь гойд байлаа. Тэрээр хөллөгөөний бүх нохойг өөртөө үг дуугүй захируулж чадаж байлаа. Дэйв, Соллекс хоёр түүний мэдэлд бүрэн орсон байлаа. Хүч тэнхээгээ шавхан дайчилж чаргануудыг чирэн урагшлуулж ногдсон үүргээ биелүүлж байвал бол оо гэж тэд үзнэ. Энэ үүргээ зохих ёсоор биелүүлэхэд нь саад болохгүй л бол ямар ч муу явдлыг уучлан эвлэрэхэд тэд бэлхэн ажээ. Биллийг түүчээ болгосон ч бай ялгаагүй, хамгийн гол нь журам дэглэмийг сахиулж чадаж л байвал болоо!

Сүүлийн үед дур зоргоороо аашилж заншсан ноход дэг журам тогтоох гэж Бэкийг хатуу шаардахад машид гайхжээ. Бэкийн ард хөллүүлдэг залхуу хойрго Пайк урьд биеэ оторлон явдаг байсан бол одоо Бэкийн байнгын хайр найргүй шийтгэлд хаширч бүх хүчээ дайчлан шургуу ажилладаг болов. Ууртай Жогийг анхны орой буудаллахад л Бэк айхтар шийтгэжээ. Түүнийг Шпиц хашрааж дийлдэггүй байжээ. Бэк түүнийг биеийнхээ бүх жингээр дарж уурлан хүржигнэн архирахаа больж өршөөл гуйж гонгинотол нь хашраажээ. Хөллөгөө гайхам сайн явдаг болов. Ноход цөм хичээнгүй зүтгэж урьдын гар нийлэмжтэй ажиллагаа дахин сэргэв.

Ринк Рэпидсийн даваанд хүрэх үед Перро ахин хоёр канад үүлдрийн Тик, Кун нэртэй хоёр ангууч нохой авлаа. Бэк энэ хоёр нохойг дор нь хөллөгөөнд сургахад Франсуа дуу алдан гайхан шагширч:

- Энэ Бэк шиг гайхамшигт нохой нарт хорвоод өөр байхгүй! Нүдний гэм болсон амьтан! Ийм нохойг худалдан авахад мянган доллар ч багадна! Үнэхээр тийм шүү, Перро тийм биз? хэмээн батлана.

Перро зөвшөөрнө. Тэд энэ үед аялалын хурдны дээд хэмжээг аль хэдийнээ эвдэж өдөр өнгөрөх бүр давуулж байлаа. Тэгээд ч цас хатуурч дагтаршаад зам сайхан байлаа. Хүйтний эрч ч чангарсангүй, нэгэн хэвийн байдалд байв. Халуун хүйтний хэмжүүрийн заалт хасах тавьд хүрээд тогтов. Перро, Франсуа хоёр ээлжлэн чарганд сууж цанаар гулган явж ноход хааяа нэг зогсон түр амарч байнга цогин давхина.

Гучин бээр хол урсах гол зузаан мөсөөр хучигдаж Доусон хот орох замдаа арван өдөр туулсан замаа ганцхан өдөр явж өнгөрөв. Дараа нь тэд Ле-Барж нуураас Цагаан морин даваа хүртэл жаран бээр замыг бараг зогсолтгүй явж маш хурдан туулжээ. Марш, Тагиш, Беннет нуруудыг гатлах далан бээр замд ноход гайхам хурдтай явж Перро, Франсуа хоёр цанаар гулган хөллөгөөг дагах ээлж ирэхэд чарганд тогтоосон уяанаас барьж явжээ. Ийнхүү урагшилсаар хоёр дахь долоо хоногийн сүүлчийн үдэш гэхэд Цагаан давааг давж Скагуэй хот түүний боомтод байгаа олон хөлөг онгоцны гэрэл гялалзан анивчсан тэнгисийн зүг уруудлаа.

Тэд долоо хоногт өдөрт дунджаар дөчин бээр зам явж хурдны дээд хэмжээг эвдэж аварга амжилт тогтоов. Перро, Франсуа хоёр гурван бүтэн өдөр Скагуэй хотын төв гудамжаар ихэмсэг зугаалж тэдний очсон газар бүрд аяга тагш дарс уухыг урьж яриа өдөж наймаачид хөллөгөөг нь тойрон шавж гайхан шагширна.

Удсангүй Баруун нутгаас ирсэн хэсэг дээрэмчин хотыг тонон цөлмөхийг оролдож зоримог дайрсных нь төлөө сум хайрлалгүй сийчсэн тухайн бөөн шуугиан дэгдэж хүмүүсийн ам хамхихгүй ярьдаг сонин зүйл болж аварга амжилтын тухай мартжээ. Энэ үед Перро өөр ажилд томилогдов. Франсуа тэр тухай дуулмагц Бэкийг тэврэн Уйлав. Бэк ийнхүү Франсуа, Перро хоёрыг эцсийн удаа Харав.

Тэд Бэкийн амьдралд урьд учирсан хүмүүс эгнэгт алга болдгийн адил мөн алга болов.

Түүнийг хөллөгөөний бусад нохойны хамт нэгэн Шотланд хүнд худалджээ. Тэд бусад олон хөллөгөөний хамт Доусон хот орох хүнд хэцүү замд дахин гарав. Энэ удаа нилээд хүнд ачаатай тул дээд амжилтын тухай бодохын ч хэрэггүй байлаа. Гэвч хүнд ачаа чирч олон өдөр бараг амралтгүй явлаа. Тэд Умард туйлд алт олохоор ирсэн хүмүүст ертөнцийн өнцөг булан бүрээс ирүүлсэн шуудан тээж буй нь энэ ажээ.

Хүнд ачаа тээж амралтгүй урагшлах нь Бэкэд хэцүү боловч гаршсан ажилдаа бахархах сэтгэлдээ хөтлөгдөн махран зүтгэх хийгээд энэ нь Дэйв, Соллекс

хоёрыг ч мөн зоригжуулна. Хийж буй ажлаараа бахархаж байгаа эсэхээс үл хамааран ногдсон үүргээ нягт нямбай гүйцэтгэхийг л Бэк хөллөгөөний нохдоос шаардана.

Байдал нэг л хэвийн, өдөр бүр адилхан байх нь үнэхээр уйтгар төрүүлнэ. Өглөө бүр тогооч нар тодорхой нэгэн цагт босож түүдэг гал асааж хоол унд бэлтгэнэ. Дараа нь майхан, эд юмсаа чарганд ачаад нохдоо хөллөгөөнд оруулна. Тэгээд тэнгэрийн хаяа цайж эхлэхээс цагийн өмнө замд гарна. Үдэш болмогц буудаллана. Хүмүүс майхнаа босгож дэвсэж унтах нарсны мөчир цуглуулж бэлтгэнэ, мод хагалж ус юмуу мөс дөхүүлж тогооч нартаа тусална. Дараа нь нохдоо хооллоно.

Бэкийн адил бусад нохдод ч үдшийн цаг хамгийн баярт мөч болно. Өгсөн загасыг идэж гэдэс гарчихаад хийх ажилгүй, хөллөгөөний бараг тавиад нохдын дундуур ийш тийш дураараа сэлгүүцэж явах даан ч сайхан. Энэ олон нохойны дотор засаршгүй зодоонч ноход байгаа нь мэдээж, гэхдээ ярдаг догшин хэдийг нь Бэк гурван тулалдаанд хашраан номхруулснаас хойш түүнийг шоглон өдөх нохой үгүй болжээ. Бэкийг үсээ сэргийлгэн соёогоо ярзайлган архирахад л бүх ноход түүнээс айж үг дуугүй захирагдах ажээ.

Бэк түүдгийн дэргэд хэвтэх их дуртай. Урд хоёр савраа дэрлээд гал руу удтал ширтэнэ. Тийм үед нь Санта-«ларын нарлаг хөндийд орших Миллер шүүгчийн том байшин, шумбан нааддаг усан сан, үсгүй шахам мексик үүлдрийн Изабель, бээжин хав Тутс хааяа санагдана. Гэхдээ улаан углаа цамцтай эр, Керлийн аймшигт үхэл, Шпицтэй хийсэн цуст тулалдаан, хэзээ ч билээ тамшаалан идсэн, эсвэл тэгж тамшаалан идэхийг мөрөөдсөн амттай идэх зүйлс л голдуу бодогдоно.

Тэгсэн мөртөө төрж торнисон нутгаа санан дурсаж уйтгарлахгүй ажээ. Нарлаг нутаг бараг мартагдаж эрхэм дурдатгалаас хэтрэхгүй болжээ. Шал өөр амьдрал, эртний удмынх нь амьдралын тухай бодол түүний сэтгэлийг догдлуулна. Тийм бодол дурдатгал урьд огт үзээгүй, мэдэхгүй зүйлийг нь ч аль хэдийний танил, зүй ёсны явдал мэт сэтгэгдэл төрүүлнэ. Өдий хүртэл хав дараастай байсан зөн билэг нь (Энэ зөн билгийг нь эртний удмын дуудлага гэж нэрлүүштэй.) одоо амилж түүнийг эзэрхэн захирна.

Түүдгийн дэргэд биеэ сунган хэвтээд гал руу нойрмог ширтэн байх үед нь заримдаа энэ дөл бол эрт дээр цагт ойртон дөхөж дулаацаж байсан, өөр нэгэн түүдгийнх, энэ эрлийз тогоочийг биш шал өөр хүнийг харж байсан шиг санагдах нь гайхшийг нь төрүүлнэ. Тэр шал өөр хүний хөл нь богино, гар нь урт, энэ тогоочийнх шиг шулуун булбарай биш харин эрчилсэн олс шиг бадриун зангирсан булчинтай, унжиж налсан сагсайсан үстэй, навтгар духтай байсан аж. Тэр хүн харанхуй уруу байн байн цочин харж өвдөгтөө хавчуулсан үзүүрт нь том чулуу тогтоосон урт савааг гартаа чанга атгасан байх нь пад харанхуйгаас их айдаг бололтой, бас хачин дуу аялгуу гаргана. Чармай нүцгэн, сэмэрч Урагдсан, галын дөлд атийж хорчийсон арьс нуруундаа нөмөрчээ. Бүх бие нь битүү үстэй, хэнхдэг, мөр, гарынх нь ар тал, гуяных нь үс нэхий мэт өтгөн ажээ. Тэр хүн цээжин биеэ бөхийлгөн өвдгөө нугалан бөхийн зогсоно. Тэр хүн үзэгдэх, үл үзэгдэх аюулаас байнга айж эмээдэг бүхний адил бараг л муурынх шиг уян налархай бие бялдартай ажээ.

Тэр үслэг хүн хааяа түүдгийн дэргэд толгойгоо гудайлган тохойгоороо өвдгөө тулан нүүрээ борооны дуслас халхалж буй мэт явган сууна. Түүдгийг тал бүрээс нь хүрээлсэн харанхуйд хос хосоороо олон цог гялалзана Энэ бол араатны нүд болохыг Бэк юу эс андахав. Араатан амьтад бутан дундуур тас няс чимээ гарган дөхөн ойртох анир чимээг Бэк соргог чагнана.

Юкон голын эрэг дээр түүдэг гал залхуутайяа гөлрөн элдвийг бодож байтал гэнэт өөр ертөнцийн хачин дуу чимээ сонсогдож жигтэй дүр зураг нүдэнд нь тодрон үзэгдэхэд Бэкийн үс нь сэрвийн босож яах ч учраа олохгүй тэрүүхэндээ гонгиноно. Тэгээд эрлийз тогоочийг "Бэк хүүе, сэр, сэр!" гэж дуудахад л өнөөх дүр зураг сарнин арилж нүдний нь өмнө бодит ертөнц харагдана. Бэк өндийж ханатал унтаж нойр авсан мэт эвшээн суниана.

Аяны замд уртад хүнд ачаатай чарганууд чирсээр ноход ядарч цуцжээ. Сая нэг Доусон хотод хүрч ирэхэд үнэхээр ядарч цөхөрч нүднээс гарсан байлаа. Арав наанадаж долоо хоног хэртэй амруулж хүч тэнхээг нь сэргээх хэрэгтэй байлаа. Тэгтэл хоёр өдрийн дараа шуудан ачиж дахин замд гарч Хуарангийн даваа уруудаж Юкон голын мөсөн замд оров.

Туйлдаа хүртэл ядарсан нохдыг хөтөч нар зогсолтгүй шавдуулж хараал зүхэл урсган нэрмээс болж өдөр өнжихгүй цас орохыг нь яана. Саяхан орсон сэвсгэр зузаан цасанд чарганы ул шигдэж хүнд ачаатай чаргыг чирэн урагшлах ноход үнэхээр хэцүү ажээ. Гэвч аян замын хүнд хүчрийг ойлгодог хөтөч нар нохдыг аль болохоор хайрлан асрамжилна.

Тэд үдэш буудалламагц юуны түрүүнд нохдынхоо байдлыг шалгаж үзнэ. Тэд эхлээд нохдоо хооллож цатгах агаад тэдний саврыг эмчлэн сувилж дуусгахаас нааш унтдаггүй байлаа. Тэгсэн хэдий ч нохдын хүч тэнхээ харьж байдал улам хүндрэв. Ноход энэ өвөл хүнд ачаатай чарга чирч мянга найман зуун бээр урт зам туулаад байлаа. Тийм урт замд ямар ч хүдэр, хатуужилтай нохой гарцаагүй тамирдан сульдалгүй яахав дээ.

Бэк одоохондоо аян замын бэрхэд сөхөрч бууж өгөөгүй, бусдыгаа зоригжуулж хөллөгөөний дэг журмыг сахиулан урагшлах авч яггүй ядарчээ. Билли шөнөжин гаслан нойрон дундаа ёолж Жо дандаа баргар царайлж явдаг дээрээ бүр шалдаа бууж Соллекс уруу сохор байтугай хараатай талаас нь ойртох осолтой болжээ.

Гэвч Дэйв бүр ч илүү ядран зовж нэг л биш болсон байлаа. Тэр дандаа цухалдан дүнсгэр царайлж үдэш буудаллахаар зогсонгуут тэр даруй нүх малтан түүн дотроо шигдэн таг чиг болно. Тэгээд хөтөч хоолыг нь түүнд байнга аваачиж өгнө. Тэр үдэш хөллөгөөнөөс сулласан цагаас маргааш өглөө нь хүртэл ямар ч хөдөлгөөнгүй дуу шуугүй хэвтэнэ. Тэрчилэн зам зуур хөллөгөө гэнэт зогсох, хөллөгөөг чирэн хөдөлгөх болгонд зовиурлан ёолно.

Хөтөч нар түүний биеийн байдлыг хэдэнтээ шалгасан хирнээ учрыг олж чадсангүй. Дэйвийн энэ байдалд хөтөч нар гайхаж хоол идэж байхдаа ч унтахаар хэвтэхийн өмнө гаанстамхиа шуналтайяа татан суухдаа ч түүний тухай ярилцана. Хөтөч нар зөвлөлдөөд Дэйвийг түүдэгт ойртуулж биеийг нь базлахад тэр хэдэнтээ хөндрүүлэн ёолов. Яс нь булгарч хугарсан юм мэдэгдсэнгүй, учрыг мөн эс олж чадаад дотор биенд нь ямар нэг гэмтэл байна гэж тааварлажээ.

Тэд явсаар Кассьярын харгайд хүрч ирэх үед Дэйв бүр сульдан байн байн бүдчин унадаг болов. Тэгэхлээр нь шотланд нутгийн хүн дохио өгч хөллөгөөг зогсоож Дэйвийг суллаж голын байранд ойр байсан Соллексийг оруулахаар шийдэв. Дэйвийг өрөвдөж түүнийг хэсэг сул чөлөөтэй давхиж жаахан амраг гэж боджээ. Гэтэл Дэйв өвдөж тамирдсан хэдий ч ажлаас хөндийрүүлж байгаатай эвлэрэхийг хүссэнгүй. Хөллөгөөнөөс сулламагц тэр архиран хуцаж байранд нь Соллексийг оруулахыг хараад гаслантайяа гонгинов. Үхлүүт өвчтэй Дэйвийн бахархал хөндөгдөж өөрийг нь илүүчлэн үзэж сольсонд дургүйцэн эсэргүүцэв.

Цуваа хөдлөхөд Дэйв зам дагуу хунгар цасанд бүдчин донгонцон дагаж Соллексийг самардахаар ухасхийж эсвэл түүн рүү асан дайрч замын хажуу руу

шахан ойчуулахаар хэдэнтээ оролдов. Хөллөгөөний нохдын хоорондуур шурган орохыг санаархаж өвдсөн, гомдсондоо тасралтгүй хуцан гангинана. Шотланд нутгийн хүн холдуулахаар шилбүүрээр хэдэнтээ шавхуурдахад Дэйв хүчтэй цохилтыг үл хайхран зүтгэсээр байхад сэтгэл нь зовж ахин гар хүрсэнгүй. Дэйв цувааны араас тайван, чөлөөтэй шогшин явахыг үл хүсэх ажээ.

Тэрээр зориуд цувааны урд юм уу хажуугаар хунгар цасанд шигдэн бүдчин заримдаа шургачин урагш цөхрөлтгүй тэмүүлнэ. Төдөлгүй тамирдан газар ойчлоо. Өндийн босож чадсангүй, хажуугаар нь хурдлан өнгөрч холдох хөллөгөөг харамсалтайяа ширтэн хоцорлоо.

Гэвч Дэйв хамаг хүчээ шавхан зүтгэсээр хөллөгөөг түр амрах үед гүйцэж ирэв. Тэгээд өөрийн байранд Соллексийн хажууд зогсов. Хөтөч тамхи асаахаар түр холдоод буцан ирж хөдлөх дохио өгөв. Ноход урагш хачирхам хөнгөн хөдөлснөө цөм гайхаж дороо зогтусан зогсож нэгэн зэрэг эргэн харцгаав. Чарганууд хөдөлсөнгүй, байсан газартаа хоцорсонд хөтөч мөн мэл гайхаснаа дор нь учрыг ойлгож хамт яваа нөхдөө дуудав. Соллексийн хоёр хэтрээг Дэйв хэмлэн татчихаад чаргануудын өмнө өөрийнхөө байрандаа сэтгэл хангалуун зогсоно.

Намайг битгий хөөгөөч гэсэн гуйлт Дэйвийн харцанд тодорно. Хөтөч нар яахаа мэдэхгүй хэсэг бодлогошров. Хөллөгөөнд явах нь ноходод хэцүү боловч дадсан хөдөлмөрөөс нь хөндийрүүлэхэд айхтар гомддог тухай тэд ярилцана. Нас дээр гарсан эсвэл өвчинд баригдсан зэрэг шалтгаанаар нохдыг хөллөгөөнөөс чөлөөлөхөд тэд гомдон гуниглаж удалгүй амь тавьдаг тухай хөтөч нар элдэв тохиолдол ам .фулаалдан хүүрнэлдэнэ. Тэд удтал хэлэлцээд Дэйвийн амь тавих цаг нэгэнт ирсэн болохоор хөллөгөөнд явсаар сэтгэл амар амьсгаа хураах боломж түүнд олгох нь зүйтэй гэж шийдэцгээв.

Тэгээд Дэйвийг хөллөгөөнд оруулав. Тэр урьдын адил урагш омголон зүтгэх хэдий байн байн ёолно. Хэдэнтээ бүдчин ойчиход нь бусад нохой түүнийг тоногтой нь цуг чирэн босгов. Нэгэн удаа бүдчин унахдаа чарганд дайруулж хойд хөл нь бэртэж догонцох болов.

Гэвч үдэш буудаллах хүртэл тэвчээр заан явсаар ирлээ. Хөтөч түүнийг түүдэг галын дэргэд хэвтүүлэв. Дэйв маргааш өглөө нь цааш явж чадахааргүй болсон байлаа. Нохдыг хөллөгөөнд оруулж эхлэхэд Дэйв хөтөч рүү арай чүү мөлхөж бүх бие нь чичрэн татвалзаж хоёр хөл дээрээ өндийснөө биеэ даалгүй ойчлоо. Дараа нь тоног углуулж байгаа ноход руу элгээрээ мөлхсөөр аажим ойртов. Урд хоёр савраа сунган биеэ хураан хүчилж ганц хоёр ямх Урагшилна.

Гэвч төдөлгүй хүч тэнхээ нь барагдаж дороо хөдөлгөөнгүй хэвтэнэ. Аян замд гарсан нохдыны араас

цасан дээр хэвтсэн чигээрээ хүндээр амьсгаадан гунигтай ширтсээр хоцорлоо. Хөллөгөө эргийн дагуу явсаар ойн цаагуур далдартал Дэйвийн зүрх шимширтэл гангинах сонсогдсоор байлаа.

Хөллөгөө ойн цаана зогслоо. Шотланд нутгийн хүн дөнгөж сая хөдөлсөн газар руу буцан алхав. Удалгүй бууны дуу алсаас бөглүү сонсогдов. Өнөөх хүн эргэн ирж энд тэндгүй ташуур шилбүүр тас няс хийж хонхнууд хоршин хангиналдаж хөллөгөө эрчээ аван хурдаллаа. Бэк, бусад нохой саяхан ямар явдал болсныг мэдэж байлаа.

### **Тавдугаар бүлэг Аян замын хатуу хүтүүг тэвчээрлэн давсаар явна.**

Бэк түүчээтэй шуудан ачсан хөллөгөө Доусон хотоос гарч гучин хоногийн дараа Скагуэй хотод ирлээ. Ноход ядарч хүч тамир нь харьжээ. Бэк зуун дөч байснаа

зуун арван таван фунт жинтэй болжээ. Түүнээс жин багатай ноход бүр ч илүү туржээ. Хөтөч нарыг дандаа залилдаг Пайк хүртэл үнэхээр догонцоно. Соллекс ч мөн хазганаж Дабын дал нь мултарч яггүй зовж байлаа.

Бүх нохойны саврын ул халцарч гишгэх болгонд нь хөндүүрлэн улам их зовооно. Ноход бүдэрч унатлаа ядарчээ. Түр зуурын хэмжээлшгүй их ачааллаас болдог ядаргаа хоёр гурван цагтухтай унтахад л гарчихдаг. Гэтэл энэ удаагийн хэдэн сар тасралтгүй үргэлжилсэн хүнд хөдөлмөрийн явцад нохдын тэнхээ тамир, эрч хүч алгуур харьжээ.

Ноход ядран цуцаж хүч тэнхээгээ сэргээн сэлбэх ч чадваргүй болжээ. Хүч тэнхээ нь шавхагдаж булчин судас

бүр нь зөөлөрч их ядарчээ. Ноход тав хүрэхгүй сарын хугацаанд хоёр мянга таван зуун бээр зам туулж тэгэхдээ сүүлийн мянга найман зуун бээр замыг туулах хугацаанд дөнгөж тавхан өдөр амарчээ. Хөллөгөө Скагуэй хотод ирэхэд ноход хөл дээрээ арай ядан тогтож байлаа. Хэтрээ оосрыг чүүтэй чаатай чангаан хөдөлж газрын уруу буухдаа чирч яваа чарганууддаа золтой л дайруулчихсангүй явлаа.

- За миний хайртай хазгарууд зүтгээд бай! Одоохон одоохон! Бараг ирчихлээ, удахгүй ханатлаа амарцгаана! гэж нохдыг Скагуэй хотын төв гудамжаар арай ядан урагшлахад хөтөч ийнхүү зоригжуулна.

Хөтөч нар энд нилээд удаан саатна гэж бат итгэнэ. Үнэхээр ч тэгж бат итгэх үндэс байлаа. Тэд мянга хоёр зуун бээр замыг туулахдаа замдаа дөнгөж хоёрхон өдөр амарсан тул тавтай амрах эрхтэй юм. Гэвч төрсөн нутагтаа сүйтбүсгүй, залуу эхнэр, хамаатан садан, анд нөхдөө орхин алсын аянд гарсан эрчүүд ертөнцийн өнцөг, булан бүрээс Клондайт хуран цугларсан болохоор Альпийн нурууны оргилд бараг тулам тийм их шуудан хуримтлагджээ. Түүнээс гадна Засгийн газрын захирамж, шийдвэр ямар тасрах биш дээ.

Тийм учраас эдэлгээнд тэнцэхгүй болсон нохдыг даруй сольж замд түргэн гарч байх захирамж гарчээ. Эдэлгээ гүйцсэн нохдыг дор нь зарж борлуулах хэрэгтэй агаад доллар нь мэдээж нохойноос хавьгүй үнэтэй тул нохдыг яаравчлан худалдана.

Бэк болон хөллөгөөний бусад нохой Скагуэй хотод гуравхан өдөр амрахдаа туйлдаа хүртэл ядран цуцаж хүч тэнхээ нь харьсныг бүр ч тодорхой мэдэрчээ. Дөрөв дэх °дрийн өглөө нь хоёр америк хүн ирж нохдыг хөллөгөөтэй нь цуг бараг үнэгүй шахам худалдан авав.

Тэд бие биенээ Хэль, Чарльз гэж дуудна. Чарльз нь цайвар царайтай, нулимсанд дэвтэж хорчийсон гэлтэй өнгөгүй бөлцийсөн нүдтэй, унжуу уруулаа далдлах гэж зориуд идэрхэг маягаар мушгиралдуулсан урт өтгөн сахалтай, дунд зэргийн настай хүн ажээ. Хэль нь харахад арван ес, хорин настай бүсэндээ том кольт гар буу, анчны хутга зүүжээ. Сум дүүрэн бүс нь түүний гоёл хэдий ч нас залуу, хэрсүү суугаагүйг нь улам ч тодотгоно. Энэ хоёр хүн Умард нутгийн хатуу ширүүн бодит байдалд илт үл зохицох агаад чухамд юунд найдаж энд ирсэн нь тайлагдашгүй тааврын нэг байлаа.

Энэ хоёр хүн Засгийн газрын шууданчтай хэлэлцэн тохиролцож мөнгө өгөхийг Бэк хараад шотланд нутгийн хүн, бусад бүх хөтөч урьд нь Перро, Франсуа, дараа нь бусад олон хүн үүрд одсоны адил энэ удаа ч мөн алга болохоор завдан буйг ойлгов.

Шинэ эзэд нохдыг буудалласан газраа хөтлөн авчрахад энд ноёрхсон эмх замбараагүй байдал Бэкийн нүдэнд юуны түрүүнд содон тусав. Майхнаа дутуу босгоо орхичихсон, сав суулгаа угааж цэвэрлээгүй, эд юмс нь энд тэнд



хөглөрнө. Мерседес нэртэй бүсгүй байх нь Чарльзийн гэргий, Хэлийн дүү хийгээд товчоор хэлбэл ах дүүсээрээ аялж яваа улс ажээ.

Тэд нар майхнаа яаж буулгаж байгаа, чарганд эд юмсаа яаж ачиж байгааг хараад Бэкийн сэтгэл нэг л эвгүй болов. Тэд ихэд чамбай ажиллах боловч хайш яаш, болхи, нэг л биш ээ. Майхнаа эв хавгүй хуйлснаас байх ёстойгоосоо гурав дахин илүү зай эзлэв. Цагаан тугалган сав суулгаа цэвэрлэж угаасангүй ачлаа. Мерседес бүсгүй тэвдэн сандарч зөвлөөд ч байгаа юм уу ам хамхилгүй шулганан эрчүүддээ саад болно. Хувцас хунараа эмх замбараагүй чихсэн шуудайг чарганы өмнө хэсэгт тавихад Мерседес эсэргүүцэж хойд хэсэгт тавих нь зүйтэй гэж зөрнө. Тэгээд хэлснээр нь болгож юмсаа ачиж дууссаны бүр хойно гэнэт өнөөх шуудайд хийх ёстой зарим зүйлийг мартаад орхичихож заавал хийхээс өөр аргагүй гэж шаардаж тэр шуудайг нь гаргахаар дээр нь тавьсан юмсыг буулгана.

Зэргэлдээ майхнаас гарч ирсэн гурван эр тэднийг хэсэг харан зогсож хоорондоо нүдээ ирмэлцэн шоолно.

Тэднийг нэг нь:

- Та нар овоо ачаа бараатай юм аа, би зааж сургах гэсэн юм биш ээ, миний бодоход наад майхан чинь илүүдсэн юм биш үү гэж өгүүлэхэд:

- Больж үзье! гэж Мерседес бүсгүй уулга алдаад айсан байдалтай гарын алгаа хавсарч: - Майхнаа орчихвол би хаашаа харж, юугаа хийдэг байна аа! хэмээн дургүйцэн эсэргүүцэв.

- Урин хавар бараг боллоо, одоо даарна гэж айгаад байх юм алга гэж нөгөө гурван эрийн нэг нь сөргүүлэв.

Мерседес татгалзан толгой сэгсэрнэ. Чарльз, Хэл хоёр уул овоо шиг өндөр ачсан эд юмс дээр сүүлчийн боодлуудыг нэмэн тохно.

- Наад ноход чинь ийм хүнд ачааг чинь хөдөлгөж дөнгөнө гэж бодож байна уу?

- Яагаад үгүй гэж? хэмээн Чарльз тасалданги хоолойгоор дургүйцэв.

- За тийм дээ, би зүгээр л... гэжөнөөххүн үгээ буцаад:

- Ачаа чинь надад шалихгүй хүндэдсэн юм шиг санагдаад л... гэв.

Чарльз уурлаж ачаагаа бэхлэх сурыг их л хүч гарган эв хавгүй угз татаж чангалах агаад дадал, туршлага муутай нь илт харагдана.

- Дажгүй дажгүй, ноход энэ зэргийн ачааг чирч бүхэл өдөржин давхилгүй дээ гэж нөгөө гурван эрийн нэг нь өгөөднө.

- Мэдээж хэрэг! гэж Хэль хүйтнээр хариулаад нэг гартаа ташуур, нөгөө гартаа урт саваа мод барьж: - За урагшаа! гэж хашгираад ташуураа эргэлдүүлэв.

Ноход урагш зүтгэснээ дороо зогсчихов. Тэд хүнд ачаатай олон чаргыг хөдөлгөн чирэх байтугай байрнаас нь ч хөндийрүүлж чадсангүй.

- Залхуу амьтад! Та нарыг сайн хашраагаад өгье! гэж Хэль уурлан хашгирч ташуур далайж нохдыг шавхуурдахаар завдтал:

- Хэль боль чи! гэж Мерседес бүсгүй уулга алдаж ахынхаа гараас ташуурыг угз татан авч:

- Хөөрхий амьтдыг чи яах нь вэ! Ахин гар огт хүрэхгүй гэж амла! Эс тэгвэл би эндээс явахгүй! гэж сүрдүүлэв.

- Чи мөн заналхийлэв ээ! гэж Хэль зандарч: - Нохдыг яаж дуулгавартай болгодогийг мэддэг юм шиг, энэ залхуу амьтад ташуурын амтыгл ганцхан ойлгодог юм, мэдэв үү! Хэн гуай нь ч хэлээд өгнө, наадуулаасаа асуусан ч хэлээд өгнө, битгий саад бол, цаашаа холд! гэв.

Мерседес гурван эрийн зүг дэмжлэг хүссэн янзтай харав. Түүний цэвэрхэн царайд амьтдыг зовоож байгаа дургүйцсэн шинж илт тодрон.

- Наад ноход чинь хөл дээрээ дөнгөн данган зогсож байгааг хараач! Ядарч туйлдсан байна, хэсэг амрааж тэнхээ тамирыг нь сэргээвэл дээр биз дээ гэж нөгөө эрийг Мерседес рүү эгц ширтэн өгүүлэхэд Хэль зөрж:
- Юуны чинь амраах! Чөтгөр авмарууд! хэмээн хараав.

Түүнийг ийнхүү хараахад Мерседес дургүйцэн санаа алдав. Гэвч төрөл садангаа гэсэн сэтгэл нь дийлж:

- Энэний үгийг бүү сонс, өөрийн ноходтойгоо яаж харьцах нь чиний хэрэг гэж ахыгаа өмөөрөв.

Хэль нохдыг хайр найргүй ташуурдана. Ноход савраа дагтаршсан цасанд шигтгэн хэтрээг сунатал нь хүчлэн чангааж газарт наалдам алдан урагш зүтгэнэ. Гэвч чарганууд байрнаасаа үл хөдлөх ажээ. Ноход хоёр удаа урагш хүчлэн зүтгээд амьсгаадан зогслоо. Ташуур агаарт шунгинан исгэрэн бууна. Мерседес бүсгүй Бэкийн дэргэд сөхрөн сууж хүзүүгээр нь тэвэрч:

- Хөөрхий ноход минь! Та нар дахиад нэг олигтойхон зүтгээд үз л дээ, тэгвэл ингэж зовоохгүй шүү дээ! гэж нүдэндээ нулимс бөнжигнүүлэн өрөвдөн гуйна.

Бэк Мерседес бүсгүйд дургүйцнэ. Гэвч ядарч туйлдсандаа болоод дургүйцлээ илэрхийлэхийг хүссэнгүй. Эмэгтэй хүн өөрсдийг нь өмөөрч байгааг ч үл ойшооно.

Энэ явдлыг ажиглан зогссон гурван эрийн нэг нь шүд зуун дургүйцлээ барин байснаа тэссэнгүй ам нээж:

- Та нарын хэрэг надад падгүй л дээ, гэхдээ наад ноход чинь надад хайран байна, эдний зовлонг нимгэлье гэвэл эхлээд ингэ, наад чаргануудын чинь ул газартай наалдаж тас хөлдсөн байна, мөсийг нь ховхлон цохиод хоёр тийш нь сайн займчуулан хөдөлгө! гэж зөвлөв.

Ноход ахин урагш тэмүүлнэ. Нөгөөх хүний өгсөн зөвлөмжийг Хэль энэ удаа дуулгавартай хүлээн авч наалдсан мөсийг нь ховхолж гулсуурыг газраас хөндийрүүлэв. Хүнд ачаатай чарганууд алгуур гулсан хөдөлж Бэк болон бусад нохой ташуурын цохилтоос Дальдчин хамаг хүчээ шавхан арай чүү урагшилна.

Буудалласан газраас зуун ярд хиртэй яваад замын эргэлтээр тойрч тэндээс төв гудамж руу уруудсан замд

оров. Хүнд ачаатай хөллөгөөг тийм налуу замаар чадмаг залах нь туршлагатай хөтчийн ажил болохоос биш Хэль шиг хөнгөн, сагсуу залуугийн амжуулах хэрэг биш байлаа.

Замын эргэлт дээр чарганууд холбирон хажуулдаж сайн татаж чангалаагүй суран татлага сулран мултарч ачааны тэн хагас нь зам дагуу асгаран тарав. Ноход зогссонгүй, эрчээрээ давхиж хажуулдаж өнхөрсөн чарганууд тэдний араас дэвхцэн чирэгдэнэ. Хэрцгий ширүүн харьцаж хүнд ачаа чирүүлж зовоосонд дургүйцсэн ноход улам хурдална. Бэкийн хилэн бадарч байдгаараа хурдалж бусад нохой ч түүний араас давхина. "Зогс! Зогс!" гэж Хэлийн хашгирахыг ноход эс тоох ажээ. Хэль хальтран газар унахдаа хажуулдсан чаргануудын дор золтой л орж дайруулчихсангүй. Хөллөгөө Скагуэй хотын төв гудамжаар замын хоёр талаар ачаагаа цувруулан хурдлахыг харсан хүмүүс хөхрөлдөнө.

Тусч сэтгэлтэй хэдэн хүн хамжиж хөллөгөөг барин зогсоож чарганаас ойчсон эд юмсыг цуглуулж тусална. Доусон хот орохыг хүсвэл ачаагаа хоёр дахин хөнгөрүүлж нохдын тоог хоёр дахин нэмэх хэрэгтэй гэж хүмүүс Хэль, Чарльз хоёрт зөвлөнө. Хэль, Чарльз, Мерседес гурав хүмүүсийн зөвлөмжийг дуртай дургүй сонсон майхнаа босгож эд юмсаа янзална. Умард нутгийн барагдашгүй

урт замд аялагч бүрийн ганц хоол болох төмөр савтай олон консервийг хаяхад хүмүүс шоолон инээлдэнэ.

- Та нар чинь зочид буудалд ч хүрэлцэх олон ноосон бүтээлэгтэй юм шив дээ! гэж Хэль, Чарльз хоёрт тусалж байгаа хүмүүсийн нэг нь тэднийг ёжлон өгүүлээд:

- Хагасыг нь орхиосон ч илүүдэх юм байна, энд борлуулчихсан нь дээр биз дээ. Майхны ч хэрэггүй, сав суулга ч гэсэн дээ, замд хэн угааж цэвэрлэж байх юм бэ? Бурхан өршөө та нар чинь юу бодож сэтгэж явдаг улс вэ!

Зөөлөн вагонд тухлан сууж аялана гэж арай бодоогүй биз дээ?

Туршлагатай хүмүүсийн үгэнд орж тэд шаардлагагүй гэсэн эд юмсаа зоригтой орхино. Шуудайтай юмсаа газар нэлийтэл асгажхувцасхунар, гоёлын зүйлийг илүүчлэн чулуудахад Мерседес эхэр татан уйлна. Илүүчлэн хаях эд юмс бүрд тэр харамсан гашуудаж өвдгөө тэврэн сууж тайтгаршгүй зовлонд учирсан мэтдагжин чичирч тэр ч байтугай арван Чарльзийн төлөө ч эндээс явахгүй гэж үглэн заналхийлнэ. Тэгээд аргаа барьж нулимсаа арчаад аян замд зайлшгүй хэрэгтэй юмыг ч хүртэл илүүчлэн хаяв. Дараа нь ах, нөхөр хоёрынхоо эд юмсыг ялгаж багтартлаа уурласандаа ч гэх үү хуй салхи мэт ширүүн зоримог хөдөлнө. Удтал бөөн ажил болсны эцэст эд юмсынхаа талыг нь илүүчлэн хаясан боловч ачаа нь мөн л их хэвээр байв.

Үдэш Чарльз, Хэль хоёр ноход нэмж худалдан авахаар яваад нутгийн биш явуулын зургаан нохой хөтлөн ирэв. Одоо хөллөгөөндөө арван дөрвөн нохойтой болсон агаад зургаан л Перрогийн анхны хөллөгөөнийх, дээд амжилт тогтоосон ялалтын өмнө ирсэн Тик, Кун хоёр, нөгөө зургаа нь саяных ажээ.

Өнөөдөр авчирсан зургаан нохой, алсын замд явахад нэг л найдвартай биш харагдана. Гурав нь гөлгөр үстэй ангууч том пойнтер, нэг нь ньюфаундленд үүлдрийнх, нөгөө хоёр нь эрлийз нохой ажээ. Цөм туршлага тааруу ажээ. Бэк болон бусад нохой тэднийг зэвүүцэн ширтэнэ. Юу хийж болохгүйг Бэк тэдэнд мэдүүлж чадсан атлаа яаж ажиллах ёстойг сургаж дөнгөсөнгүй. Учир нь тэд хөллөгөөнд явах дургүй байлаа. Пойнтер, ньюфаундленд Үүлдрийн ноход Умард нутгийн бүдүүлэг хэцүү байдалд Дасаж чадахгүй сэтгэлээр унаж хатуу ширүүн харьцахаас голдоо ортол айж шантарчээ. Энэ хоёр үүлдрийн ноход сүнс нь зайлчихсан гэлтэй байнга айн бэмбэгнэж араг ясыг нь хэмхчин тастчиж эд бад хийхээр дайрсан ч эсэргүүцэн тэмцэх зориг, тэнхэлгүй ажээ.

Энэ хэдэн болхи нохой аян замын хүнд хүчрийг тэсвэрлэн туулж чадахгүй, хөллөгөөний хашир ноход хоёр мянга хагас бээр зам амралтгүй туулж тэнхээ тамираа барсан болохоор энэ удаагийн аян амжилттай болно гэсэн найдвар даан ч алга.

Гэтэл Хэль, Чарльз хоёрын сэтгэл хөөрч баярлана. Хөллөгөөндөө арван дөрвөн нохойтой гэдэг жирийн хэрэг биш болохоор баярлаж бахдалгүй яахав! Тэд Доусон давааг даваад буцан ирж байгаа хүмүүсийг бишгүй л харсан, гэхдээ арван дөрвөн нохойтой хөллөгөө хараагүй юм даг!

Гэтэл үнэн хэрэгтээ Арктик тивээр аялагчид алсын замд олон нохойн тэжээл ачиж явах төвөгтэй тул нэг хөллөгөөнд арван дөрвөн нохой оруулдаггүй юм байжээ. Эл учрыг Хэль, Чарльз хоёр огт гадарласангүй. Тэд алс замыг төчнөөн өдөрт туулна, хөллөгөөний өчнөөн нохойд төчнөөн хэмжээний тэжээл хүрэлцэнэ гэж цаасан дээр харандаагаар тооцоолжээ. Мерседес бүсгүй нөхрийнхөө мөр дээгүүр өнгийн харж харандааны үзүүр жирэлзэж бүх зүйл тов тодорхой ойлгомжтой байгаад зөвшин толгой дохино.

Маргааш нь өглөө нилээд оройтож Скагуэй хотын төв гудамжаар Бэк түүчээтэй урт хөллөгөө аян замд сунжран гарлаа. Алсын аяны өмнө тэнхээ тамираа сэлбээгүй ноход, Бэк ч бусад нохой ч ялгаагүй хүч чадлаа шавхан байвч хурдан урагшилж үл чадна, тэгж хурдан явахыг ч үл хүсэх ажээ.

Гашуун ус хэмээн газраас Бэк Доусон хот руу дөрвөн удаа ирж очиж байсан болохоор алсын тийм бэрх замыг

дайрч туйлдсан үедээ дахин туулах болсондоо багтартлаа уурлана. Бусад нохойн ч сэтгэл тавгүй ажээ. Хөллөгөөнд сая ирсэн ноход бүхнээс айн эмээж туршлагатай, хэрсүү ноход шинэ эзэддээ үл итгэнэ.

Энэ хоёр эр, бүсгүйд найдаж хэрхэвч болохгүй гэдгийг Бэк зөнгөөрөө мэдрэв. Тэдний хийж чаддаг юм гэж бараг үгүй, тэгээд ч юм сурахгүй гэдэг нь өдөр өнгөрөх тутам бүр тодорхой мэдэгдэнэ. Тэд юманд гар хүрэхээрээ дандаа хам хум хийнэ, дэгжурам сахилга гэдгийг мэдэхгүй ажээ. Үдэш болмогцхоноглох газар сонгон мунгинажудна, өглөө нь замд гарах гэж бараг өдрийн талыг авчихна. Чарганд эд юмсаа эмх замбараагүй ачдагаас өдөржин зам зуур байсхийгээд л зогсон саатаж ачаагаа янзалж цэгцлэхчээн аядан үнэт цагийг хоосон алдана. Заримдаа өдөрт арван бээр ч явж барахгүй, тэр ч бүү хэл буудалласан газартаа өнжсөн удаа ч бий. Умард нутагт өдрийн дундаж гэж тооцдог замын хагасыг ядаж ганц өдөр ч атугай явж байсангүй.

Аян замд гарсны анхны өдөр л Хэль, Чарльз нарын ноходод авсан тэжээл хүрэлцэхгүй гэдэг нь тодорхой болов. Тэд нохдыг өдөрт хэт хооллож байснаар сүйрлийг улам наашлуулав. Байнга өлсөж бага идэж гол зогоож дасаагүй шинэ нохдын ховдгийг яана. Нутгийн ноход ядран цуцаж удаан явж байгааг Хэль хоол нь багадаж гэж бодоод орцыг хоёр дахин нэмэв.

Түүнээс гадна Мерседес бүсгүй нүдэндээ нулимс мэлтэлзүүлэн нохдыг илүү сайн хооллохыг хоолойгоо чичрүүлэн Хэлээс гуйж гувшин үгийг нь тоохгүй болохоор загас хулгайлж нохдыг нууцаар хооллоно. Гэтэл Бэк болон бусад нохой хоол ундны хажуугаар хэсэг ч атугай амрахыг <sup>х</sup>Үсч байлаа. Ноход хэдий түргэн яваагүй ч гэсэн ачааны хүндэд тэнхээ тамираа барна.

Удсангүй өлсөх гэдэг зовлон нэмэгдэв. Аян замын дөнгөж дөрөвний нэгийг яваад байхад ноходод авсан тэжээлийн барагтал хувь нь идэгдсэнийг Хэль нэгэн өдөр мэдэж гайхав.

Энэ нутагт тэнгэр тулсан үнэ амлаад ч тэжээл олдохгүй. Хэль бодож бодож өдрийн хоолны орцыг багасгаж хурдаа нэмэх нь зүйтэй гэж шийдэв. Дүү, хадам ах хоёр нь түүний саналыг дэмжив. Хөллөгөөний ачаа дэндүү хүнд, хөтөч нар туршлага муутайгаас Хэлийн шийдвэр олигтой үр дүнд хүрсэнгүй. Нохдын хоолны орцыг багасгах хялбархан атал тэдний явалтыг хурдасгах гэдэг нь санасан зоргоор бүтэх ажил биш байлаа. Тэрчилэн эзэд нь өглөөд удтал мунгинасаар замд оройтож гарч бөөн цаг алдана. Энэ гурав нохдоо жинхэнэ ёсоор халамжилж захирч чаддаггүй, өөрсдөө ч дэг журам сахидаггүй улс ажээ.

Хамгийн түрүүнд Даб амь тавив. Дандаа баригдаж шийтгүүлж явдаг тэр хулгайч нохой дажгүй давхидаг байлаа. Дал нь мултарчихаад байхад нь барьж оруулаад хөллөгөөнөөс хэсэг чөлөөлж амраагаагүйгээс болж биеийн байдал нь дордсоор эцэст нь Хэль түүнийг том кольт гар буугаар буудаж дуусгав.

Умард нутгийн хүмүүс өөр газраас ирсэн нохдыг нутгийн ноход шиг үзэж өлчир тэжээж нэмэгдэл хоол өгөхгүй байвал тэд дорхноо өлсгөлөн тураалд орж амь тавьдагийг мэднэ. Тэгтэл Хэль тэр хатуу сургамжийг мэдэхгүй учраас нутгийн ноходод ногддог орцыг хоёр дахин багасгасан тул нөгөө зургаан нохой нүд анихад хүрэв. Эхлээд нь юфаундленд, дараа нь нөгөө гурван ангууч нохой

цувран амь тавив. Тэдний хоёр нь амьд явахын төлөө хичнээн ч зүтгээд барсангүй, бас цааш харлаа.

Энэ үед гурван аялагч маань Өмнөд нутгийн боловсон эрхэмсэг зангаа бүр умартлаа. Арктик нутгаар аялах хөөрүү мөрөөдөл нь талаар өнгөрч бодит байдал төсөөлж байснаас нь дэндүү хатуу хүтүү гэдгийг энэ насандаа мартаггүйгээр ойлгожээ.

Мерседес бүсгүй нохдыг хайрлан өрөвдөж уйлдагаа больж гагцхүү өөрийгөө зэмлэн буруутгаж нөхөр, ах хоёрыгоо төнхөн дандаа хэрүүл өдөж явдаг болов. Тэд маргалдаж хэрэлдэж дуусахгүй ажээ. Аян замын зовлон зүдгүүрт цухалдан уурлацгаана. Умард нутгийн аяны алдарт замд аян замын хүнд хүчир хөдөлмөр, барагдашгүй гачигдал, зүдрэлийг тэвчээртэй нэр төртэй даван туулахад нь тустай өгөөмөр тусархаг сэтгэл, бие биендээ гүн халамж тавих тэр эрхэм сайхан чанаруудыг энэ хоёр эр, бүсгүй гурав эзэмшиж чадсангүй. Бэкийн шинэ эзэд хүлээцтэй байх гэдгийг ер мэдэхгүй ажээ. Тэд хүйтэнд дандаа дагжин чичрэнэ, булчин шөрмөс нь байнга янгинан өвдөнө. Өглөөнөөс үдэш болтол тасралтгүй хэрэлдэж мэддэг хорон муухай үгээрээ бие биенээ доромжлон цаашлуулна.

Мерседес бүсгүйг сая нэг хэрэлдэхээ болиход нөгөө хоёр нь хоорондоо шөргөөлцөж эхэлнэ. Ажлын голыг би нугалж байна гэж хэн хэн нь бодож тэр бодлоо сав л хийвэл тоочин нөгөө рүүгээ давшилна. Мерседес нэг нөхрөө нэг ахаа өмөөрч гэр бүлийн маргаан, хэрүүл үл тасрана. Жишээ нь Чарльз, Хэль хоёрын аль нэг нь түүдэг асаах гишүү мөчир түүж авчрах болоход л даруй хэрүүл гарч хэдэн мянган бээрийн тэртээд байгаа бүх хамаатан садан, <sup>3</sup>Цэг эх, үеэл ах эгч болон аль хэдийнээ ертөнцийн мөнх бусыг үзсэн хүмүүсийн ясыг өндөлзүүлнэ.

Ер нь Хэлийн урлагт хандах үзэл бодол эсвэл нагац ахынх нь бичсэн жүжиг, түүдэг ноцоох мөчир түүж Цуглуулахын хооронд ямар учир холбоотой болох нь эс ойлгогдоно. Байнгын хэрүүл маргаанд Чарльзийн улс төрийн үзэл бодол мөн холилдон хутгалдана. Чарльзийн аманцар эгч болон Юкон голын эрэг дээр түүдэг гал асаахын хооронд ямар уялдаа холбоо байгаа нь үл тайлагдах оньсого мэт ажээ. Үүний учрыг энэ сэдвийг ам хамхихгүй тайлбарлах Мерседес бүсгүй л мэдэж байгаа юм болов уу даа. Авааль нөхрийнхөө төрөл садангийнхны олон зан аашийг ичиж зовохгүй муулан шууд давшлахыг нь яана. Ийнхүү цэц булаацалдсаар түүдэг галаа асааж чадалгүй, хоноглох бэлтгэлээ хийж амжилгүй, нохдоо ч хооллосон юмгүй өнгөрөөнө.

Мерседест чухам эмэгтэй хүний хувьд аян замын энэ хэцүү нөхцөл байдалд дургүйцэн зэвүүцэх бас нэг онцгой шалтгаан байв. Тэр нь юу гэвэл царайлаг, эрх дураараа, уян наалинхай ааштай, эрчүүд өөрт нь сээтэн хаяж эелдэг зөөлөн харьцдагтдасчихжээ. Гэтэл ах, нөхөр хоёр нь түүнтэй бүдүүлэг ширүүн харьцаж байгаа нь гайхшийг нь төрүүлнэ.

Бүсгүй хүний дорой зөөлөн зангаараа Мерседес бүхнийг халхавчлахыг оролдох нь Чарльз, Хэль хоёрын дургүйцлийг хүргэнэ. Гэвч эмэгтэй хүний нандин эрх дархын эсрэг аливаа халдлагыг Мерседес эсэргүүцэж тэгснээрээ хамт яваа хүмүүсийнхээ сэтгэлийг бүр ч зовооно. Ядарч цуцан биеэ дандаа чагнаж явдгаас түмэн өвчинд баригдсан мэт нохдыг хайрлахгүй ямагт чарган дээр хэвтэж явна. Энэ эрх танхил, булбарай хөөрхөн бүсгүй зуун хорин фунт жинтэй агаад тамирдаж цуцсан, өлмөн цөлмөн нохдын тээж яваа ачаанд чамлалтгүй нэмэлт болох ажээ. Мерседес өдөржингөө чарган дээр байх агаад гагцхүү ноход тамирдан зогсоход л сая нэг чарганаас аргагүйн эрхээр бууна. Чарганаас

бууж цанаар яваач хэмээн Чарльз, Хэль хоёрыг ятган гуйхад Мерседес хариуд нь эхэр татан уйлж ширүүн харьцлаа гэж гомдоллоно.

Эрчүүд нэгэн удаа түүнийг чарганаас хүчээр буулгаад дараа нь амаа барин гэмшиж хойшид ийм оролдлого дахин хийж болохгүй гэдгийг ягштал ойлгожээ. Мерседес бүсгүй айлын эрх хүүхэд шиг маяглаж зориуд догонцон хэд алхаснаа газар суучихаад явсангүй. Эрчүүд холдон явахад суусаар л хоцорчээ. Тэд гурван бээр хиртэй яваад буцан ирж ачаагаа хөнгөлөн байж түүнийг чарган дээр хүчээр шахам суулгажээ.

Энэ гурван хүн өөрсдийнхөө зовж зүдэрч байгааг л ихэд тооцож нохдын ядран цуцахыг юман чинээ тоохгүй ажээ. Хатуужил бол амьтан бүхэнд зайлшгүй хэрэгтэй чанар гэж Хэль үздэг боловч энэ баримтлалаа бусдад л хамааралтайд тооцно. Эхлээд энэ талаар нөгөө хоёрыгоо номлох гэж үзээд алдсан боловч үр дүнд хүрсэнгүй учир нохдоо бороохойгоор түншдэг болжээ.

Тавин хуруу хэмээх газар хүрч ирэхэд нохдын тэжээл нь дуусав. Анчны урт хутганы хамт Хэлийн бүсийг чимж явсан кольт хийцийн гар бугаараа нэгэн индиан эмгэнээс хэдэн фунт адууны хөлдсөн арьс сольж авав. Хагас жилийн өмнө өлбөрч үхсэн адууны арьсыг тэжээл гэх даанч хэцүү юм. Хахир хүйтэнд хөлдөж төмөр мэт хатуу болсон арьсыг харангалсан ноход арайхийн зулгаан гол орохчоон болно. Амт шимт ч гэж алга, ходоодонд орсон хойноо ч шингэхгүй ихэд зовооно.

Бэк энэ аяны хатуу хүтүүг шүд зуун тэвчиж хөллөгөөний манлайд сажлан явж-хүч тэнхээгээ шавхан ачааг чирч тэнхээ тамир нь барагдахад өөрөө ч мэдэлгүй дороо ойчин удтал хэвтэнэ. Тэгээд бороохой, ташуурын тасралтгүй цохилтыг тэсвэрлэхийн аргагүй болоход л сая өндийнө.

Саглагар өтгөн үс нь шороо даахинд баригдан өнгө зүсээ алдаж Хэлийн тушаарын тоймгүй олон цохилтоос арьс нь энд тэндээ хэгзрэн цус шүүрэн хатжээ. Хүчирхэг булчин нь орооцолдсон олс мэт болж турж эцэн энд тэндээ хуниралдсан арьсны нь цаанаас хавирганы яс нь хэрзийжээ. Энэ бүхэн хэний ч атугай зүрхийг мохоохоор боловч хэдэн жилийн тэртээ улаан цамцтай эрийн лавтай ойлгож мэдсэнээр Бэкийн зүрх юунд ч мохошгүй, дийлдэшгүй ажээ.

Хөллөгөөний бусад нохой Бэкээс дээрдэх юм байсангүй, цөм сажлан гэлдэрсэн хэлхээтэй араг яс болон хувирчээ. Одоо Бэкийг оруулаад дөнгөж долоон нохой үлджээ. Тэд үнэхээр ядарч цуцан ташуур, бороохойгоор цохихыг ч мэдрэхээ больжээ. Дандаа занчуулсаар ташуур, бороохойны цохилтыг хэзээ ч билээ тийм юм хүртэж байлаа даа гэсэн шиг ер ажрахаа больжээ. Тэд амь тавих ойртсон амьтад, амьдралын гал цог нь унтарсан, шуудайд чихсэн мах яс шиг харагдана.

Түр буудаллаж хөллөгөөнөөс гаргахаас өмнө зам дээр дороо хүч алдран тэрийн хэвтэнэ. Амьдралын хийморь золбоо нь бүрмөсөн унтрачихав уу гэсэн бодол өөрийн эрхгүй төрнө. Ташуур, бороохойны цохилт тасралтгүй бууж эхлэхэд сая нэг амьдралын гал цог нь бадаг бүдэг сэргэх шиг болж өндийн босож хамаг хүчээ шавхан урагш зүтгэцгээнэ.

Сайхан зантай Билли нэгэн өдөр газар сунан хэвтээд ахин өндийсөнгүй. Хэль одоо гар буугүй тул түүний толгойд сүх буулган цааш харуулаад хөллөгөөнөөс чирэн гаргаж замаас зайлуулав. Бэк болон бусад нохой энэ явдлыг хараад мөн ийм хувь заяа биднийг хүлээж байна гэдгийг ойлгож орох байх газраа олж ядна. Дараа өдөр нь Кун амь тавьж тавуулхнаа үлдэв. Жо ядарч цуцсандаа болоод архиран давшилдагаа больж доголон Пайк залилж мэхэлдэгээ ч мартав бололтой. Ганц нүдтэй Соллекс үнэнч зүтгэсэн хэвээр авч тэнхээ тамир нь

харьж чаргануудыг чирч дийлдэхгүй болсондоо яахаа мэдэхгүй байж ядна. Энэ өвлийнх шиг алсын аянд урьд нь явж үзээгүй Тик туршлагагүйгээс болоод бусдаасаа илүү олон удаа зодуулжээ. Бэк хөллөгөөний түүчээ хэвээр боловч нохдоо удирдан захирах чадвараа бүрмөсөн алдаж дэг журам сахиулах гэж чармайхаа больж зөнд нь тавьжээ. Бэк хүч тэнхээ нь сульдсанаас урагш сохорсон мэт зөнгөөрөө л явж толгой нь дүйнгэтэн хөл нь дадсан заншлаар урагш алхалсаар байгаа учраас л замаас хазайж гарчихгүй явсаар буй ажээ. Хаврын сар гарсан боловч хүмүүс, ноход урин дулааныг үл мэдрэх ажээ. Өдөр өнгөрөх бүр нар улам эрт мандаж үдэш оройтож жаргадаг болжээ. Гурван цагт үүр цайж үдэш есөн цагт харанхуй нөмөрнө. Нар бүтэн өдөржин гийнэ. Өвлийн жихүүн нам гүм хаврын хөгжөөнт дуу шуугианаар аажим солигдоно. Сэргэжтэнхрэхийн баяр бахадлыг амссан газар нутаг өнгө төрхөө засна. Өвлийн олон сард амь хураасан мэт хөдөлгөөнгүй байсан бүхэн одоо сэргэж хөдөлгөөнд орлоо. Нарс модны шүүс тунарч улиас модод нахиагаа дэлгэж бут сөөг ногоон хучлагаа нөмөрчээ. Хүрэлзгэнэ шөнөжин цэр цэр дуугарч газраар гүйж мөлхөгч амьтан бүхэн өдөржин наранд ээн сүлжилдэнэ. Ойд ятуу шувууд бие биенээ дуудацгааж тоншуул мод тоншиж хэрэм мөчир дамжин үсрэн дүүлж ДУучин шувууд уянгалаг аясаа түгээж өмнө зүгээс аялан яваа зэрлэг нугаснууд агаар далавчаараа зүсэн сүрэг сүргээрээ гангар гунгар шулганалдан ниснэ.

Довцог бүрийг уруудан ус мурилзан урсаж үл харагдах олон горхины хоржигноон эргэн тойронд түгнэ. Орчин тойрны бүх зүйл гэсэж чимээ шуугиан тархаан хаврын эелдэг салхийг амдах мэт өөдөөс нь тэмүүлнэ. Юкон голын мөс нарны хурц илчинд гэснэ. Энд тэндгүй харз ус бий болж мөс тас няс дуугаран хагарч ан цав нь улам томорч хэсэг хэсгээрээ хагаран тасарч усанд далдарна. Хаврын урь орох тусам амьдрал сэргэж эрч хүчээ авч нар тааламжтай ээж урин зөөлөн салхи сэвэлзэн байхад хоёр эр, нэг эмэгтэй, ноход үхлийг амдах мэт сажлан явна.

Ноход унан тусан урагшилна. Мерседес байнга уйлж унжин чарганаас үл бууна. Хэлийн уур цээжиндээ багтаж ядан хараал зүхэл тавин явна. Чарльзийн бүлцийж хавдсан нүдэнд тайлагдашгүй гуниг тогтжээ.

Тэд ийнхүү явсаар Цагаан голын адагт байдаг Жон Торнтоны буудалласан газар хүрч ирлээ. Ноход амь тавьж буй мэт газар тэрийн хэвтэцгээв. Мерседес бүсгүй нулимсаа арчин Жон Торнтоныг ширтэнэ. Чарльз гуалин дээр бүх бие нь хөшсөн мэт аажим суулаа.

Хэль эхэлж ам нээв. Жон Торнтон хус модны тайрдсыг янзлан сүхний иш хийж суув. Тэрээр тавьсан асуултад ганц хоёр үгээр хариулж товч тодорхой зөвлөмж өгнө. Гэвч ийм хүмүүс хэлэн үг, өгсөн зөвлөмжийг нь ер тоохгүй, юман чинээ бодохгүй гэдгийг мэдэж байв.

- Одоо мөсөөр явах нь туйлын аюултай гэсэн Жон Торнтоны болгоомжлолыг Хэл эсэргүүцэж:

- Биднийг нааш гарахад зам муу, найдваргүй, яваад хэрэггүй гэж ам булаалдан зөвлөцгөөгөөд л байсан. Ядахдаа Цагаан гол ч хүрч дөнгөхгүй гэж гоочлоод муу ёрлоод, гэтэл бид ингээд хүрээд ирдэг байж! гэж бах нь ханасан янзтай ёжлон хэлэв.

- Та нарт зөв зөвлөмж өгчээ, мөдхөн цөн түрнэ, өдийд усан тэнэг л мөсөн замаар явах гэж муйхарлан зүтгэнэ дээ. Гэхдээ тийм хүмүүс дандаа азтай явдаг юм билээ. Шууд хэлэхэд би л хувьдаа Аляскийн хойгийн бүх алтны төлөө ч азаа туршихгүй дээ гэж Жон Торнтон сөргүүлэв.

- Үгүй ер та тэнэг биш л дээ гэж Хэль дургүйцсэнээ:

- Харин бид яаж ийгээд Доусон оччих байлгүй гээд ташуураа агаарт эргэлдүүлж: - Бэк бос за босоцгоо, урагшаа! гэж хашгирлаа.

Тэнэг хүмүүсийг тэнэг явдал үйлдэхээс нь авран хамгаалах гэж оролдоод нэмэргүй гэдгийг Торнтон сайн мэддэг учраас тэднийг тоож өндийж ч харсангүй, ажлаа хийсээр суув. Тэгээд ч хоёр гурван тэнэг зөрүүд хүн цааш харлаа гээд энэ уудам хорвоод байдал ямар өөрчлөгдөх бишдээ.

Гэтэл ноход хашгиран заналхийлэхийг үл хайхран хэвтсээр байна. Тэд зөвхөн зодуулж занчуулж байж л сая нэг босож чадахаар тийм байдалд аль хэдийнээ хүрсэн байлаа.

Хэль ташуураа агаарт эргэлдүүлж нохдыг хайр найргүй нүднэ. Жон Торнтон шүд зуун биеэ барина. Хамгийн түрүүнд Соллекс арай чарай өндийв. Дараа нь Тик, Жо хоёр өвдсөндөө гангиналдан босов. Пайк хамаг хүчээ шавхан босохыг оролдож урьд хоёр хөл дээрээ өндийснөө биеэ даалгүй ойчив. Тэгээд гурав дахь удаа сая өндийж хөл дээрээ тогтов.

Харин Бэк гангинаж гасалсангүй. Хөдөлгөөнгүй хэвтсээр байлаа. Ташуурын сур биенд нь хэдэнтээ халуу °ргиулан буусан боловч эсэргүүцэжархирсангүй. Торнтон Үг хэлэх гэж завдсанаа дуугарсангүй, түүний нүдэнд нулимс •"Үйлгэнэнэ. БэкийгХэль ташуурдан нүдсээр байлаа.

Торнтон босож байх суух газраа олж ядан хойш урагш алхана.

Бэк анх удаа захирагдахаас татгалзсанд Хэлийн уур шатжээ. Ташуураа газар шидээд гартаа бороохой авч Бэкийг цохиж гарлаа. Бэк боссонгүй. Тэр бусад нохойн адил бүх хүч тэнхээгээ шавхан байж босож чадах байсан хэдий ч зориуд хэвтсээр байлаа. Амдан буй үхлийн аюулыг зөн билгээрээ мэдэрчээ.

Хөллөгөө эрэг өөд мацан гарах үед үхэл хаяанд ирсэн юм шиг нэг л жигтэй сэтгэгдэл гэнэт төрж санаанаас нь гарахгүй зовоогоод байв. Өдөржин хөл доор нь нимгэн мөс бэмбэлзэн навталзаж эзэн нь одоо хөөж туугаад байгаа тэр замд энүүхэнд үхлийн аюул амдан буйг тэр лавтай мэдэрсэн юм шиг байлаа.Тэгээд боссонгүй.

Хүч тэнхээ нь тартагтаа тулж бороохойны цохилтыг бараг үл мэдэрнэ. Амьдралын хийморь золбоо, гал цог нь бөхөн унтрах мөч нь ирсэн мэт ажээ. Бүх бие нь бадайран суларч захирагдахаа болив. Цохилтыг мэдрэхээ больж өөрийг нь хайр найргүй занчиж байгааг бүүр түүр ойлгож байгаа ч өөрийг нь биш өрөөлийг л нүдэж байгаа юм шиг санагдана.

Жон Торнтон тэссэнгүй, гэнэт араатан амьтан архирах шиг аймшигтай хашгираад бороохой далайж байгаа хүн рүү дайрав. Цавчигдан унаж байгаа модонд даруулах мэт Хэль гэдэргээ саван унав. Мерседес бүсгүй уулга алдан орилов.

Чарльз нөгөө л гунигт харцаараа энэ бүгдийг мэлрэн нулимсаа арчихчаа болон сууна. Босох гээд биеэ даахгүй байлаа.

Жон Торнтон тайвшрахыг хичээн Бэкийг ширтэн зогсоно. Уур нь бадарснаас үг дуугарч үл чадна. Сая ам нээж:

- Энэ нохойд ахин гар хүрвэл би чамайг дор чинь цааш харуулчихна шүү! гэж заналхийлэв.

Хэл өндийн босож амнаас нь шүүрэх цусыг арчингаа.

- Наадахь чинь миний нохой, эндээс зайл эс тэгвэл чамайг нам буудчихна шүү, бид ямар ч байсан Доусон явна! гэж давшлав.

Гэвч Бэкийг Торнтон халхлан зогсоод "зайлан" холдохыг хүссэнгүй. Хэль бүснээсээ анчны урт хутгаа шүүрэн авав. Мерседес нэг чарлаж нэг уйлан



хөхөрч яг л галзуурсан юм шиг болчихов. Торнтон сүхний ишээр Хэлийн гарыг огцом оновчтой цохиж хутгыг алдуулав. Хэль хутгаа авах гэж бөхийсэн боловч гараа ахин цохиулаад ухрав. Торнтон хутгыг газраас авч Бэкийн хэтрээг огтлон таслав.

Хэлийн ямаан омог дарагдав. Тэгээд ч ухаан тавьсан дүүгээ ганхан найгахад түшин авав. Бэк мөдхөн амьсгаа хураана, одоо чарга чирч ямар чадах биш гэж Хэль бодоод энэ жигтэй нөхөртэй зууралдаад нэмэргүй гэж шийдэв.

Хэдэн минутын дараа гэхэд хөллөгөө эргээр уруудан бууж мөсөн замд оров. Холдох чаргануудын чахрааг Бэк сонсож толгойгоо өндийлгөж араас нь харна. Түүний байранд Пайк хамгийн голд нь Соллекс түүний хажууд Жо, Тик хоёр явна. Ноход догонцон урагшилна. Мерседес бүсгүй чарганд ачаан дээр цомцойтол суужээ. Хэль хөллөгөөний өмнө урт саваа гозолзуулан алхана. Чарльз хөллөгөөний ард дув дуугүй явна.

Тэдний араас ширтэн харсаар Бэк хоцров. Торнтон түүний дэргэд өвдөглөн сууж бахим чанга гараараа түүний биеийг болгоомжтой базлан яс нь хугарсан эсэхийг үзэв. Тэгээд нохой дэндүү их зодуур, нүдүүр үзэж өлссөнөөсөө болон турж эцсэнийг мэдлээ.

Энэ зуур хөллөгөө дөрөвний хагас бээр хиртэй холджээ. Хүн, нохой хоёр мөсөн замаар гулсан яваа хөллөгөөг харц салгалгүй ширтэнэ. Гэнэт чарганууд араараа дээш боссоноо нүхэнд ойчих шиг далдарч урт саваа агаарт гозолзов. Мерседес бүсгүйн чарлах сонсогдов. Чарльз эргэж эргийн зүг гүйсэн боловч хөл дор нь мөс цөмөрлөө. Хүмүүс, ноход цөм живжээ. Тэдний явж байсан газар харз ус л цэлэлзэж үзэгдэж мөсөн зам оргүй алга болжээ.

Жон Торнтон, Бэк хоёр бие биеийнхээ нүд уруу ширтэнэ.

- Хөөрхий минь дээ! гэж Жон Торнтоныг хэлэхэд Бэк хариуд нь гарыг нь долоов.

### **Зургаадугаар бүлэг** **Хүнд хайртай хэвээр байлаа.**

Бүр арванхоёрдугаар сард Жон Торнтоныг хөлөө хөлдөөхөд нөхөд нь түүнийг буудалласан газраа тайван байж эдгэрэг гэж амьжиргаанд хэрэгтэй бүх зүйлийг бэлтгэж орхиод Доусон хотод аваачих гуалин бэлтгэх газар уруу гол өгсөн явцгаажээ. Нохойг аврах тэр үедээ Торнтон багахан догонцож байсан агаад урин дулаан цаг болоход өвчин нь бүр эдгэрчээ. Бэк хаврын урт өдөр голын эрэг дээр ус үелзэн урсахыг харж шувуудын жиргэн шулганалдахыг чагнан тайван хэвтэнэ. Бие нь аажим тэнхэрнэ.

Гурван мянган бээр алсын замыг туулсны дараа ийнхүү тааваараа амрах юутай сайхан. Шарх сорви нь анин эдгэрч булчин шөрмөс нь чангарч овоо таргалж зүс царай орох бүр Бэк улам залхуурах болов.

Бэк төдийгүй Торнтон, бас Скит, Ник ноход цөм Доусон хот очих салчдыг хүлээж хийх ажилгүй зүгээр л байцгаана. Ирланд нутгийн сейтер үүлдрийн бяцхан биетэй Скит гичий Бэкэд дорхноо дасав. Ядарч зүдэрсэн Бекэд түүний энхрийлэл халамжийг эсэргүүцэх тэнхэл ч байсангүй. Скит өвчин, шархыг анагааж эмчлэх увидастай нохой ажээ. Тэрээр муур зулзагануудаа энхрийлэн долоодгийн адил Бэкийн шархыг долоож эмчилнэ. Скит өглөө бүр Бэкийн хоолой идэж дуусахыг хүлээж байгаад сайн дураар авсан үүргээ баяртай гүйцэтгэнэ. Нэг мэдэхнээ Торнтонд Бэк дасчихсан шигээ түүний анхаарал халамжинд бас дасчихав.

Мөрдөгч нохой, шотланд тайга нохой хоёроос төрсөн эрлийз Ниг нохой Бэкэд нөхөрсөг хэдий ч Скиттэй

харьцуулахад арай даруу хандана. Хөгжилтэй нүдтэй, сайхан сэтгэлтэй, лагс том биетэй, хар үстэй нохой ажээ.

Энэ ноход өөрт нь атаархаж эзэндээ дургүйцэхгүй байгаад Бэк гайхна. Торнтоны тусархаг сайхан сэтгэл, найрсаг зан аашийг тэд хуулан авсан мэт санагдана. Бэкийн биеийн байдал сайжрахын хирээр түүнийг хоёр нохой шуугиант ноцолдоондоо оролцуулдаг болж Торнтон ч тэсэж чадалгүй тэдэнтэй нийлж хамт хөгжилдөнө.

Бэк нэг мэдэхнээ бие нь сайжран тэнхэрч шинэ амьдралтай золгов. Амьдралдаа анх удаа жинхэнэ халамж, барагдашгүй энхрийлэл гэдгийг амсаж баярлана. Тэрээр Санта-Кларын нарлаг хөндийд Миллер шүүгчийнд байхдаа ч ийм гүн хайрыг хүртэж байгаагүй билээ. Анд хамт явж хээр талаар дагуулан хамт зугаалдаг байсан шүүгчийн хөвгүүдтэй найзархаг, бяцхан ач нартай нь хүндэтгэж өмгөөлсөн байдалтай харьцдаг, шүүгчтэй бол нэр төрөө хичээсэн нөхөрсөг харьцаатай байжээ. Гэтэл Жон Торнтон түүний сэтгэлийн угт хав дараастай байсан хүнийг ухаан жолоогүй, эргэлт буцалтгүй хайрлах чин хайрыг нь сэргээжээ.

Торнтон юуны өмнө амийг нь аварснаар Бэкийн эрхэм хүндэтгэлийг хүлээжээ. Энэ хүн нохойтой жинхэнэ эзний ёсоор чин стэгэлээсээ хүндэтгэн харьцана. Зарим хүн ашиг хонжоог л урьтал болгон нохойг анхаарч халамжилдаг бол Торнтон ямар ч атгаг хар санаагүй, эцэг хүн хүүхдээ хайрлан энхрийлдэг шиг нохойг мөн тэгж халамжлан асарна. Түүнээс гадна нохдоо элэгсэг дотно үгээр дандаа баярлуулж тэдэнтэй удтал элдвийг ярилцан хүүрнэнэ, тийм тоглоом шоглоом, яриа хөөрөөндөө өөрөө ч нохдоосоо дутуугүй баярлана.

Бэкийн толгойг Торнтон хоёр гараараа барьж Духанд нь духаа наалдуулан хоёр тийш нь савчуулах

дуртай агаад ингэхдээ давтан хэлэх элдэв хачин хочийг нь Бэк энхрийллийн үгс гэж хүлээн авна. Хараал зүхэл дүүрэн энэхүү ширүүнд энхрийлэлд Бэк дасаж үргэлж баярлаж хөөрөх бөгөөд Торнтон толгойг нь сэгсрэн хөдөлгөхөд цээжинд нь баяр талархал багтаж ядна. Тэгээд Торнтоныг холдоход хэлээ унжуулан инээмсэглэж дороо харайн дэвхцэх агаад ямар ч сайхан үгээр илэрхийлж боломгүй хүндэтгэл хайр харцанд нь тодорно.

Жон Торнтон өөрийг нь нүд цавчилгүй ширтэн зогсоо Бэкийг харж "Тэнгэр минь энэ нохойд хүнээс дутах юм алга, үнэхээр чин үнэнч анд юмаа, ярьж чаддаггүй нь л даан ч харамсалтай юм даа." гэж бодно.

Эзэндээ Бэк хайр талархлаа илэрхийлэхдээ заримдаа хэтрүүлчихнэ. Торнтоны гарыг шүднийхээ ор удтал арилахааргүй чанга хазчихна. Гэвч тийм тоглоом шоглоомыг өөрийнх нь хараал зүхэл дүүрэн энхрийллийг нь баясан хүлээн авдаг шиг тийм энхрийлэл гэж Торнтон үзнэ.

Эзнээ гэсэн хайраа Бэк заримдаа дув дуугүй илэрхийлэх нь сонин. Торнтон өөртэй нь тоглон наадаж сэгсчин эсвэл ярьж хөөрөхөд сэтгэл нь баяслаар дүүрэх хийгээд гэхдээ түүний анхаарал энхрийллийг хүртэх гэж ер оролдохгүй. Хэрэв Скит гичий Торнтоны гарт хоншоороо шургуулан өөрийг нь өхөөрдөн илтэл нь хамраа үрж Ниг эзэндээ наалдан том толгойгоо өвдөг дээр нь тавьж энхрийлэл хүртдэг бол Бэк шал өөр, хайр хүндэтгэлээ тэгж улайм цайм илэрхийлэхгүй.

Тэрбээр Торнтоны дэргэд царайг нь нүд цавчилгүй ширтэж түүнийг судалж буй аятай хэдэн ч цагаар харж залхууралгүй хэвтэнэ. Бэк эзнийхээ царайны агшин зуурын өөрчлөлтийг ч туйлын анхааралтай ажиглана. Заримдаа зайдуухан хэвтэж хажуугаас нь араас нь хөдөлгөөн бүрийг нь алсаас ширтэнэ. Хүн нохой ийнхүү дотно нөхөрлөж Торнтон өөрийг нь Бэк ширтэн буйг мэдэрч эргэн харж өөдөөс нь дув дуугүй харна. Тэгэхдээ хүн, нохой хар бие биенийхээ харцанд өөрсдийг нь эзэмдсэн нэг л сэтгэлийг уншина.

Бэк үхлийн аюулаас аврагдсаны дараа Торнтоныг удтал холдоход сэтгэл нь тавгүй болдог байв. Торнтоныг майхнаас гарч элдэв ажил төрөл амжуулаад буцаж орох хүртэл Бэк салахгүй дагана. Бэк Умард нутагт ирээд энд байнгын эзэн гэж ер байдаггүй, олонтаа солигддогийг мэдэх тул эхлээд Перро дараа нь шотланд хүн эгнэгт алга болсон шиг Торнтон бас явчих вий гэхээс ямагт айж эмээнэ. Тэр ч байтугай шөнө хар дарж зүүдлэн сэрж шөнийн жихүүн хүйтэнд дулаан хэвтрээсээ босож гадагшаа гарч майхны дэргэд очиж эзнийхээ амьсгалж байгааг удтал чагнан зогсоно.

Жон Торнтоныг гэсэн хайр нь Бэкэд угтаа соёлжих нөлөө үзүүлэх ёстой байтал Умард нутагт ирээд сэрсэн зэрлэг омгийнх нь зан авир арилсангүй. Хүний гал голомтыг дагаснаас гардаг чин үнэнч чанар Бэкэд шингээстэй авч зэрлэг араатны догшрол, хар санаа түүнд байсаар байх ажгуу.

Бэк нь урин дулаан Өмнөд нутгийн олон үе нь хүний гараар орсон нохой биш харин Жон Торнтоны түүдэг гал руу балар битүү ойгоос ирсэн эртний зэрлэг араатны удам байлаа. Тэрбээр Жон Торнтонд ихэд дассан тул түүнээс идэх зүйл хулгайлж зүрхлэхгүй мөртөө бусад хүний юмыг сэтгэл зовохгүй хулгайлна, тэгэхдээ араатны арга залиар ямар ч шийтгэлд өртөхгүй байж чадахыг яана.

Түүний бие, хоншоорт олон тулалдаанд оролцсоны сорви цөөнгүй агаад одоо ноходтой тулалдахдаа Урьдынхаасаа бүр илүү догшин ширүүн, самбаа заль гаргадаг болжээ. Скит, Ниг хоёр бол номхон дөлгөөн зантай, түүнээс гадна Торнтоны ноход учраас л Бэктэднийг хэмлэдэггүй байлаа. Харин өөр, ямар ч үүлдрийн ямар ч хүч тэнхээтэй нохой бай Бэкэд даруй захирагдах ёстой. Эс тэгвэл аюултай дайсантай үхэх сэхэхээ үзэх цуст тулалдаанд гарцаагүй хүрдэг байлаа.

Бэк бороохой, соёоны хуулийг ягштал ойлгосон хийгээд хэзээ ч хэнийг ч өөгшүүлдэггүй, өрсөлдөгчөө гарцаагүй дийлж устгахын тулд ухрах няцах гэдгийг ер мэдэхгүй ажээ. Энэ хатуу сургамжийг Шпиц цагдаагийн болон шуудан зөөгч зодоонч нохдоос баттай мэдэж авчээ. Бэк тулалдаанд нэг бол ялан дийлнэ, эсвэл шившигтэйгээр ялагдана, дайснаа өрөвдөх нь сул доройгийн шинж гэж үзнэ.

Балар цагийн зэрлэг араатнууд өрөвдөх, энэрэх гэдгийг огт мэдэхгүй, тийм сэтгэлийг аймхай хулчгарын шинж гэж тооцдог ажгуу. Өрөвдөн хайрлах сэтгэлдээ ганц удаа дийлдлээ гэхэд тэр нь засаршгүй алдаа болж гарцаагүй үхэлд хүргэнэ. Нэг бол дайснаа устгана, эсвэл өөрөө амь алдана, нэг бол

амтархан зооглоно, эсвэл өөрөө тастчуулан идүүлнэ гэсэн зэрлэг араатны хөдлөшгүй хууль бий. Энэхүү өнө эртнээс уламжлагдан ирсэн хатуу хуульд Бэк захирагдана.

Бэк бол одоо амьдарч байгаа цаг үе, өнөөгийн амьдралаас дэндүү ах ажээ. Түүнд өнгөрсөн, эдүгээ нэгдэж өнгөрсөн, эдүгээ үеийн дуу хоолой мөнхийн хүчит хэмнэл мэт ээлжлэн солигдох агаад энэ нь жилийн дөрвөн улирал бие биенээ гэнэт огцом өөрчилж байгаатай зүйрлэм ажээ.

Жон Торнтоны дэргэд түүдгийн хажууд хэвтэж байгаа өтгөн саглагар үстэй, цагаан соёотой, хэнхгэр цээжтэй нохойд хүний гарт дутуу сургагдсан авч зэрлэг нохдын мөн чанар хослон шингэжээ. Энэ мөн чанар нь түүнд улам ч тод илэрч санаа бодлыг нь залан чиглүүлж идэж байгаа махыг нь улам амтшуулж ууж байгаа усыг нь ховдоглон залгиулж сонсож байгаа зүйлийнх нь учрыг ойлгуулжхарлан буй балар битүүйн амьдралын шуугиан, чимээний учрыг тайлбарлан ухааруулна. Тэрчилэн бодол, тэмүүллийг нь захирч ямар хэрэг үйлдэхийг нь зааж унтаж байхад нь зэрэгцэн хэвтэж зүүд нойронд нь үзэгдэнэ.

Шал өөр амьдралын дуудлага Бэкийг зовоож хүмүүс тэдний аж төрөл өдөр өнгөрөх бүр анхаарлаас нь улам алслан холдоно. Балар битүү ойн гүнээс учир нь үл ойлгогдох тэгсэн хирнээ туйлын дотно танил дуудлага Бэкэд сонсогдож чагнах бүрийд энэ улалзан байгаа түүдгээс зугтааж ширэнгэ дотор далдарч алс хол давхин одох хязгааргүй хүсэл төрж яахаа мэдэхгүй болдог боллоо.

Бэк хаашаа ямар зорилгоор давхих билээ гэж ер бодсонгүй. Түүнд туйлын дотно сайх дуудлагыг эсэргүүцэх тэнхэл алга ажээ. Бэк ногоон хучлага битүү нөмөрсөн ойд орж хэний ч мөр урьд нь гараагүй газраар өөрөө ч учраа олохгүй давхисаар, гэнэт Жон Торнтоныг санаж буцан ирдэгбайв.

Гагцхүү Жон Торнтон л түүнийг тогтоон барьж байлаа. Бусад хүн Бэкийн хувьд байхгүйтэй адил. Замд тааралдсан аялагчид заримдаа түүнийг магтан шагшихад Бэк огт хайхрахгүй агаад хэн нэг нь шохоорхон биед нь гар хүрэхэд шууд босон холдоно.

Торнтоны анд Ганс, Пит хоёрыг удтал хүлээлгэсэн салаар ирэхэд Бэк анхандаа тэднийг ер анзаарахгүй байсан хийгээд дараа нь Торнтон тэдэнд дотно хандаж байгааг ажиглаж сая л тэдний байгааг нь, найрсаг харьцааг нь хишиг хайрлаж буй аятай хүлцэнгүй тэвчдэг болов. Ганс, Пит хоёр Жон Торнтоны адил сайхан сэтгэлтэй, дөлгөөн тайвуун, хурцхараатай, гадаа ганадаж хөдөө хөхөрч сурсан хүмүүс аж. Тэд Доусон хот очихоос бүр өмнө, мод бэлтгэж хураасан газрын тэнд хүчтэй ширүүн урсгалтай голд сал тавих үед Бэкийг сайн таньж мэджээ. Гэхдээ Ниг, Скит хоёрыг өөрсөддөө дасгасан шигээ түүнийг дасгаж чадсангүй.

Харин Жон Торнтонд бол улам илүү дасчээ. Зуны цагаар байнга нүүдэллэх үед нуруундаа ачаа тэгнэхийг Бэк ганцхан Торнтонд л зөвшөөрөх хийгээд түүний хэлсэн, тушаасан бүхнийг үг дуугүй биелүүлнэ.

Нэгэн удаа (Тэд салаар авчирсан модоо зарж хүнсний нөөцөө сэлбээд Доусон хотоос Танан голын эх өгсөж явж байх замд тэр хэрэг болжээ.) аянчид ёроолд нь чулуун талбай харагдах гурван зуун фут<sup>1</sup> эгц хавцал дээрх хадан байц дээр хоноглохоор буудаллажээ. Жон Торнтон хадан байцны захад Бэк хажууд нь сууж байв. Торнтонд жигтэй бодол төрж Ганс, Пит хоёрт хандаж дүрсгүйтээд үзье гэж өгүүлээд:

- Бэк үсрээд! гэж баруун гараараа эгц хадны ёроол руу заан тушаав.

Тэгээд хоромын дараа Бэкийгтэврэн зуурч, байцын ирмэг дээр тогтоон барив. Ганс, Пит хоёр тусалж байж хоеуланг нь аюулгүй газар холдууллаа. Бүгд тайвшран санаа алдацгаахад Пит хамгийн түрүүнд ам нээж:

- Энэ ч ёстой ер бусын юм аа! гэж хэллээ. Торнтон толгой сэгсэрч:  
- Үгүй дээ догь л хэрэг, гэхдээ аймшигтай гэдгийг та нарт хэлчихье! Энэ хавын үнэнч зангаас би заримдаа айх юм гэв.  
- Үнэн шүү, үүний дэргэд гээд Пит, Бэк уруу толгойгоороо зааж: - Чамд гар хүрэх хүн нь би л болохгүй юмсан гэж айсан байдалтай өгүүлжээ..  
- Би ч гэсэн мөн адил, бурханы нэрээр андгайлъя! гэж Ганс түүнийг дэмжив.  
Тэр жил Пит үнэн үг хэлснийг нотолсон явдал Серкл хотод болжээ.  
Хар санаатай, дураараа аашилдаг хар Бартон хэмээх хүн цайны газар нутгийн заншилтай танилцаж амжаагүй нэгэн хүнтэй хэрэлдэж зодолдоход Торнтон тусч сэтгэлдээ хөтлөгдөн тэднийг салгахаар оролджээ. Бэк буланд ердийнхөөрөө урд савраа дэрлэн хэвтэж эзнээ нүд салгахгүй ширтэнэ. Бартон гар далайж бүх хүчээрээ Торнтоныг цохив. Торнтон арагш савж лангууны хашлагаас барьж хөл дээрээ арай ядан тогтов.  
Цайны газар байсан бүх хүн энэ агшинд нохойны хуцалт ч биш архиралт ч биш харин зэрлэг араатны хүрхрэхийг сонсож хиртхийн айжээ.  
Бэк нүд ирмэхийн зуур агаарт сунан дүүлж Бартоны хоолой руу дайрав. Бартон зөнгөөрөө гараараа хоолойгоо хамгаалжамьхэлтрэв. Бэк түүнийг ш-; аь дээр унаган дарж гарт нь шиптэсэн соёогоо сугалж хоолойноос нь зуурахыг дахин завдав. Энэ удаа Бартон оновчтой хамгаалж чадсангүй. Бэк хүзүүнээс нь зуув. Хүмүүс ухасхийж нохойг хамжин холдуулав.  
Эмч Бартоны хүзүү, гараас гоожих цусыг тогтоон боож байхад Бэк аймшигтай архиран тэднийг тойрч Бартон руу дайрахыг хэдэнтээ завдсан боловч бороохойтой тулгаран буцав. Газар дээр нь болсон алтны эрэлчдийн хурлаас нохой эзнээ хамгаалан дайрсан нь зүйтэй гэсэн шалтгаанаар Бэкийг зөвтгөв. Энэ явдлын дараа Бэкийн алдар цуу Аляскийн хагас арлын бүх тосгон суурингаар түгэн тархав.  
Мөн тэр жилийн намар Бэк огтын өөр байдалд эзнээ бас нэг аварчээ. Гурван найз Дөчдөх бээр хэмээх голын нэгэн аюултай гармаар урт нарийхан завиа нөгөө эрэгт гаргах хэрэгтэй байлаа. Ганс, Пит хоёр эрэг дагуу явж модонд уяж тогтоосон олсыг татаж завины хурдыг сааруулна. Торнтон урт саваагаар завийг залж нөгөө хоёртой хашгирч чухам яахыг заана. Бэк эрэг дагуу завины харалдаа сандран гүйж эзнээ харц салгалгүй ширтэнэ.  
Гол руу түрэн орсон эргийн тэндэх уснаас ёрдойсон хэсэг хад руу завь ойртон ирэхэд Ганс олсыг суллан тавьж Торнтоныг урт саваагаар голын дунд хэсэг рүү завиа залах зуур гартаа олсны нэг үзүүрийг барьсан чигээрээ эрэгдагуу гүйж завь хадыг тойрон өнгөрөнгүүт татахаар бэлэн болгов Завь хадыг тойрон гаруутаа хүчит урсгалд дийлдэн эрчээрээ дайвалзан хурдлахад Ганс хурдыг сааруулах зорилгоор олсыг татсан боловч хэт огцом угзарчээ. Завь огцом угзралтад хажуулдан хөмөрч Торнтон усанд холбирон ойчиж ямар ч усчны гарч дийлэмгүй хүчит урсгалд дийлдэн урсав.  
Энэ мөчид Бэк гол руу үсрэн орж хөөсрөн эрчилсэн усаар гурван зуун ярд сэлж эзнээ гүйцэж Торнтоныг сүүлнээс нь шүүрэн атгамагц эргийн зүг хамаг хүчээ гарган самардав. Хүчит урсгалыг сөрөн сэлэх туйлын хэцүү учир аажуухан урагшилж байлаа. Асар том давалгаа мэт усан дотроос ёрдойсон хадыг хүчит урсгал шавхуурдан нүднэ.  
Гармын ойролцоо усны эргүүлэг мурилзан харагдаж Торнтон эрэг хүртэл сэлж амжихгүй нь тодорхой болов. Нэгэн хад мөргөж өөр нэг хад руу эрчээрээ шидэгдэн тэндээ тогтолгүй гурав дахь уруу нь шидэгдлээ. Тэгээд Бэкийн сүүлийг тавьж хадны хальтираамтгай үзүүрийг хоёр гараараа тэвэрч усны хүчит шуугиан дундуур:

- Бэк яв, цаашаа яв! гэж хашгирав.

Бэк усны урсгалд дийлдэж сөрөн сэлэх гээд бүтсэнгүй, эзнийхээ хашгирахыг сонсоод эцсийн удаа харах гэсэн аятай уснаас толгойгоо өргөн цухуйлгаж эргийн зүг дуулгавартай сэлэв. Бэкийн тэнхээ барагдаж ус залгин хахаж цацан тэр үед нь Ганс, Пит хоёр түүнийг уснаас татан гаргаж чадав.

Хүчит урсгалд байн байн нүдүүлэх хальтрам хадан дээр Торнтон цаанадаж гурав, дөрвөн минутаас илүү тогтон бяйж чадахгүйг Ганс, Пит хоёр ойлгож байлаа. Тэд голын дунд Торнтоны тогтон байгаа хаднаас нилээд дээгүүр газар руу эрэг дагуу гүйн очиж Бэкийг олсоор хөдөлгөөнд нь саад болохгүй, хоолойг нь шахан боочихгүйгээр хүлээд усанд тавив. Бэк урагш сунан хөвнө.

Гэнэт голын гол хэсэг рүү орчихов. Бэк алдаа гаргаснаа хожимдож ухаарчээ. Торнтон руу бараг дөхөж хэдхэн сэлэлтээр хүрчихээр ойрхон очсоноо хүчит урсгалд туугдан хажуугаар нь өнгөрчихөв.

Ганс сандарч олсыг угзран татав. Гэнэтийн огцом угзралтад Бэк самгардаж усанд живэн далдраад ахин цухуйсангүй. Ганс, Пит хоёр түүнийг эрэг дээр татаж гаргахад тэр бараг амьсгаагүй байв. Тэр хоёр Бэкийн гэдсэн дээр дарахад хамар амнаас нь ус годгодон гарна. Хиймэл амьсгал ч хийв. Бэк өндийн боссоноо биеэ даалгүй газар ойчив.

Торнтоны хашгирахыг тэр бүдэг сонсож хэлсэн үгийг нь ойлгоогүй боловч даруй туслахгүй бол амь осолдох нь гэдгийг ойлгов. Эзнийх нь дуу Бэкэд цахилгаан гүйдэл жирсхийх мэт нөлөөлж ухасхийн босож эрэг дагуу давхихад Ганс, Пит хоёр араас нь гүйнэ. Тэд Бэк анх ус руу орсон газарт ирэв.

Ганс, Пит хоёр Бэкийг ахин олсоор хүлэв. Бэк ус руу орж голын яг дунд хэсэг уруу чиглэн хөвнө. Бэк гаргасан алдаагаа дахин давтдаггүй ажээ. Ганс олсны нэг үзүүрээс барьж аажим аажмаар сулруулна. Бэк сэлсээр Торнтонтой бараг зэрэгцэн ирээд түүний зүг хурдан галт тэрэг шиг тэмүүлэн зүтгэв. Торнтон нохойгоо нүд салгахгүй ширтсээр, хүчит урсгалд туугдан өөрийг нь мөргөхөд хоёр гараараа саглагар үстэй хүзүүнээс нь тэврэн зүүгдэв. Ганс олсыг модны их биеийг тойруулан татна.

Бэк, Торнтон хоёр усанд живэн далдарч ус залгин хахаж цацан голын ёроолын чулуу, модны тайрдас мөргөн бие биенийхээ дээр доор орон гаран тэмүүлсээр эрэг дээр гарч ирлээ.

Торнтон сая ухаан ороход голын урсгалаар эрэг дээр хаягдсан гуалин элгээрээ хөндлөн дараад хэвтчихсэн. Ганс, Пит хоёр нурууг нь базлан дарж байлаа. Юуны түрүүнд Бэкийг нүдээрээ эрэхэд тэр нь үхсэн мэт хөдөлгөөнгүй хэвтэж дэргэд нь Ниг галсан хуцаж Скит хоншоор, аниастай нүдийг нь долоож байгаа харагдав. Ухаан орсон Торнтон биеэ хөндүүрлэхийг үл хайхран босож Бэкийн биеийг базлан үзэж хавирга нь гэмтсэн болохыг мэдэв.

- За тэгэхлээр бид энд үлдэхнээ гэж тэр зөрөх аргагүй шийдвэртэй өгүүлэв.

Бэкийн гэмтсэн хавирга эдгэрч явж чадах болтол нь тэд энд хэд хонов.

Тэр жилийн өвөл Бэк Доусон хотод тийм их баатарлаг биш гэхнээ гавъяа байгуулж алдар нь улам цуурайтав. Гавъяа байгуулсны нь ачаар одоохондоо алтны ганц ч эрэлчин хүрч чадаагүй байгаа алс бөглүү цэгт очих мөрөөдөл болсон аян хийхэд дутагдаад байсан тоног хэрэгслийг эзэд нь худалдан авав.

"Эльдорадо" цайны газар эрчүүд хайртай нохдоо ам булаалдан шагшин магтахаас бүх юм эхэлжээ. Нэр алдар нь цуурайтсан Бэк хүмүүсийн яриа хөөрөөний бай болж Торнтон хайртай нохойныхоо нэр төрийг шийдвэртэй өмөөрнө. Хагас цагийн дараа ярилцагчдын нэг нь нохой нь таван зуун фунт хүнд ачаатай чаргыг газраас хөндийрүүлж тэр ч байтугай чирч чадна гэж

сайрхахад нөгөө нь миний нохой зургаан зуун фунт ачаа, гуравдахь нь долоон зуун фунт ачаа чирч чаддаг гэж бие биенээ давах гэж маргалдана.

- Тэр юу ч биш, миний Бэк мянган фунт ачаатай чаргыг чирч чадна гэж Жон Торнтон санаандгүй ам алдчихав.

- Тэгээд тийм ачааг ядаж зуун ярд хөдөлгөж дөнгөх үү дээ? гэж нохойгоо долоон зуун фунт ачаатай чарга чирч чадна гэж зүтгээд байсан, алтны уурхайн эздийн нэг Мэттьюсон түүнийг ёжлов.

- Зуухан ярд газрыг ч яаж ийгээд явж дөнгөх байлгүй дээ гэж Жон Торнтон тайвуун хэлэв.

- За тийм байж гэж Мэттьюсон дуугараад бүгдэд сонсогдохоор:

- Тэгж яасан ч чадахгүй гэдгийг ои батлаад мянган доллараар мөрий тавьж байна гээд нутгийн хиам шиг алтны элс бүхий хүүдийг лангуун дээр шидэв.

Нэг ч хүн ам нээж дуугарсангүй. Торнтоны хэлсэн үгийг цөм л дэмий л онгирсон хэрэг гэж боджээ.

Торнтон царай нь халуун оргин улайхыг мэдэрч ийм үг яаж хэлж чадав аа гэж өөрөө ч гайхна. Бэк мянган фунт ачааг чирч дөнгөх болов уу? Хагас тонн гэсэн үг шүү дээ! Торнтон ийм тоо санаанд нь буухад цочирдон айлаа. Бэкийн хүч чадалд итгэдэг, ямар ч ачааг чирч чадна гэж бахархан боддог боловч шалган үзье гэж ганц ч удаа оролдоогүй ажээ. Тэгтэл одоо олон арван хүн өөрийг нь таг дуугүй ширтэн юу гэж хэлэхийг нь хүлээнэ! Ганс, Пит гурвуулаа мөнгөө нийлүүлээд ч мянган доллар хүрэхгүй шүүдээ.

-Энүүхэнд гадаа тус бүр нь тавин фунт жинтэй хорин шуудай гурил ачсан чарга байж л байна, одоо мөрийгөө үзсэн ч болно гэж Мэттьюсон түүний хорыг малтав.

Торнтон юу гэж хэлэхээ мэдэхгүй хариу дуугарсангүй, учраа олохгүй байгаа хүний дүр үзүүлж хүмүүсийг нүд гүйлгэн харна. Тэгээд эртний анд нутгийн баян Жим О'Брайен дээр харц нь тусахад шууд түүнд:

- Мянгыг зээлүүлээч! гэж шивгэнэн гуйв.

- Тэгье гэж Жим О'Брайен дуртайяа зөвшөөрч лангуун дээр Мэттьюсоны хүүдийний хажууд алтны элстэй хүүдий шидээд: - Жон чиний хавыг тийм ч хүч тэнхээтэй гэдэгт итгэхгүй байлаа ч гэсэн өгчихье гэв.

"Эльдорадо" цайны газар байсан бүх хүн онц сонирхолтой үзвэр сонирхохоор гадагш гарав. Хөзөр тоглон улайрсан хүмүүс ч зугаагаа орхиж бас даган гарлаа. Нэхий хувцастай хэдэн зуун хүн ачаатай чаргыг хагас тойрон хүрээлэв.

Мянган фунт хүнд гурил ачсан Мэттьюсоны чарга энд ирснээс хойш хоёр цаг гаруй нэг байрандаа байж (Халуун хүйтний хэмжүүрийн заалт тэгээс доош жаран хэмийг заана.) чарганы гулсуур дагтаршсан цасанд шигдэн хөлджээ. Мөрийд хорхойтой улс Бэк чаргыг хөдөлгөж яасан ч чадахгүй гэж хашгиралдаж мөрий хоёрыг харьцах нь нэг байх ёстой гэж ам бардам зөвлөнө.

Тэгтэл "чаргыг хөдөлгөх" гэдгийг хэрхэн ойлгох эсэх тухай жигтэй асуудал гарав. Чарганы улны мөсийг ховх цохин арилгаж газраас хөндийрүүлсний дараа л Бэк чаргыг чирч хөдөлгөнө гэж Торнтон тайлбарлана. Гэтэл Мэттьюсон эсэргүүцэж Бэк чаргыг чирч байж л газар наалдаж хөлдсөн чарганы гулсуурыг хөндийрүүлэх ёстой гэж зүтгэв. Ихэнх хүн Мэттьюсоны саналыг дэмжиж мөрийг гурвыг харьцах нэг болгох нь зүйтэй гэж шуугилдана.

Бэкийг гавъяа байгуулж чадна гэж баттай итгэх хүн ганц ч гарсангүй. Торнтон эргэж буцахааргүй хэцүү байдалд орсон нь хүн бүхэнд тодорхой байлаа. Шуудайтай гурил ачсан чарга цасан дээрцувран хэвтсэн хөллөгөөнийх нь арван

нохойг Торнтон харж зориг нь мошно. Мэттьюсон магнай хагартлаа баярлан хөөрч:

- Мөрийг гурвыг харьцах нэг болголоо! гэж хашгирч:

- Би дахин мянгыг нэмлээ! Торнтон, хоёулаа гар барьж батлачих уу даа? гэв.

Торнтоны царайд сэтгэлийг нь зовоосон түгшүүрэл арилж элдэв бодол тооцоог таягдаж тулалдааны уухайнаас бусдыг үл анхаардаг, бүтэхгүй хэмээх санааг үгүйсгэсэн цог жавхаа тодорно. Ганс, Пит хоёрыг дуудаж гурвуул мөнгөө нийлүүлэхэд дөнгөж хоёр зуун доллар болов. Сүүлийн үед тэдний ажил хэрэг бүтэмж муутай, энэ хоёр зуун доллар одоо гар дээр нь бэлэн байгаа бүх хөрөнгө нь ажээ. Гэвч тэд энэ хэдхэн доллараа Мэттьюсоны зургаан зуун долларын өөдөөс эргэлзэж тээнэгэлзэлгүй тавив.

Мэттьюсоны арван нохойг хөллөгөөнөөс суллаж оронд нь ганц Бэкийг оруулав. Эргэн тойрны хашгиралдаан шуугианд Бэкийн сэтгэл хөөрч Жон Торнтоны төлөө маш чухал хэрэг заавалчгүй бүтээх шаардлагатай юм байна гэдгийг зөн билгээрээ ухаарчээ.

Хүмүүс мах, шөл нь таарсан сайхан нохойг харж бахдан шагширна. Бэкийн хүч тэнхээ багтаж ядна. Түүний зуун тавин фунт жин нь цуцашгүй хүч чадлын зуун тавин фунт ажгуу. Өтгөн саглагар үс нь торго мэт гялалзаж сэрвээний үс нь тайван байхад нь азраганы дэлийг санагдуулж хөдлөхөд нь хүч тэнхээ идүүлсэнээс гэлтэй сортойн босож үсний нь сор болгонд хүч тэнхээ амтагдах мэт харагдана. Ханхар өргөн цээж, хүчит урд хоёр хөл нь бие цогцостой нь атаархам зохицсон агаад булчин шөрмөс нь зангиран төвийжээ. Хүмүүс дөхөн ойртож булчинг нь барьж үзээд төмөр мэт хатууг нь шагшина. Бэкийн эсрэг мөрий хоёрыг харьцах нэг болон багаслаа.

- Ноёнтоон, таны нохой байгалийн гайхамшигтай сайхан бүтээгдэхүүн байна гэж эндхийн шинэ баячуулын нэг Скукум-Бенча тэрүүхэндээ бувтнаж:

-Тэмцээний өмнө найман зуун доллар урьдчилгаа болгон өгье, ноёнтоон найман зуун доллар шүү! Яг одоо өгье чиний нохойг шууд авъя! гэж шууд тулгахад Торнтон толгой сэгсрэн татгалзаж Бэк рүү очив.

- Хүүе бүгд холдоцгоо! Тэмцээн шударга байх ёстой гэж Мэттьюсон дургүйцнэ.

Эргэн тойрон нам гүм болж мөрий хоёрыг харьцах нэг байх ёстой гэж хэдэн хүний маргалдах л сонсогдоно. Цугларсан бүх хүн Бэкийг хөллөгөөний гаргуун сайн нохой гэж үзэх боловч тус бүр нь тавин фунт жинтэй хорин шуудайг хараад ганц ч хүн түрүүвчээ хоосолж зүрхэлсэнгүй.

Торнтон сөхрөн сууж Бэкийн толгойг хоёр гараараа тэвэрч хацраа наав. Тэр өнөөдөр нохойтойгоо заншсан ёсоор тоглож наадсангүй, толгойг нь сэгсчин хөдөлгөсөнгүй, өхөөрдөн харааж зүхсэнгүй, харин чихэнд нь ямар нэгэн зүйл шивэглэнэ.

- Бэк миньчи ... надад хайртай бол ... надад хайртай бол ... гэж шивнэхэд Бэк тэвчээр алдаж яарснаас тэрүүхэндээ гангинав.

Хүмүүс тэр хоёрыг гайхан ширтэцгээнэ. Нэг л хачин жигтэй үзэгдэл ажээ. Торнтоныг өндийн босоход Бэк шүдээрээ гарыг нь зууж хэсэг байснаа алгуур, дургүй янзтай тавих нь эзэндээ хайртай гэдгээ илэрхийлж буй ажээ.

Торнтон арагш нилээд холдож:



- За Бэк! гэж дуугарав.

Бэк хөллөгөөний хэтрээг татаад дараа нь хэдэн ямх хиртэй суллав. Энэ нь түүний сурсан арга ажээ. Эргэн тойрны нам гүмийг эвдэж:

- Урагшаа! гэх Торнтоны дуу тод огцом хадав. Бэк баруун тийш бөхийж хэтрээг гэнэт огцом

чангааснаа дороо зогсчихов. Чарганы ачаа чичирч чарганы гулсуур дор мөс тас няс дуугарав.

- Ахиад! гэж Торнтон хашгирав.

Бэк энэ удаа зүүн тал руу чангаав. Тас няс хэмээх дуу улам чангарч чарга ганхаж чарганы гулсуур хажуу тийш хэдэн ямх хөдлөв. Ийнхүү дагтаршсан цасанд чарганы гулсуурыг хав барьж хөлдсөн мөс хагарчээ.

Хүмүүс амьсгаа хураан мэл гайхан ширтэцгээнэ.

- Одоо урагшаа!

Торнтоны тушаал гар буугаар буудаж өгсөн гарааны дохио мэт болж Бэк хэтрээг байдгаараа чангаан урагш тэмүүлнэ. Түүний бүх бие нь чангарч булчин шөрмөс нь төвийжээ. Тэрээр хэнхдэг цээжээрээ газар шүргэм алдаж толгойгоо сунгаж савраа дагтаршсан цасанд шигтгэн урагш тэмүүлнэ. Чарга ганхан чичирч хөдлөв. Бэкийн нэг хөл гэнэт хальрахад нэгэн хүн уулга алдав. Гэвч чарга зогссонгүй хөдөлсөөр эхлээд хагас ямх, дараа нь ямх ...

дараа нь ... хоёр ямх урагшлав. Чарга хөдөлсөөр хурдаа авмагц Бэк дажгүй чирэн явна.

Хэдхэн хоромын өмнө амьсгаа даран байсан хүмүүс сая сэтгэл тэнийж санаа алдацгаав. Торнтон чарганы араас Бэкэд хандан тасалданги хөгжилтэй хашгиран гүйнэ.

Зуун ярд газрыг хэмжин тэмдэглэж хураасан мод руу Бэкийг хүрч ирэхэд хүмүүс баярлалдан уухайлан хашгиралдана. Бэкийг хураасан модыг өнгөрч Торнтоны тушаалаар сая зогсоход хүмүүс улам ч чанга орилолдож малгай бээлийгээ дээш шиднэ. Мэттьюсон ч шагширч хашгирна. Хүмүүс сэтгэл нь хөөрсөндөө болоод дэргэд нь зогсох таних, танихгүй хүмүүсийн гарыг харилцан чанга чанга атгана.

Бэкийг өмнө Торнтон өвдөглөн сууж духанд нь духаа нааж сэгсрэн ганхуулна. Тэр хоёрыг хүмүүс тойрон шавна. Торнтон нохойгоо энхрийлэн, өрөвдөн удтал хараана.

- Ноёнтоон гайхамшигтай явдал! Нүдээрээ хараагүй бол итгэхгүй байсан даа! гэж баян Скукум-Бенча бувтнаж:

- Ноёнтоон би танд мянган доллар өгье эсвэл мянга хоёр зууг авах уу? гэж гуйв. Торнтон сая босоход хоёрыг хацрыг нь даган нулимс бөмбөрөн байгаа харагдана. Тэр, нулимсаа нуухыг ч оролдсонгүй.

- Үгүй ноёнтоон үгүй, хэдийг ч авахгүй, ноёнтоон та чөтгөр шулам руугаа тонил! Би ийм л зөвлөлгөө танд өгмөөр байна гэж Торнтон баян Скукум-Бенчад хэлэв. Бэкийг гараас нь хазахад Торнтон түүнийг ахин сэгсчин ганхуулна. Учрыг ойлгосон хүмүүс цөм тэдний нөхөрсөг чин сэтгэлийн яриа хөөрөөнд саад болохгүй гэсэн шиг холдов.

### **Долоодугаар бүлэг Цусан төрлийн дуудлагад захирагдав!**

Бэк тавхан минутын дотор Жон Торнтонд мянга зургаан зуун доллар олж өгчээ. Эзэн нь хамаг өр ширээ дарж анд нөхөдтэйгээ Умард зүг домог нь энэ нутгийн түүх адил хуучирсан хав дараастай алтны орд эрж олох аянд гарав. Тэр цуутай алтны ордны эрэлд олон хүн явсан боловч цөөнхид нь аз таарч зорьсон газраа

хүрсэн боловч бараг бүгд буцаж ирээгүй ажээ. Тэрхүү үлгэрийн баян алтны ордтой олон эмгэнэлт явдал холбоотой агаад тэр орд одоо хир нууцаа хадгалсан хэвээр байгаа юм. Тэрхүү алтны ордыг хэн анх нээснийг мэдэх хүн ганц ч байхгүй. Энэ тухай эрт дээр үеэс өнөөг хүртэл уламжлагдан ирсэн домогт ч дурсдаггүй. Тэрхүү алтны ордны буурин дээр эрт цагийн эвдэрхий овоохой бий гэж л ярьцгаана. Алтны зарим эрэлчин амьсгаа хураахын өмнө тэр овоохойг харсан, алтны ордыг олсон гэж батлан тангараглаж үнэнийг нотолж Умард нутагт урьд өмнө үзэгдээгүй цул шижир алт харуулдаг байжээ.

Гэвч энх тунх байгаа хүмүүсийн дотор тэрхүү үнэт сангаас хишиг хүрсэн хүн ганц ч үгүй, үхсэн хүн харсан зүйлээ, мэдсэн юмаа хэлж чадахгүй шүү дээ. Жон Торнтон. Ганс, Пит гурав Бэкээс гадна зургаан нохой хөлөглөж урьд нь нэг ч хүн, ганц ч нохой хүрч мөрөө үлдээж байгаагүй газар очих их зорилгыг өвөртлөн огт мэдэхгүй замаар Умард зүгийг зорив.

Тэд Юкон гол өгсөж долоон зуун бээр явж дараа нь зүүн тийш эргэж Стюарт голоор дайрч Мэйо, Мак-Квешен голыг гаталж аялалаа цааш үргэлжлүүлж Стюарт гол нарийссаар горхи болж хувирсан, энэ тив нутгийгхөндлөн зүсэх уулсын нурууны өндөр өндөр хад асгыг ороосон газартхүрчээ.

Жон Торнтон түүнтэй хамт явагчид нь байгалиас ихийг горьдож шаардахгүй агаад аглаг зэлүүд нутгаас ер айж эмээхгүй ажээ. Ата давс авч буу үүрээд балар ой руу орж удтал хэсэн явна. Нутгийн индиан хүмүүс шиг өлчир амьдарч хаашаа ч яарч тэвдэхгүй ан хийж хооллоно. Замд нь ангийн шувуу таарахгүй бол индиан хүн шиг тайвуун байж ангийн шувуутай золгоно гэсэн бат найдвар өвөртлөн алхана. Тэд Умарт нутгаар хийж байгаа хугацаагүй их аянд бэлтгэхдээ ан хийж хооллоно гэж тооцоолж зөвхөн тоног хэрэгсэл, буу зэвсэг, сум авч гарчээ.

Ан агнаж загас барьж огт мэдэхгүй нутгаар дураараа зугаалж хэрэн тэнүүчилж байгаа энэ амьдрал нь Бэкийн сэтгэлд нийцэх ажээ. Тэд хэд хоног зогсолтгүй явж дараа нь хаа нэгтээ буудаллаж бас хэдэн долоо хоногоор суурин байв. Тийм үед ноход хийх юмгүй, цаг нөгцөөх аргаа олж ядан байхад эзэд нь энд тэндгүй хөлдүү газар сэндчин ухаж хөрсний дээжийг авч алт байгаа эсэхийг үзэж түүдгийн дэргэд ховоонд угаан шүүнэ. Тэд зам зуур ангийн шувууд тааралдсан ан амжилттай болсноос шалтгаалан заримдаа ихэд өлсөж заримдаа цадталаа хооллоно. Зун болоход хүмүүс, ачаа тэгнэсэн ноход салаар олон нуур гол гаталж модны гол ухаж хонхойлгон хийсэн хэврэгхэн бяцхан завиар үл мэдэх олон голыг өгсөж уруудан аялалаа үргэлжлүүлнэ.

Олон сар өнгөрч аялагчид урьд нь хүний мөр огт гараагүй, гэхдээ өнөөх эвдэрхий овоохойн тухай домгоор бол хэзээ ч юм хүмүүс иж байсан зэлүүд бөглүү нутгаар хэрэн тэнүүчилсээр явлаа. Тэд олон гол горхи эх авсан уулсын нуруудыг давж нүдгүй цасан шуурганд нүдүүлж ч явав. Тэрчлэн гүн битүү ой, мөнх цасан уулсыг зааглах нөмөр газаргүй уулсын оргил дээр тасхийм хүйтэн жаварт чичрэн дагжиж ч байлаа.

Нар төөнөх тал хээрээр явж шумуулд хайр найргүй дээрэлхүүлж мөсөн уулсын нөмөрт идэж баршгүй гүзээлгэнэ, Өмнөд нутагт шүтээн болох цэцэгтэй гоо сайхнаараа энэ зэрэгцэх анхилуун цэцэг ч түүж ч явлаа. Хэзээ ч юм билээ ангийн шувууд ганганалдаж байсан нь лавтай, одоо бол зэвүүн хүйтэн салхи исгэрэн шуугисан, сүүдэр газраа ус нь тас хөлдсөн, эзэнгүйрсэн эргийг нь усан долгио гаслантайяа нүдсэн амьдралын ямар ч шинж тэмдэггүй, гуниг дүүрэн эл хуль нуруудын нутагт тэд намар болоход иржээ.

Тэд хоёр дахь өвлөө урьд энд ирсэн хүмүүсийн аль хэдийнээ арилсан мөрийг эрж тэнүүчилж явлаа. Нэгэн удаа балар ой дотор бараг үл мэдэгдэм болсон зөрөг замтай таарч тэр зөрөг зам нь энүүхэнд ойрхон байгаа өнөөх овоохойд хүргэх нь гэж боджээ. Гэтэл тэр зөрөг зам хаанаас хаа хүрдэг нь мэдэгдсэнгүй, хэн гэгч ямар зорилгоор гаргасан нь таавар болон үлдэв.

Дараагийн удаа улирах цагийн аясаар эвдэрч нурсан анчны овоохойтой тааралдаж ялзарч өгөршсөн хөнжлийн дороос Жон Торнтон урт голтой цахиур буу олов. Хүмүүс баруун хойд зүг рүү алтны эрэлд махран тэмүүлж байсан анхны жилүүдэд тийм бууг Гудзон булангийн пүүс үйлдвэрлэж байсныг тэр санав. Тэр үед тийм нэг цахиур буу нэг боодол минжний арьстай тэнцэж байжээ. Хэзээ ч юм энэ овоохойд амьдарч буугаа хөнжил дотроо орхисон хүний хэн болохыг гэрчлэх өөр юм гарсангүй.

Ахин хавар болж тэд удтал эрж хайсны үр дүнд өнөөх цуутай эвдэрхий овоохойг биш харин өргөн хөндийд ховооны ёроолд шар тос адил тунарах алт бүхий ордыг олжээ. Тэгээд гурван аялагч аялалаа зогсоов. Тэд өдөр бүр хэдэн мянган долларын үнэ хүрэх алтан элс, шижир алт тунгаан авч байлаа. Тэд өдөр өнжихгүй ажиллана.

Тунгаан шүүж авсан алтаа тус бүр нь тавин фунтийн багтаамжтай хандгайн арьсан хүүдийд хийж баглаад гацуур модны мөчир сүлжиж босгосон овоохойныхоо өмнө давхарлан хураана. Хүнд хүчир ажилд улайрсан хүмүүс цаг хугацаа харавсан сум мэт өнгөрөхийг ч үл анзаарна. Баялаг нь улам өссөөр байлаа.

Ноход Торнтоны буудсан ангийн шувуудыг хааяа очиж авчрахаас өөр хийх юмгүй гиеүрэн налайна. Бэк түүдгийн дэргэд олон цагаар бодлогошрон хэвтэнэ. Энэ үед нь богино хөлтэй, үслэг хүн дандаа санагдана. Бэк гал руу нүдээ онийлгон ширтэж оюун бодолдоо бүдэг бадаг санагдах өөр ертөнцөд тэр үслэг хүнтэй хамт тэнүүчлэн явна.

Тэрхүү өөр ертөнцөд нь айх эмээх сэтгэл ноёрхдог бололтой. Түүдгийн дэргэд өвдгөө хоёр гараараа тэврэн толгойгоо унжуулан унтаж байгаа үслэг хүн нэг л тавгүй сонор соргог байж нойрон дундаа байсхийн давхийн цочин сэрж пад харанхуй руу эмээн хараад галд мөчир нэмдгийг Бэк ажиглан мэдэв.

Хоёул тэнгисийн эргээр үслэг хүн дун түүж явна гэхэд тэрхүү хүн дунгийн доторхийг тэр дор нь ховх сорон идчихээд нүд нь энүүхэнд аюул отож байна уу гэлтэй тал бүр тийш хялалзаж аюул айсуй гэхэд ухасхийн зугтаахад бэлхэн байна. Бэк ой дотор үслэг хүний араас дагаж хоёул чимээ анир гаргахгүй явна. Хоёул ямагт болгоомжтой явж чих нь зэрэг сэртийн босож хамар нь зэрэг сортолзоно. Тэрхүү үслэг хүний сонор, мэдрэхүй Бэкийнхтэй адил соргог ажээ. Үслэг хүн газраар хурдан нүйдгийн адил модонд авиран дамжихдаа мөн түргэн шаламгай ажээ.

Тэрээр мөчир дамжиж заримдаа модны хоорондох арваас арван хоёр фут зайд агаарт чөлөөтэй нисэн дүүлэх нь гайхаш төрүүлнэ. Мөчрөөс гараараа зууран унтаж байгаа үслэг хүнийг модны ёроолд хамгаалан хонож байсан шөнө нь Бэкэд санагдана.

Үслэг хүн харагдах тэрхүү хий үзэгдэл нь балар харанхуй ойн гүнээс аль эртнээс даллан дуудсаар буй дуудлага байсан ажээ. Тэрхүү дуудлагыг сонсогдоход Бэкийн сэтгэл догдолж үл ойлгогдох хүсэл төрүүлнэ. Бэк байсхийн баясал, түгшүүрэл, тайлагдашгүй гунигт автана. Тэгээд хачин дуудлага сонсогдох ой уруу давхин далдарч тэр дуудлага бодитой барьцтай зүйл юм шиг баахан эрж заримдаа аяархан заримдаа уурлан цухалдан хуцна.

Бэк ойн хүйтэн хөвд, өвс өндөр ургасан газарт хоншоороо шааж удтал үнэртэж сэтгэл нь ханан тургина. Эсвээс хүчит шуурганд ойчсон модны ард отолтонд суугаа мэт чихээ сортойлгон нүдээ бүлтийлгэн ойн чимээг чагнаж хөдөлгөөн бүрийг харж хэдэн цагаар хэвтэнэ. Ийнхүү хэвтэхдээ амар заяа өгөхгүй зовоогоод байгаа өнөөх үл харагдах дуудлагыг амдан барихаар завдан байсан ч юм бил үү бүү мэд. Бэк энэ бүх үйлдлийг яах гэж хийгээд байгаагаа өөрөө ч үл ойлгоно. Тэр өөрөөс нь илүү хүчтэй, илүү эрх дархтай ямар нэгэн юманд захирагдах болов.

Бэк одоо юунд ч дийлдэшгүй зөн билгийн эрхшээлд оржээ. Заримдаа овоохойны дэргэд наранд ээн зүйрмэглэн хэвтэж байснаа гэнэт толгойгоо өндийлгөн чихээ сортойлгон ямар нэгэн чимээ хүчлэн чагнах мэт болсноо ухасхийн босож давхин холдсоор хэдэн цагаар ой дотор, хээр талаар тэнүүчилнэ. Тэрээр ширгэсэн голын голдрилоор давхиж ойн амьдралыг сонирхон ажиглах дуртай болов. Зүлэг дээр ихэмсэг алхаж далавчаа дэрвэн байн байн дүрсхийн нисэн бууж наадах ятууны сүргийг ажиглан Бэк өдөржингөө бутан дотор нуугдан хэвтэнэ.

Гэхдээ Бэк зуны шөнийн бүрэнхийд давхиж ойн нойрмог бөглүү чимээ анирыг чагнаж хүн ном уншиж байгаа адил элдэв чимээ, дүрсийг уншин ялган таньж сэрүүн байхад нь ч нойрон дунд нь ч ямагт сонсогдоод байгаа тэр дуудлагын нууцыг эрж явах маш их дуртай болжээ.

Бэк нэгэн удаа шөнө дунд гэнэт цохин сэрж өндийн нүдээ бүлтийлгэн агаар шуналтайяа залгив. Бүх биений нь үс сэрвийн босчээ. Ойн зүгээс өнөөх дуудлага урьдынхаас бүр тод сонсогдоно. Энэ бол хөллөгөөний нохдын хуцалт мөн ч юм шиг биш ч юм шиг санагдах ажээ. Энэ дуу эрт дээр үеэс сонссон, дотно танил мэт Бэкэд санагдана.

Хэдхэн харайн дүүлж нойрсон буй хотхоноос холдоод ойн зүг чимээ анир гаргалгүй давхив. Улилт ойрхон сонсогдоход тун болгоомжтой урагшилна. Бэк явсаар ойн төгөл рүү дөхөж модны ардаас сэмхэн харахад том биетэй туранхай чоно хоншоороо өргөн ульж байгаа үзэгдэнэ.

Бэк дороо хөдөлгөөнгүй зогсов. Гэтэл чоно сэжиг авч улихаа больж дайсан аль зүгт байгааг тодорхойлох зорилгоор агаар шиншин үнэртэнэ. Бэк бүх биеэ хөвчлөн сүүлээ сунган хөлөө туйлын болгоомжтой зөөн тавьж зөөлөн явсаар ойн төглөөс гарлаа. Түүний хөдөлгөөн бүрт заналхийлэл, түүний зэрэгцээ танилцъя гэсэн нөхөрсөг санал хослон илэрнэ. Ойн зэрлэг араатнууд чухам тэгж уулзан золгодог.

Тэгтэл чоно Бэкийг хармагц эргэн зугтав. Бэктүүнийг хөөж гүйцэх дийлдэшгүй хүсэлдээ хөтлөгдөн араас нь том том харайн давхина. Бэк чоныг дагасаар горхины ширгэсэн голдрилд гүйцэн ирэхэд өнөөх чоно битүү ширэнгэнд тулж цааш зугтах зам нь боогдов. Чоно сандран тэвдэж Жо болон бусад нохой мухардалд орохоор оцойн сууж соёогоо тачигнуулан архирдаг шиг аашлав.

Бэк уулгалан дайрсангүй, нөхөрсөг санаагаа илэрхийлэн түүнийг тойрлоо. Гэвч чоно биеэр Бэкээс бараг гурав дахин бага, намхан болохоор сэжигтэй хандаж айж буй нь илт. Чоно гэнэт ухасхийн хөөцөлдөөн дахин эхлэв. Бэк хөөсөөр чоныг заримдаа хаа нэгтээ мухардуулан шахахад чоно яаж ийгээд бултан зугтсаар байлаа. Турж эцэж нүднээс гарсан чоно учраас л Бэкэд амархан гүйцэгдээд байв. Чоно зугтан давхисаар, мөрдөн байгаа Бэкийг зэрэгцээд очмогц хажуу тийш огцом бултан зайлна.

Ийнхүү хөөцөлдөн давхисаар эцэст нь Бэкийн шургуу тэвчээр дийлэв. Чоно түүний гэмгүй санааг ойлгож дороо зогсон эргэж хоёул бие биенээ шиншин үнэрлэнэ. Тэд ийнхүү найрсаг харьцаа тогтоож араатан амьтад догшролоо нуун

байдгийн адил бие биенээсээ сэрэмжлэн тоглон наадна. Чоно цааш хөнгөн хатирч нэг тийшээгээ Бэкийг даган явахыг уриалж байгаагаа ойлгуулахыг оролдов.

Тэд харуй бүрэнхийгээр гол өгсөж эх авсан баргар уулаа тойрон урсаж байгаа уг голын хажуу хавцлаар явлаа. Дараа нь гол хоёр тийш салсан уулзвараар голын нөгөө эрэгт гарч хавцлын бэлээр доош уруудан тал руу бууж ойн дундуур давхив.

Олон цаг өнгөрч нар өндөрт мандав. Омог нэгтэнтэйгээ хамт зэрэгцэн нойрон дунд нь сэрүүн байхад нь дапласаар байгаа өнөөх дуудлагын зүгт явж байгаадаа Бэк баярлан бахадна. Балар эрт цагийн хачин жигтэй дурсамж сэтгэлд нь ургаж хий үзэгдэлд хэдий ч билээ талархан баярлаж байсны адил жигтэй дурсамжийг дуртайяа хүлээн авна. Үнэхээр ч энэ мөчид болж буй бүх үйл явдал нь бүдэг бадаг санагдаад байсан өнөөх, шал өөр ертөнцөд эрт дээр цагт мөн болж байжээ. Тэгэхэд өнөөдрийнх шиг цэнхэр тэнгэрийн дор хэний ч мөр гараагүй газраар сул чөлөөтэй давхиж байжээ.

Горхины дэргэд түр саатаж л ус уух үед Бэк сая эзнээ санаж дороо хөдөлгөөнгүй суув. Чоно ус уучихаад цааш хэсэг давхиснаа Бэкийг суусаар байгааг эргэн харж хүрч ирж хоншоорт нь хоншоороо нааж үрэх зэргээр хамт явахыг хүсэн шаардав. Тэгтэл Бэк босож буцан алгуур алхана. Чоно бараг бүтэн цаг зэрэгцэн давхиж тэрхүүхэндээ гангинана. Дараа нь аргаа барж оцойн сууж хоншоороо тэнгэр өөд өргөн улилаа. Бэкийг холдон явахад тэр гуниг, харуусал дүүрэн улилт удтал сонсогдсоор байв.

Жон Торнтоныг оройн хоолоо идэж байхад нь Бэк буцаж ирэв. Шууд л эзэн рүүгээ дүүлж хайр талархалдаа умбан эзнии нь нэрлэдэгээр "дүрсгүйтэж" газар унагаж нүүрийг нь долоож гарыг нь зөөлөн хазахад эзэн нь хариуд нь толгойг нь тэвэрч сэгсчин өхөөрдөн хараал урсгана.

Бэк бүтэн хоёр хоног хаашаа ч явсангүй, эзнээ нүд салгахгүй ширтэн дагасаар өнгөрөөв. Эзнээ өглөө алтны орд уруу очиж өдөржин ажиллаад буцан ирж хоолоо идэж үдэш хөнжилдө шурган унтаж үүрээр босохыг нь харсаар байв.

Ийнхүү хоёр хоног өнгөрөхөд балар ойн гүнээс сонсогдох өнөөх дуудлага Бэкийг урьдынхаас бүр илүү шаардангуй даллан дуудах болов. Уулсын цаад энгэрийн өргөн хөндий, балар битүү ойр төрөл нэгтэнтэйгээ зэрэгцэн хамт давхиж явсан нь түүний санаанаас ер гарахгүй, сэтгэл нь дахин тавгүйтнэ. Бэк байн байн ой руу очих хэдий ч төрөл нэгтэнтэйгээ дахин тааралдсангүй. Шөнийн уртад чих тавин чагнах авч өнөөх гуниглал дүүрэн улилт ер сонсогдохгүй байлаа.

Бэк хотхоноос хэд хоногоор алга болдог болж хаана ч хамаагүй унтана. Нэгэн удаа эртээдийн явсан голын уулзвараар гарч өнөөх балар ойд очиж төрөл нэгтнийхээ мөрийг бүтэн долоо хоног эрээд олсонгүй. Зам зуур барьсан ангаар өл залган хооллож зогсолтгүй давхисаар байлаа. Ингэхдээ ядарч цуцахгүй нь гайхалтай. Алс холын тэнгист цутгадаг том голоос хулд загас барьж бас голын ойролцоо хүрэн баавгайг цааш харуулав. Бэкийн адил загас барьж байсан баавгай шумуулд бариулан уур хилэн нь бадран яахаа мэдэхгүй ой уруу давхижээ. Үхэх сэхэхийн төлөө тэр ширүүн тулалдаанд Бэкэд хав дараастай байсан араатны заль нь буцалтгүй сэргэжээ. Хоёр хоногийн дараа баавгайг дийлсэн газартаа буцаж ирэхэд нь арваад зээх бэлэн олзыг нь хоорондоо булаацалдан зодолдож байв. Бэк тэдэн рүү дүүлэн дайрахад хоёр нь бултан зайлж амжсангүй баригдав.

Бэк амьдрахын тулд амьтай голтой болгоныг зөвхөн өөрийн хүч чадал, эрэлхэг зоригт найдаж ганцаараа, бусдын дэмжлэг туслалцаагүйгээр алж устгаж өрсөлдөгч бүрийг дийлж хүчтэй нь гагцхүү амьдрах эрх эдлэх тийм ертөнцийн улаан цусанд амташсан араатан болон хувирчээ. Багтаж ядан цалгих бяртэнхээ, хүч чадлаа мэдэрсэн нь өөрөөрөө бахархал сэтгэлийг нь төрүүлнэ. Бахархал нь түүний хөдөлгөөн болгонд булчин шөрмөс бүрийнх нь зангираа болгонд ялангуяа зан араншинд нь тод илэрнэ.

Тэрчилэн саглагар өтгөн зогдор, үсний нь өнгө зүсийг улам ч сайхан болгосон юм шиг байлаа. Хоншоор, нүдний нь дээрх хүрэн хүрэн бяцхан толбо цээжин доорх цагаан судал үсийг нь эс тооцвол нас бие гүйцсэн аварга том чононоос ялгагдах юм алга байлаа. Сенбернар үүлдрийн эцгээсээ хүдэр цогцос, чац бусад зүйлийг хоньч эхээсээ тэр өвлөн авчээ. Хоншоор нь чононых шиг урт боловч хамаагүй том, толгойны нь гавал яс өргөн мантгар хэдий ч хэлбэрээрээ яг чононыхыг санагдуулна.

Бэкэд чононы ов заль, зэрлэг араатны аюулт арга бааш төрөлхөөс заяасан төдийгүй хоньч нохойны саруул ухаан, сенбернар нохойны түргэн сэтгэлгээ хосолжээ. Энэ бүхэн нь амьдралын хатуу хүтүүг ханатал амсаж хуримтлуулсан туршлагатай нь нийлээд Бэкийг балар ой шугуйн ямар ч зэрлэг амьтнаас илүү аюул осолтой аймшигтай араатан болгожээ.

Зөвхөн түүхий улаан махаар хооллох энэ нохойны нас бие гүйцэж бяртэнхээ нь амтагдана. Торнтон саврыг нь илэхэд үсний нь ширхэг бүр нь соронзонт чанараа илрүүлж буй мэт шажигнана. Түүний бие цогцос, уураг тархины нь эс бүр, булчин шөрмөс бүр нь булгилан цалгиж бат авцалдаатай, нягт зохицолдолгоотой хөдлөх нь үнэхээр гайхамшигтай. Бэк харсан, сонссон бүхэндээ, хариу шаардсан үйлдэл бүрд агшин зуур цахилгаан гүйдэл мэт шаламгай хөдөлнө.

Умард нутгийн янз бүрийн үүлдрийн ноход гэнэтийн довтолгоог маш түргэн няцаадаг бол Бэк тэднээс хоёр дахин илүү түргэн хариу барина. Хөдөлгөөн ажиглаж чимээ анир сонсмогц бусад нохой юу билээ гэж эрэгцүүлэн байх зуур Бэк аль хэдийн учрыг олчихсон, товчоор хэлбэл нэгэн хоромд ухаарч шийдвэр гарган хөдөлсөн байдаг. Уг нь ухаарах, шийдвэрлэх, хөдлөх үйлдэл нь дараалан явагдах атал Бэкийн хувьд хоорондох хугацаа нь завсарлагагүй • нэгэн зэрэг тасралтгүй үргэлжилнэ. Зангирах булчин шөрмөс нь төвийж болд пүрш мэт гайхам түргэн, мадаггүй хөдөлнө. Цалгин бялхах амьдрал Бэкэд хүчит урсгал болон шингэсэн агаад энэ хүчит урсгал нь дийлдэшгүй тэмүүлэлдээ хөтлөгдөн бүх биеэр нь садран асгарч энэ хорвоог живүүлэх мэт ажээ.

Бэкийг хотхоноос ихэмсэг алхан холдож буйг хараад Жон Торнтон нэгэн удаа нөхөдөө хандан:

- Нарт хорвоод энүүн шиг нохой цорын ганц байгаа юм, өөр ийм нохой байхгүй! гэж бахдан өгүүлэхэд:

- Үнэхээр тийм шүү, байгалиас энэ нохойг цутгатал хэв нь хагарч дахин ер хэрэглэгдээгүй байх аа гэж Пит цэцэрхэв.

- Нээрээ тийм шүү, би ч мөн тэгж бодож байна гэж Ганс батлав.

Тэд Бэкийг хотхоноос холдон явахыг харж байснаас биш, ой руу орж хүний нүднээс далдармагц агшин зуур танигдашгүй өөрчлөгддөгийг нь харж байсангүй. Бэк ойд ормогц ихэмсэг догь алхаагаа таягдаж зэрлэг араатан болон хувирч моддын дундуур сүлжин муур мэт чимээ анир гаргахгүй, ойн түмэн сүүдэр дотор сүүдрээ бараг нуух шахам явна. Хаана л бол хаана байрлаж

могой шиг элгээрээ мөлхөж түүн шиг өрсөлдөгчөө гэнэдүүлэн дайрч устгаж чадна.

Ятууг үүр дотроос нь овжин базан чарлуулж татан гаргадаг, унтаж байгаа туулайг сэхээ өгөхгүй дарчихдаг, мод өөд авирах гээд хором хожимдсон жирхийг нисэлт дунд нь шүүрэн барьдаг ажээ. Усан дотор дураараа сэлгүүцэж явсан загас хүртэл түүнээс зугтан зайлж амждаггүй хийгээд усан хаалт босгон сэрэмжтэй ажиллаж буй минж ч үхлээс мултардаггүй аж. Бэк аливаа амьтныг зэрлэг хэрцгийгээр тамлахын төлөө биш чухамдаа цадтал хооллохын тулд алдаг. Зөвхөн гардаж алсан зүйлээ иднэ. Ан хийж явахад нь амьтдыг шоглон даажигнах хүсэл заримдаа төрнө. Тухайлбал хэрэм рүү сэм дөхөн очиж шүүрэн барих гэсэн дүр үзүүлээд айж сүнс нь зайлсан хэрэм мод өөд ухаан жолоогүй авиран дүүлэхийг нь харж баясна.

Намар болоход өвөл гайгүй хүйтэрдэг хөндийд өвөлжихөөр нүүдэллэж тааваараа яваа хандгайн сүрэг ойд зөндөө тааралдана. Бэк сүргээсээ тасарсан ходлыг олонтаа барьж идсэн ба арай том олз барьж дийлэх хүсэлд автаж нэгэн удаа ууланд горхины эхэнд тийм олзтой тулгарчээ. Тэр нь ойгоос нүүдэллэж яваа хориод хандгай байлаа. Сүргийн удирдагч нь зургаан футаас илүү өндөр, хүдэр том манж байв. Уул хилэн нь бадарсан энэ хандгайгаас илүү догшин өрсөлдөгч олох Бэкэд хэцүү байлаа. Хандгай арван дөрвөн салаа том эврээ дүнхийлгэн ганхуулж бяцхан нүдэнд нь уур хилэн нь бадрах агаад Бэкийг хармагц омог хилэн нь улам дүрэлзэж хүнгэнэтэл урамдана.

Хандгайн цээжинд өдтэй сум туялзан байх нь омог хилэн нь дүрэлзсэний шалтгаан байжээ. Эрт дээр цагт гөрөөчилж явсан төрөл нэгтнээсээ өвлөсөн зөн билэг нь юуны өмнө удирдагчийг нь сүргээс нь салгах хэрэгтэй гэсэн шийдвэрийг Бэкэд хэлж өгнө. Энэ бол туйлын хэцүү хэрэг байв.

Тэгээд Бэк манжийн чанх өмнө гарч тулалдаанд уриалж аварга том эвэр, оносон нэг цохилтоороо л улаан голыг нь тасалчих аймшигт туурай нь хүрэхээргүй аюулгүй зайд хуцан займчина. Хандгай, соёо нь ярзайсан энэ аймшигт амьтныг эврээрээ сүлбэн шидчих боломж гарахгүй байгаад хилэн омог нь шатна. Хандгай Бэк рүү байн байн дүүхэлзэн дайрсан боловч Бэк овжин бултан зайлж халз тулалдах бяр тэнхээ дутуу байгаа дүр үзүүлж тэгж хор шарыг нь улам бадрааж сүргээс нь аажмаар холдуулахыг оролдоно. Гэвч манжийг сүргээсээ багахан холдмогц хоёр гурван эр хандгай Бэк рүү хамсан довтолж шархадсан удирдагчдаа сүрэгтэйгээ нийлэх боломж олгоно.

Араатан амьтан болгонд жишээ нь аалзанд шүлсэн тор залхуурахгүй сүлжих, могойд биеэ цагираглуулж хэвтэх, ирвэсийг отолтонд олон цагаар чимээ аниргүй байхад нь туслах барагдашгүй онцгой тэвчээр байдаг. Араатан амьтад нэг нь нөгөөгөө дийлж хооллохын тулд гөрөөлж байхдаа бахдам хатуужил гаргадаг. Бэк тийм тэвчээр, хатуужлыг гаргаж хандгайн сүргийг саатуулан барьж залуу хандгайнуудыг басамжилж хотлоо дагуулсан сүндэсүүдийг айлгаж сүргийн удирдагчийнх нь ухааныг нь балартал хор шарыг нь малтана. Ийм байдал хагас өдөр үргэлжлэв.

Бэк хандгайн сүрэгт элдвээр заналхийлж тал бүрээс нь дайрч тойрч давхин хуулируулж удирдагч манжийг сүрэгтээ буцан нийлмэгц нь угсран довтолгон холдуулж тийм байдлаар мөрдүүлэгчдэд мөрдөгчөөс ямагт бага байдаг тэвчээрийг нь барна.

Нар тэнгэрийн хаяа тийш далдарч (Намар болж харуй бүрий эрт болж шөнө зургаан цаг үргэлжилнэ.) өдөр дуусах үед залуу хандгайнууд удирдагчдаа

туслахаар сүргээсээ тасран холдох нь улам цөөрөв. Өвөл ойртож хөндий рүү түргэн очиж суурьших хэрэгтэй атал энэ эцэж цуцахыг мэддэггүй амьтан хоргоогоод явуулдаггүй. Тэгээд ч аюул нийт сүрэгт биш харин ганц хөгшин манжид заналхийлж байгаа болохоор өөрийн амь хамгаас үнэтэй тул тэд хөгшин хандгайг золиосонд гаргахад бэлхэн ажээ.

Харуй бүрий болов. Манж толгойгоо гудайлган зогсож сүргээ, хайртай сүндсээ, хотлууд, хүч тэнхээгээрээ өөртөө захируулсан хандгайнуудыг холдон явахыг ширтэнэ. Нүдний нь өмнө өрөвдөх гэдгийг мэдэхгүй хурц соеогоо ярзайлгасан аймшигт амьтан бүртэлзэн явуулахгүй байгаа учраас сүргээсээ ганцаараа хоцров. Хагас тонн жинтэй тэмцэл гачигдлаар дүүрэн хатуу хүтүү амьдрал туулсан манж зангиран товолзсон том өвдөгт нь бараг хүрэхтэй үгүйтэй өндөртэй нэгэн амьтанд дийлдэн амиа алдах болжээ.

Хандгайн сүрэг удирдагчаа орхин одсон мөчөөс Бэк аманд нь бараг орох дөхсөн олзыг өдөржин, шөнөжин сахиж нэг ч минут тайван байлгасангүй. Модны навч, цагаан хус, бургасны дөнгөж цухуйсан найлзуур зулгаан идэх, гол гатлах үед ганц удаа ус балгах боломж ер гарахгүй байв. Хандгай цангаж гол нь харлана. Манж цөхрөнгөө барж заримдаа хамагбайдгаараа хурдлахад Бэк түүнийг зогсоох гэж оролдохгүй, зорьсон хэрэг нь бүтэмжтэй байгаад сэтгэл хангалуун мөрийг нь мөшгөн давхина. Манж сая нэг зогсоход Бэк ойролцоо нь газар хэвтэнэ. Тэгээд хандгайг өл зангах, цангаагаа тайлахыг оролдоход нь тухай бүр агсран дайрна.

Манж одоо олон салаа эвэртэй толгойгоо бөхийлгөн улам удаан сажлан алхана. Түүгээр ч барахгүй хоншоороо бараг газарт хүргэн чихээ унжуулан удтал зогсох зуур нь Бэк түр холдож ус ууж амарч амжина. Том цогцостой хандгайг хүндээр амьсгаадан улаан хэлээ унжуулан нүд салгахгүй ширтэн хэвтэхэд эргэн тойрны байдал цоо шинэ содон шинжтэй болсон юм шиг Бэкэд санагдана. Энэ ертөнцөд байдал цоо шинээр өөрчлөгдсөнийг тэр мэдрэв.

Хандгайн сүрэгтэй цугмар нэгэн амьтан сэм ирсэн мэт санагдаж үүнээс ой, ус, агаар цөм айж чичирч байх мэт санагдана. Энэ бүхнийг Бэк харж сонсож үнэрлэж бус, зөн билгээрээ мэдэрнэ. Тэрээр ямар нэгэн онцгой ер бусын юмс огт хараагүй, ер сонсоогүй мөртөө энэ ертөнцөд цоо шинэ өөрчлөлт гарсан, хаа нэгтээ хачин жигтэй амьтад хэсүүчлэн тэнэж байгааг мэдлээ. Тийм учраас одоогийн хэргээ дуусгачихаад дараа нь амьдран байгаа орчноо сайн судлахаар шийджээ.

Бэк дөрөвдэх хоногийн өглөө гэхэд хөгшин манжийг яаж ийгээд дийлэв. Бүтэн өдөржин, шөнөжин олзныхоо дэргэд байж цадталаа идэж ханатлаа унтаж тэрүүхэн хавьдаа хэсэн тэнүүчлэв. Амарч хүч тэнхээгээ сэлбэж сая л Торнтоныг санаж хөнгөн цогин буцав. Бэк замгүй үл таних газраар олон цаг луужингаар зэвсэглэсэн хүнтэй эн зэрэгцэхээр хотхоныг шууд чиглэн итгэл төгс явна.

Бэк зам зуур орчин тойронд шинэ зүйл, түгшүүрэл бий болсныг мэдрэв. Бүтэн зун хаа сайгүй байхдаа ажиглан мэдсэнээс нь шал өөр жигтэй амьдрал бий болжээ. Энэ бүхнийг Бэкэд зөн билэг нь биш харин шувуудын шулганалдаан, хэрэмнүүдийн яриа хөөрөө, салхины сэвэлзээ хэлж өгнө. Бэк хэдэнтээ зогтусан саатаж өглөөний тунгалаг агаарыг байн байн шуналтайяа үнэртэн шинжилж тийнхүү шинжилэхдээ өөрийг нь улам хурдан давхихыг шаардах тийм чимээг сонсох мэт санагдана. Нөмрөн айсуу эсвэл магад ч үгүй аль хэдийнээ болсон аюул сүйрлийн совин төрж сэтгэлийг нь шаналгана. Бэк өнөөх голын салаалсан хэсгээр гарч хотхон байрласан хөндий уруу уруудан буухдаа сэрэмжлэн улам чимээгүй явна.



Гурван бээр хиртэй давхиад шинэ мөртэй тулгармагц нурууны нь үс сэрвийн босов. Тэр мөр хотхон уруу, Жон Торнтон руу шууд чиглэжээ!

Бэк улам хурдалж бүр ч чимээ анир гаргахгүй давхина. Бүхий л мэдрэхүй нь хүчтэй ажиллаж бүгдийг нь нэгмөсөн биш ч гэлээ ихэнх зүйлийг өөрт нь хэлж өгч байгаа олон жижиг шинж тэмдгийг соргог мэдрэнэ. Одоо давхиж байгаа зөрөг замаар урьд нь үл таних хүмүүс явсныг үнэртэн мэдлээ. Эргэн тойрон битүү хүрээлэх ой нам гүм байдалдаа муу ёр зөгнөжээ. Шувууд жиргэн гангиналдахаа больж хэрэм зугтан нуугдсан гэлтэй. Ганц хэрэм л Бэкийг нүдэнд үзэгдсэн нь хуурай мөчрийн борлосон гадаргууд бяцхан бор биеэ хураан наалдан хэвтсэн байсан агаад тэр нь модны хаг шиг харагдаж байв.

Бэк сүүдэр газраар нүүдэллэх мэт хөнгөн, сэм хурдлан байснаа хоншоор нь ямар нэгэн гаднын хүчинд татагдах мэт хажуу тийш биеийг нь залав. Цоо шинэ содон үнэрийн зүг ойртон дөхөхөд Ниг бутан дотор үхсэн хэвтэж байв. Хоёр ташаанд нь өдтэй сум зоолттой байгаа нь тэр мөлхөн зугтсаар энд амь тавьсан бололтой.

Бэк цааш ахин зуун ярд яваад Торнтоны Доусон хотод байхдаа худалдаж авсан хөллөгөөний нохдын нэгтэй таарав. Тэр нохой зөрөг замын хажууд атиралдан хэвтэж байх нь ихэд шаналан зовж үхсэнийг нь илтгэнэ. Бэк зогсож саатсангүй, түүнийг тойрч цааш явав.

Хотхоны зүгээс нэг чангарах, нэг намдах чимээ бүдэг бадаг сонсогдох нь дууны нэгэн жигд хэмнэл адил дуулдана. Бэк элгээрээ мөлхсөөр ойн цавчаалд хүрч ирэхэд сор нь сэртийсэн үхэр зараа шиг олон суманд зэрэг сүлбүүлсэн Ганс доош харан хэвтэж байгаатай таарав. Энэ агшинд Бэк гацуур модны мөчир сүлжиж хийсэн овоохой байгаа зүгт харуут нурууны үс нь сэрвийн босож уур хилэн нь бадрав. Тэр өөрөө ч мэдэлгүй сүртэй догшин архирав. Омог хилэн нь амьдралд нь сүүлчийн удаа ов заль, саруул ухааныг нь давамгайлжээ. Үүний шалтгаан нь Жон Торнтоныг гэсэн аугаа их хайр байжээ.

Эвдэж нураасан овоохойг тойрон бүжиглэж наадаж буй индианчууд сунан дүүлэн айсуй, урьд нь огт үзэгдээгүй, сургийг нь ч сонсоогүй араатны аймшигт архиралтыг сонсонгуут мэл гайхав. Өшөө хонзон авах шуналд ухаан нь балартсан Бэк хуйларсан салхи мэт дүүлэн дайрав. Хамгийн ойр байгаа хүн рүү (Энэ нь омгийн удирдагч байжээ.) үсрэн бууж соёогоороо хоолойг нь хүү татав. Цус усан оргилуур мэт садран годгодов. Тэр индиан хүнийг үхэтхийн унамагц Бэк түүнд ахин гар хүрсэнгүй, шууд дахин нэг хүн рүү үсрэн дайрч хоолойг нь хүү татав. Бэк одоо юунд ч дийлдэшгүй юу ч түүнийг тогтоон барьшгүй болжээ.

Бэк сандран тэвдэж бужигнан бөөгнөрөх олон руу дайрч тал бүрээс нь исгэрэн буух өдтэй сумыг үл хайхран тастчин хядна. Бэк зүг бүр тийш аймаар түргэн үсрэн дүүлж балмагдан сандарсан индианчууд сум онилж тавих боловч түүнийг биш харин бие биенээ ононо. Нэгэн залуу анчин Бэк рүү жад шидсэн боловч оносонгүй, нөгөө нэг анчны цээжинд тусаж нэвт гарав. Энэ мөчид-аймшигт араатанд довтлуулан хядуулж байгаа индиан хүмүүс амь амиа хоохойлон аймшигт сүнс бидэн рүү дайрлаа гэж гуаглан чарлаж ой руу тархан зугтлаа.

Бэк модны хоорондуур буга мөрдөн тууж байгаа мэт индианчуудыг хөөн гүйцэж тастчин алсаар байгаа нь үнэхээр чөтгөрийн амилсан дүр мэт байлаа. Энэ өдөр улаан арьстнуудын хувьд үйл нь ирсэн өдөр болжээ. Ойр орчмын модоор нэг тархаж зөвхөн долоо хоногийн дараа л амьд үлдсэн нэг нь алсын хөндийд цугларч гарз хохирлоо бодож үзжээ.

Бэк индианчуудыг хөөсөөр удтал ядарч эзгүйрэн эл хуль болсон буудалдаа буцан ирэв. Гит давхарлан хучсан олон хөнжил дотроос сугарч амжилгүй алагдсан байв.

Жон Торнтоны эцсээ хүртэл тэмцсэнийг гэрчилсэн мөрийг Бэк үнэртэн шиншилсээр гүнзгий устай цөөрмийн эрэгт тулж зогсов. Эрэг дээр амьсгаа хураатлаа эзнээ орхиогүй үнэнч Скит нохойны толгой, урд хоёр савар нь усанд дүрээстэй үхсэн хэвтэнэ. Найгасан дүүрэн замагтай, алтны хүдэр угааснаас булингартсан энэ цөөрөм ёроолдоо байгаа бүхнийг далдалж чаддаг ажээ. Тэнд одоо Жон Торнтон үүрд нойрсож буй. Бэк эзнийхээ мөрийг цөөрмийн эрэгт хүргээд алдаж дороо зогслоо. Эргэж буцсан мөр олдсонгүй.

Бэк бүтэн өдөр цөөрмийн эрэг дээр сууж хотхоноор сэтгэл нь тайлагдашгүй шаналан тэнүүлчилж өнгөрөөв. Бэк үхэл гэж юу байдгийг мэддэг. Хүн хөдөлж алхахаа, үг хэлэхээ, уурлаж баярлахаа больж энэ ертөнцөөс эгнэгт алга болдог. Жон Торнтон үхсэн, дахин хэзээ ч эргэж ирэхгүй гэдгийг Бэк ойлгов. Бэкийн сэтгэл хямарч сэтгэлийн хоосрол нь өлсөж цангаж байгаатай адил боловч байнга зовоож ямар ч хоол идэж, унд уугаад тайлагдаггүй ажээ. Энэхүү сэтгэлийн хоосрол нь индианчуудын хүүрийг харан зогсох үед түр мартагдана. Тэр мөчид Бэкийн сэтгэлд аугаа их бахархал төрнө. Урьд нь ганц ч удаа ингэж баярлаж байсангүй. Тэр, хүнийг хамгийг эрхэм амьтныг бороохой, соёоны хуулиар дийлжээ. Хүүрүүдийг сониучирхан үнэртэнэ. Хүнийг алах тун амархан ажээ! Нохойтой тулалдан дийлж цааш харуулахаас ч бүр хялбархан! Хүмүүс нум сум, жад, бороохойгоор зэвсэглээгүй үедээ Бэктэй хүч чадлаар эн зэрэгцэж чадашгүй нь! Иймд хойшид гартаа нум сум, жад, бороохой бариагүй үед нь хүнээс айж эмээж хулчийх ямар ч хэрэггүй!

Шөнө болж ойн дээгүүр хавирган сар мэлтийн газар дэлхийг сүүн өнгөөр гийгүүлнэ. Бэк энэ шөнө цөөрмийн эрэг дээр харамсан гуниглан сууж байхдаа балар битүү ой дотор түүний хувьд цоо шинэ амьдрал байгааг тов тодорхой мэдрэв.

Өндийн босож чихээ сотойлгон агаар үнэртэнэ. Алсаас ганц чонын улилт бүдэг сонсогдсоноо дараа нь чонон сүргийн хоолой хоршсон улилт болон нэмэгдлээ. Улилт улам чангарсаар мөч тутам ойртоно. Бэк энэ улилтыг сэтгэлийнх нь угт хав дараастай байсан өнөөх дуудлага, нөгөө ертөнцөд хэдийд ч билээ сонсдог байснаа санав.

Бэк ил гарч чагнан зогсов. Энэ нь үнэхээр өнөөх дуудлага, хоолой хоршсон дуудлага яг мөн байлаа! Тэр дуудлага нь урьд өнөөдрийнх шиг шургуу, одооных шиг захирангуй даллан дуудаж байсангүй. Бэк энэ дуудлагад бүрэн захирагдахад бэлэн болов. Жон Торнтон үхэж хүний ертөнцтэй холбосон сүүлчийн хэлхээ холбоо эгнэгт тасарчээ. Одоо хүмүүс аж амьдрал, заншил журам, зан араншинтайгаа Бэкээс тасран оджээ.

Чонон сүрэг амьд олз гөрөөлж нүүдэллэж яваа хандгайн сүргийг индианчуудын адил мөрдөж балар ой дундуур, олон гол горхийг гатлан явсаар Бэкийн байгаа хөндийд иржээ. Чонон сүрэг сарны гэрэлд умбасан ойн төгөл рүү орон саарал урсгалаар гарч ирэхэд Бэк ойн төгөлийн голд баримал мэт хөдөлгөөнгүй зогсон хүлээж байлаа.

Энэхүү хөдөлгөөнгүй зогсоо хүдэр том цогцостой амьтныг хармагц чонон сүрэг хиртхийн цочиж дороо зогтусан хэсэг алмайран байснаа хамгийн зоригтой нь түүн рүү ухасхийн дайрав. Бэк нүд ирмэхийн зуур бултан зайлж сөрөн дайрч хүзүүний нугаламыг нь хүү татав. Бэк дороо хөдөлгөөнгүй зогсоход хажууд нь амь тавьж байгаа чоно тарчлан газар хөрвөнө. Гурван чоно Бэк уруу ээлжлэн довтолж хоолойгоо, хүзүүгээ уруулж цусаа гоожуулан ухрав.

Эцэст нь сүргээрээ Бэк рүү дайрав. Бусдаасаа түрүүлж түүнийг унагах гэсэн шуналдаа хөтлөгдсөн сүрэг бие биенээсээ өрсөлдөн үсрэн дүүлнэ. Гэвч Бэк гайхам овжин самбаатай тулалдаж хойд хоёр хөл дээрээ баттай тогтон зүг бүр

эргэлдэн соёо, савраараа угтаж тэдний зэрэг дайралтыг няцаана. Ар талаасаа дайруулахгүй гэж аргагүйн эрхэнд ухрав. Цөөрөм өнгөрч ширгэсэн голын голдрил хүртэл ухрав.

Дараа нь өндөр налуу газарт тулж ухарсаар эзэд нь алт тунгаан цэвэрлэхээр элс авсаар хонхойлсон гүнзгий ухаадсанд ирэв. Энд Бэк гурван талаасаа хамгаалалттай болж эгц урдаас нь довтолох чононуудын дайралтыг няцаана.

Бэк амжилттай тулалдаж чонон сүрэг хагас цагийн дараа гэхэд мэгдэн ухрав. Чонод хэлээ унжуулан хүндээр амьсгаадан зогсоно. Тэдний цагаан соёо сарны гэрэлд гялалзан үзэгдэнэ. Зарим нь толгойгоо өргөн чихээ сотойлгон хэвтэхэд зарим нь Бэкийг нүд салгахгүй ширтэн зогсоно. Бусад нь цөөрмийн уснаас ууна. Том биетэй, өлсөж гуриналсан нэгэн саарал чоно уриалгахан нөхөрсөг харьцах гэсэн санаагаа илт харуулж Бэк рүү болгоомжтой дөхнө. Бүтэн өдөр ой дотор хамт давхин явсан өнөөх цусан төрөлтөө Бэк сая танив. Чоно тэрүүхэндээ гангинахад Бэк хариуд нь мөн гангинаж ойртон ирэхэд хажигласангүй, бие биенээ үнэрлэнэ.

Дараа нь саяны тулалдаанд бүх бие нь гувруу болсон хөгшин чоно дөхөн ойртоход Бэк анхандаа соёогоо ярзайлган угтсанаа дорхноо бие биенээ үнэрлэн шинжив. Хөгшин чоно ийнхүү ёслол үйлдсэний дараа хоншоороо сарны зүг өргөж уртаар уянгалуулан улив. Бусад чоно ч дагалаа.

Олон шөнө сэтгэлийг нь зовоон шаналгасан өнөөх дуудлага энэ мөн болохыг Бэк таньж тэднийг дууриан сууж хамт улина. Тэд сая улихаа болиход Бэк хориглосон газраас ил гарав. Чонон сүрэг түүнийг хүрээлж зарим нь нөхөрсөг, зарим нь дайсагнан хандаж үнэртэн шиншилнэ. Чонон сүргийн удирдагч дахин улиад балар ойн гүн рүү

давхив. Бусад чоно хоолой нийлүүлэн ульж араас нь дагав. Бэк зэрлэг цусан төрөлтөнтэйгээ зэрэгцэн давхиж улина.

Ингээд Бэк нохойны тухай нуршуу туужаа дуусгаж байна.

Нилээд хэдэн жил өнгөрөхөд индианчууд чонон сүргийн өнгө зүс мэдэгдэхүйц өөрчлөгдсөнийг ажиглажээ. Толгой дээрээ, хоншоортой хүрэн хүрэн толботой, цээжиндээ цагаан судалтай чононууд үзэгдэх болов. Гэхдээ индианчуудын ярьдгаар хамгийн гайхалтай нь чонон сүргийг "Нохойн сүнс" толгойлж явдаг гэнэ. Ов заль ихтэй тэр нохойн сүнснээс индианчууд маш их айж эмээнэ. Хүйтэн өвөл нөөцөлсөн хүнсний зүйлийг нь хулгайлж хавханд орсон олзыг нь булааж нохдыг нь хэмлэн хяргаж тэр ч байтугай хамгийн зоригтой анчдаас ч үл эмээх ажээ. Дээрхээс илүү аймшигтай зүйлийг ч тэд ам дамжин ярьцгаана. Ойд ан гөрөөлөхөөр явсан анчид заримдаа буцан ирдэггүй, хожим нь мэдэхнээ хоолойгоо тас татуулаад амь осолдсон байдаг. Тэгж амь алдсан анчдын орчимд чононыхоос илүү том савартай араатны мөр цасан дээр тод гарсан байдаг. Индианчууд намар цагт хандгай гөрөөлөхөөр явахдаа нэгэн хөндийг холуур тойрон гардаг. Нохойн сүнс тэр хөндийд орогнодог болсон тухай яриа хөөрөө түүдэг галын дэргэд өрнөхөд бүсгүйчүүдийн сэтгэл гуниг харууслаар дүүрнэ.

Гэсэн ч зун цагт тэр аймшигт хөндийд ердөө л саглагар өтгөн, гялтганасан үстэй ганцхан чоно ирдэгийг хэн ч мэддэггүй байлаа. Тэр чоно балар битүү ойн гүнээс ирж хөндий уруу бууж ойн төгөлд очно. Тэнд үжирч илжирсэн хандгайн арьсан шуудайнууд байх агаад шуудайнаас садран асгарч газар нэлдээ тархсан алтны завсар сиймхийгээр нарнаас халхлам өндөр ургасан өвс ногоо найгана.

Өнөөх аймшигт чоно энд хүрч ирээд удтал бодлогошрон оцойн сууж хэсэг гунигтай ульж байгаад дараа нь буцан явдаг ажээ. Тэр чоно наашаа дандаа ганцаараа ирдэг бишээ. Өвлийн зэврүүн хүйтэн шөнө болоход олз хайж хөндий уруу бууж ирсэн чонон сүргийн манлайд тэр чоно явж байдаг. Тэрхүү аймшигт чоно сарны бүдэг гэрэлд Умард туйлын анивчих туяанд цусан төрлийнхөө сүргийг тэргүүлж энэ хорвоо идэр залуу байсан балар эрт үеийн дууг-чонон сүргийн дууг хоолой мэдэн цуурайтуулан давхиж явнам.

## **Гарчиг**

I бүлэг. Балар цагийн амьдралд эргэн очсон нь

II бүлэг. Бороохой, соёоны хууль

III бүлэг. Зэрлэг араатан сэргэн амилав.

IV бүлэг. Тэргүүлэхийн төлөө тэмцэлд ялан дийлэв.

V бүлэг. Аян замын хатуу хүтүүг тэвчээрлэн давсаар явна.

VI бүлэг. Хүнд хайртай хэвээр байлаа.

VII бүлэг. Цусан төрлийн дуудлагад захирагдав!